



Гашуун өвс
Зохиолч:Б.Явуухлан

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Солонго билээ... би...

Ижийгээс минь асгарсан

Улаан бороо...

Эцгийн минь зүрхийг

Норгож арилсны дараа

Голоо эгштэл хүлээсэн

Говь дээгүүр татсан...

Нарыг зургаа хэрчсэн тоонотой

Гэр дээгүүр татсан...

Намайг тэврэх гэж яарсан бүхний

Өвөр дээгүүр татсан...

Солонго билээ... би...

Эрхий ороох сур шиг

Хүний богинохон заяанд

Элбэг дутуу ялгаа нь үгүй

Амьдын эрээн зүүдэнд

Нэгэн үзүүр нь

Тэнгэрээс хөллөж

Нөгөө үзүүр нь

Газарт уллах

Зуурхан төдий татаад арилах

Зургийн алаг солонго билээ... би...

Хүн дээгүүр гишиглэсэн он жилүүдийн

Зуурын төдий босоо үзэгдэл

Хувилгаан бор газар хөх тэнгэрийн

Зугаа төдий хоосон чанар

Нумын бөгтрөг шиг болж ирээд

Чулуу жийж татсан

Нарны тал шиг болж ирээд

Цэцэг илж татсан

Оногдсон заяаныхаа ааг зорго дээгүүр

Олойртож татсан

Олдохгүй хоёр буурлынхаа булшин дээгүүр

Бөхийж татсан

Эхлэх үзүүр нь сүүнд дүрээстэй

Эцэслэх үзүүр нь нулимсанд дүрээстэй

Солонго билээ... би...

Монголын их хээр тал

(Аавынхаа дурсгалд)

Нар нартай чулуунууд нь

Дуулгын дүрсэнд тоглосон

Намар намрын өвс нь

Нумын дүрсэнд тоглосон

Монголын их хээр тал

Тогоруу нь буцсан нуурын хөндүүр арилаагүй байхад

Тоссон газар шороо томдсон аз төөрөг

Үр асахын тал...

Бухим шөнийн тэнгэрийг цэцэг гижигдэхэд

Буусан ододыг шигшин гэгээнд холих

Үүр цайхын тал...

Ерхөг сугартал цалалзсан салхи

Ердөө л хагасыг нь туулаад омог нь эцдэг

Салхи эцэхийн тал...

Туулай дэгдээтэй саран үүл зүсэн гулгаж

Туйлдаж дунд нь хээр хонон цонхийдог

Сар хэвтэхийн тал...

Хавтгайн ингэ хэвтээд босоход

Харганын толгойд нь өрөм дарайж үлддэг

Сүү дусахын тал...

Нуган нуган үрдээ “хаан” цус нь эргэж

Нулимсны нь горыг тайлж, эргээд урагтаа төрдөг

Сүнс эгэхийн тал...

Дээлээ томдтол Богд Чингис бага болж

Дэлхийн өмнө бохиноогүй өвдгөө нугалж мөргөсөн

Хаан сөгдөхийн тал...

Бусдад тэгтлээ заяахгүй энэ их талыг жийж төрсөн

үрд нь

Бурхан хүртэл атаархдаг

Хатан амаржихын тал...

Нар нартай чулуунууд нь

Дуулгын дүрсэнд тоглосон

Намар намрын өвс нь

Нумын дүрсэнд тоглосон

Монголын их хээр тал.

Чамаараа би зөндөөн гоёсон

(Ханьдаа)

Харахгүй өнгөрч чадахгүй

Харчуулын нүдэн дундуур туучиж

Халуун залуу үзэсгэлэнт охин чамайг

Хань минь болооч гэж гуйж

Хайрын зовлонгоор гоёсон

Чанад холын мөрөөдлөөр зүрхээ бялууруулж

Чамайгаа олсондоо нар өвөртлөн гялайж

Чандага дэгдэх шиг мэлс мэлс санаа алдан

Чамайгаа би холоос үхтлээ санаж

Санахын жаргалаар гоёсон

Балга балга инээдэнд чинь согтож

Балтай урууланд чинь зөгий шиг шигдэж

Хасын саран үүлэнд бүдэчсэн шөнөөр

Харц харцаа шатаан гэгээ татуулж

Чамаараа би зөндөө гоёсон

Галын ээлэнд алтан ургийг уяж

Газрын заяанд аралт тооныг өргөж

Бадмын цэцэг мэт суут ижий чамаар

Бавуугийн ганц хүү өөрийгөө

Ес болгож гоёсон

Үйрэн үйрэн эмтэрч

Үнэний чулууг дэрлэхдээ

Үйлийн үргүй сайн ханьтай хорвоог туулснаа

Үхэлд хүртэл гайхуулж

Чамаараа би гоёно...

Эдлэн

Үхэл бидэн хоёр

Эхийн тунамал дунд цуг үүссэн

Эсэнлэх тэр үүрээр цуг хашгирсан

Морины нуруунд

Хоёр талаас нь цуг ассан...

Айлд хоёулаа хамт бууж

Амрагийн уруулыг үхэл бид хоёр хувааж үнссэн

Зовлонгийн оромж миний толгой

Зоргоороо үхэлтэй дэр хувааж

Там диваажин хоёрын элч үхэл

Тал бие шиг минь хамт оршсон

Амьдын гал “аа” омгоороо

Үхлийг би дарладаг байсан

Алгуурхан тэр дотроос минь

Үгүй болоход минь дурладаг байсан

Би хэмээгч нэгэн бие

Бурхан чөтгөр хоёрын

Буйлж эзэгнэсэн эдлэн болсон

Намайг хүн болгож ургуулаад

Над дээр бас юм болгон тарьсан

Учрыг олохын дон над дээр ургасан

Ухаан ургасан

Урт амьдрахсан гэсэн тэнэг зөн ургасан

Үнэн сайхан ханийн өлмийд

Үхэж алдах хайр ургасан

Үрээ гэж санаа богшиж

Үйлээ эдлэх үүрэг ургасан

Хагацлын нулимстай жимс

Халуун сагсуу бодол ургасан

Хүнд байдаг юм болгоныг

Хүглийтэл над дээр тарьсан

Өөд болсны минь дараа

Өт мартахуй хоёр миний ургацыг хураана

Буруутай зөвгэй орчлонд би

Бурхан чөтгөр хоёрын эдлэн явсны

Мөнх, мөнх бус хоёрын

Мөчөөрхөл тэгээд дуусна

Үхэл-миний хамгийн хуучин хагацал

Үхэл-миний ижийдээ очих томилолт

Эх орон бид хоёр бие биендээ ирсэн

(Отчигин хүү Л.Санансэцэндээ)

Эх орон бид хоёр

Бие биенээдээ ирсэн...

Эх орон бид хоёр

Аавын гэрийн баруун хатавчинд

Амраг эхийн хормой дор уулзсан

Ээрч чарлах дуутай минь зөрөн

Цэцгийн салхи нь урсаж

Эх орон над руу ирсэн

Эхийн сүүтэй цуг

Цээжинд цутгаж

Эх орон над руу ирсэн

Өөдсийн чинээхэн зулбсага

Цустай холилдон эх орондоо ирсэн

Өөрөөсөө өөр юмгүй гүйлгачин

Хүйтэйгээ орооцолдон

Эх орондоо ирсэн

Эх орон бид хоёр

Бие биенээдээ ирсэн

Их яарч ирсэн

Алтан хигээст хорол тооноор бялхсан

Зургаан тасархай наран дор

Аргал унгатан асан алдах

Зун ханхалсан угаан дунд уулзсан

Ус нь намайг угаах гэж

Эрэг дээгүүрээ цоройж

Эх орон над руу ирсэн

Уул намайг үнсэх гэж

Манан дээгүүрээ цорвойж

Эх орон над руу ирсэн

Бүрдэнд нургих шувуудыг

Бужигнатал сарваганаж

Эх орондоо би ирсэн

Бужин хоёр хөлөөрөө

Буурал газрыг хонхойтол жийж

Эх орондоо би ирсэн

Эх орон бид хоёр

Бие биенээдээ ирсэн

Их яарч ирсэн

Үүл нарны ээлжинд уулзсан

Үхэх төрөхийн хооронд уулзсан

Эх орон бид хоёр

Эхлэх төгсөхийн жамын

Сүнс бөртөлзсөн босгон дээр уулзсан юм чинь

Энэрэх хатуурхах заяаны

Сүүдэр зүссэн ирэн дээр уулзсан юм чинь

Би ясаа үйрүүлэн

Эх орон чам юундаа шигдэн,

Эх орон минь над руу

Бэлээ эдгэртэл хумирч

Бид хоёр нэгэн цул болно

Бүрэнхий агаад гэгээн орчлонд ирэхдээ

Бүжин хөлөөрөө хонхойлгосон зайгаа

Өссөн биеэрээ дүүргэж

Бүтэн болгоноо эх орон минь.

1995 он

Өнжүүлийн хөх өвгөд

Ард минь биш

Урд минь

Ааруул үнэртсэн

Үгээ хэлдэг...

Ил далд нэг л зантай

Инээх нь хүртэл дугуй нартай

Ухаантай өвгөд минь

Уулын оройн хадад минь...

Буруу бүхнийг дарж

Булгарч унадаг чулууд минь...

Дөрвөн улирал хэрэлдсэн хөдөөдөө

Дөрөөн дээрээ босоо өвгөрсөн

Хэдэн улаан уул минь

Хэлхэгэр дээлтэй “туульс” минь

Талд багтдаггүй уртын дууг

Тавган дээрх үзэм нуртал дуулж

Янаглаж ирдэг зовлонгийн нулимсыг

Ясаа нортол дотогшоо залгилж

Даанч ажина үгүй явсан

Далиндаа хяруутай

Эр бор харцаганууд минь

Ижийд минь

Унага татаж өгч

Эцэгтэй минь

Цэрэгт цуг мордож

Цагаан агсмаар найр сандааж

Эсгийд боолгон хашгирч

Цагтаа сайхан хүүхнүүдийн

Зүрхний гижиг нь явсан

Өнгөрсөн он цагийн “алтан гэрэгэ”

Өнжүүлийн хөх өвгөд минь...

Золгох гээд очиход

Буцсан байх юм...

Зовлонгоо ярих гэхэд

Дутсан байх юм...

Ашаа эвдэхэд минь

Хошлон байдаг

Алдаж оноход минь

Багана байдаг

Гэр дэрвэхэд

Чагтага байдаг

Төр үймэхэд

Тулга байдаг...

Түүхийн жаварт биеэ ирлэсэн

Түрэмгий бардам өвгөд минь

Өнжүүлийн хөх өвгөд минь...

Ижийтэйгээ байхад...

Хагарсан чулуу

Дахиад хэзээ ч эвлэдэггүй шиг

Үнэнээ хэлье

Нулимсаараа зуурч хэлье !

Хагацахын цагт үхэл давж уулздаггүй шиг

Үнэнээ хэлье !

Амьсгалаа зангидаж хэлье !

Ижийтэйгээ байхад би баян байсан...

Орилсоор ижийдээ очин нулимсаа арчуулахад

Одод бүгдээрээ миний

Нүдэн дотор л түгдэг байсан...

Ижий минь инээгээд над руу ирэхэд

Энэхэн замбуутивийн наран

Ганцхан над дээр л асгардаг байсан...

Ижийтэйгээ байхад би баян байсан...

Араг үүрсэн ижийнхээ ар өвөрт гүйхэд

Аараг толгодын элс алтаар нурдаг байсан

Бөртөн бөртөн зэрэглээ хормойтой минь орооцолдож

Бүжин бор хөлийн минь сайрыг долоодог байсан

Ижийтэйгээ байхад би баян байсан

Судас нь лугшиж халуу дүүгсэн

Бурхны өвөр дээр тоглодог байсан...

Сүнс зайлам харанхуйн дунд

Сүү нөмөрч унтдаг байсан...

Ижийтэйгээ байхад би баян байсан...

Уул уулын орой уулздаггүй шиг

Үнэнээ хэлье !

Эсээ шатааж хэлье !

Урсгал усан эргэж урсдаггүй шиг

Үнэнээ хэлье

Цусаа буцалгаж хэлье !

Ижийгээ амирласнаас хойш би гуйлгачин болсон

Гэхдээ...

Энэ хорвоогийн үхлээс бусдыг тоож гуйхгүй гуйлгачин болсон

Ижийтэйгээ байхад би баян байсан...

* * *

Чилтлээ ширтэх, харчуудын нүдэнд хордсон

Чиний үзэсгэлэнд өөрийн чинь юм нэг ч байхгүй

Төөрөг заяа чинь тэнгэр эцгийнх...

Төрсөн бие чинь газар эхийнх...

Нулимс чинь хөх булгийн ус...

Инээд чинь хөөрүү хадны цуурай...

Эрвэлзэх сормуус чинь хиаг өвснийх...

Элбэг сэвх чинь харвасан ододынх...

Илүү зангуй дөлгөөн чинь уулынх...

Их тунгалаг зүс чинь сарных...

Өнгө, сүүдрийн хорвоогоос булааж авсан

ҮЗЭСГЭЛЭНГ ЧИНЬ

Өгсөн юм болохоороо буцааж чамаас авна

Гайхуулж яваа үзэсгэлэнгээс чинь

Ганц ч юм чинийх бишээ! амраг минь

1990 он

Тэр өдөр

Цочиж харвасан

Одод сараачсан

Хөх тэнгэрийн дор

Цуцсан нулимс унагалан

Санаж л яваадаа намайгаа

Цац суварган галаа

Ширтэн суухдаа бодлоо ч

Цайгаа дэврэх эгшинд

Мартаж л яваадаа намайгаа...

Газар билүүдсэн жавартай үүрээр

Цантай дээсэнд хайруулж

Галын тарни шившин өрхөө татаж явахдаа

Бодож л яваадаа намайгаа

Өөтэй бүхний дараа үгүүлж намайгаа бодлоо ч

Өлгийтэй хүүгээ уйлахад

Мартаж л яваадаа намайгаа...

Сарны зэлгээхэн туяа тооноор садарсан шөнөөр

Сайхан ханийхаа гарыг дэрлэн хэвтэхдээ

Бодож л байгаа даа намайгаа

Ассан гал шиг хайрын уруул

Биеий нь гижигдэхийн цагт

Амраг заяа нь нялхарч мартаж л яваадаа намайгаа

Илдийг зэв идэж

Их санахуйг мартахуй мэрдэг болохоор

Мартана даа чи намайг

Мартана

Мартана

Мартана даа...

Он жилүүд бид хоёрын дундуур

Цагаан зээр шиг хуйларна

Чи намайг мартана...

Олбин зэрэглээ бид хоёрын дундуур

Цагаан манан татуулан бүрэлзэнэ

Чи намайг мартана даа

Мартана

Мартана

Мартана даа...

Өнөө муу шүлэгч үхэж гэнэ гэж дуулдсан тэр өдөр

Өөрийн эрхгүй чи намайг санана даа

Зүрхээн цууртал санана даа...

Санана

Санана

Чиний гар

Алга нь тал мэт тэнэгэр

Атгаг хомхойн хонхор үгүй

Аз жаргал, нартай цуглуулан хотлуулж

Атга атгаар асгаж өгөхийн буян хургасан чиний гар

Үет найлзуур мэт хуруу нь

Үе бүхэндээ одод хальтилсан

Үрэл тогтом хонхорхойт

Үрийн даллагат чиний найланхай гар

Ар өвөр нь ялгаа нь үгүй

Ангирын өрөвлөг мэт зөөлөн

Тууш нь дэндүү, салаан завсраар нь гэрэл багтахгүй

Туулайн цус мэт бүдэг ягаан туяат чиний гар

Буруутан байлаа ч өрөөлийн нүдийг чичээгүй жудагт

Бурхны мутрын эх алтан загвар

Бөөрөнхий алаг үрээн дагаж намирсан

Бөмбөрцгийн амьд халуун бүслүүр чиний гар

Их үнэний аргамжаа гараас чинь хөтөлсөн байхад

Сохорсон ч би бүдрэхгүй...

Ийм сайхан гараас чинь

Хор уусан ч гомдохгүй...

Хагацахуй

Хагацахуй дор хагацах шиг хагацна

Хаан шиг амьдарч, нохой шиг үхнэ. . .

Намайг тойрч салхилсан

Намуухан салхины зангирааг тайлж хагацна

Ахиад алхахдаа гишгэх байсан

Алаг цэцэгний амийг өршөөж хагацна

Балгахан агаар цээжиндээ залгиж

Буцааж гаргалгүй тэнгэрийн цулыг зовоож хагацна.

Хагацахуй дор хагацах шиг хагацна

Хаан шиг амьдарч, нохой шиг үхнэ. . .

1990 он.

* * *

Намрын халуун өвсийг, мэсийн ирээр хадахуй

Нарны ноолуурыг амин зуулгандаа хамах мэт . . .

Намрын улаан жимсийг шүдэтийн хүслээр зулгаахуй

Нарны нулимсыг “жаргал” хэмээн эндүүрсэн мэтэд . . .

* * *

Усанд дүрсэн мөчрийг хагацаах дор

Удаан нь аргагүй, ус дусагнан салж ядмуй

Эсхүл удын мөчир, усаа санаж уйлсан хэрэг . . .

Эсхүл урсгал усан, усаа харамлаж нэхсэн хэрэг . . .

Бээжин хот

* * *

Өвөлдөө цасан бага унасан шалтагт

Ургах л гэж яарсан мододын өлмий хуурай

Өрөөлийн төлөө бага уйлсны шалтагт

Уярах л гэж заяасан хүмүүний төгсгөл хуурай

* * *

Харийн нуурийн хирийг үүл арчиж өнгөрнө

Халиун зэгсний тоосыг салхи үлээж өнгөрнө

Хавар ирсэн шувууд зусаж нэгэн өнгөрнө

Хажууд нь өссөн би л очиж чадахгүй өтөлнө

Өнжүүл. Харийн нуур

Халзан Бөзөнхий

* * *

Хээр талд өвс ганхах нь дураараа

Гандах л гэж дураараа . . .

Хүмүүн гэгч амьдын зайд дураараа

Үхдэг л болохоороо дураараа . . .

* * *

Манан цэцэг хоёр уулын элгэнд ээлжлэн эрхэлнэ

Зовлон жаргал хоёр над дээр ээлжилж эрхэлнэ

Шувуу давалгаа хоёр нууран дээр ээлжилж эрхэлнэ

Шударга хуурмаг хоёр хорвоод ээлжилж эрхэлнэ

* * *

Төгсгөл үүссэн цэг дээрээ давхцана

Шулуун муруй дээрээ давхцана

Буруу зөв дээрээ давхцана

Үхсэн хүн дээр амьд нь дэвхцэнэ

* * *

Зөөлөн өвс шоргоолжинд сэрүүн шугуй мэт. . .

Зөн мөрөөдөл хүмүүн зөгий бал мэт . . .

Өс хонзон үхлийн улаач хань мэт . . .

Үмхэж чадалгүй унагасан будаа тэнгэрийн хонь мэт . . .

Хон-Хонг

* * *

Манан дунд бүгээн адуу тургилна

Мэлхий эрэг дээр ч усандаа ч тухгүйтнэ

Нойтон эсгийнээс эртний угаа үнэртэнэ

Хүйтэн хүн чулууг үхэр шөргөөнө

* * *

Зааны арьс шиг

Үрчийсэн уулсын дунд

Загасны хайрс шиг

Гялалзсан хот Сөүл

Цэвэр тэнгэрт угаа тулж

Цийдэм мэт униар татна

Цэгээн далайд өлмий дүрж

Цэлий хадахгүй багтарч эргэнэ

Дуу дуулахад

Цуурайг нь алдчихдаг их талын

Цуу татах мэт өрхөө татахад

Нар тооноор шуурдаг

Хөх тэнгэр ойрхон орны

Хүмүүн юм болохоор

Илдэн уулсын ташаанд хадсан

Эсгий гэр минь санагдана

Ханийн минь хөхийг тойрч урссан

Хар хөх хоргой эмжээр мэт

Халуун бор толгод ороож урссан

Хачин тунгалаг усаа санана

Байж л байдаг бүхнээ

Бадаг бадаг шүлгээр дурсана

Бавуу хэмээх их өвгөнийг онхолсон

Байцаг уулын өвдөг хондыг дурсана

Амьтны тансаг хүрээлэнд ирчихээд

Өөриймсөж өгөхгүй талын чоно мэт

Аргаа барж суухдаа

Бийрээ хэмлэж сууна

Хаан минь эндээс

Хатан буулган хөглөрч

Үлдсэн цэргүүд нь

Үрээ төөрүүлсэн орон

Чижү арал дээр

Чийг нар хоёрт цохиулж

Үг буцлам халуунд

Үс нь зулгарсан морьд

Байн байн янцгааж

Баруун тийшээ л харж

Далайн хөлгүй алсаар

Дальгүй төрснөө тавлуулж

Овоон дээр тавьдаг толгойгоо

Оломгүй далайд унагасан газар

Дэлхийн нэгэн “бар” сувд

Дээдсээс үсэрсэн холын цус

Үг нь хүртэл холилдсон Солонгод иргэдэд байлаа ч

Үнэндээ би нутгийн зүүдгүй ганц хоносонгүй . . .

Бие сийчсэн монголын салхигүйгээр

Би амьд явах арга алга. . .

Сөүл

1995-11-27

Хан мөрөн

Хан мөрөн

Инээдээр хөөсөрч

Их хол урсана

Хан мөрөн

Түүхийн харанхуйгаас эх авч

Ирээдүй рүү урсана

Хан мөрөн

Урсгал дээрээ нөлөөтөх солонгосын хирийг

Угааж урсана

Сөүл

1990.8.24

* * *

Цонхоо онгойлголоо. . .

Чухам би юу оруулах гэж онгойлголоо . . .

Тэвэр тэвэр тэнгэрийг

Тээглэх юмгүй орог гэж

Тэнгисийн давстай салхи

Тэмтчин ирэг гэж

Навч цэцэгтэй исэлдсэн

Нарны үнэр морилог гэж

Намар цагийн сүмэн өвсний

Найгатал согтоох ааг саатаг гэж. . .

Гэтэл

Өндөр хөгжлийн “хулмас”

Өөрийн эрхгүй бараалхдаг байна

Багтаж ядсан тунгалаг агаар

Байхаа байсан газар байна

Цонхоо хаалаа . . .

Сөүл хот

1995.9.28.

* * *

Нутагтаа миний гишгэж явдаг лууль

Нэг мэдэхнээ тавган дээр

Өндөр үнэтэй заларч

Өөдөөс минь тэхийж байна

Хачин юм. . .

Хаа газрын ёс, хоол хоёр гэдэг. . .

Энэ газрынхан

Хогийн ургамал иддэг байх . . .

Эсвэл би нутагтаа

Иддэг юман дээр гишгэдэг байх

Сөүл

Сонет

Харагдах гэж ургасан цэцэгс гандлаа
Хагдрахаа бас харуулах гэж ургажээ...
Өнгөөр сэрэхүй ядуурч нүд эзгүйрсэн ч
Өндийх унахын жишгээр сэтгэл бялууруулав
Сүнс нь зайлсан цэцгүүд хэдий гудайсан ч
Сүүдэр нь харин буйн дайтай байв
Энэлэнт зохионгуйг мэдрэхүй тоолон дор
Эрлэг чимхэх мэт эмзэглэл биеэр тарна
Жаахан заяаны цэцэг биеийг гаднаас илдэг ч
Жамын алаг загвар, тархины дотроос зандчина
Хүмүүн үхэхдээ дотроосоо эхэлж үхдэг ч
Хөрөхдөө гаднаасаа эхэлж царцмуй
Дулаахан хаврын дундуур цэцэг цэцгээ давтана
Дурсахуй хожим ирдэг ч мартахуй ард нь сүүтийнэ

* * *

Навч хагдрах намрын сүмэн цагаар
Надад хүн дурлаж гэнэ...яахнав дээ...
Тоост хорвоогийн тохуу доог хоёрт улайстлаа өртөж
Толгой эргэм найр, хайрт уйдталаа төөрөв
Ший жүжиг шиг хорвоогийн алаг явдлын
Шившиг, тансаг хоёрыг мэднээ... би...
Мэдэх мэдэхдээ... мэдэх шиг мэднээ...
Мэндлэхээс үхэх хүртэл нь мэднэ

Хуучнаас хуучин хорвоогийн илбэ билбүүр

Үнгэгдсэн хойно минь”шинэ” байлгахна...

Худлаа нь үнэний эргийг зулгаасан үед

Үхэхийн минь өмнө ”хайрлаж” гялайлгахна...

Муухай гэдгийг минь гэрэл сүүдэр зурсаар атал

Муухайг сайхан гэж эндүүрсэн сохор хайрын буруу

1992 он

* * *

Дэрвэж явсан залуу халуун насыг минь

Дэвсэлж явсан бүсгүйтэй тааралдлаа....

Дэвэрч ассан сайхан зүсээрээ нүд арчиж

Дэргэд минь нулимж байсан хүүхэнтэй уулзлаа....

Дэндүү тэнэг явжээ....би гээд санаа алдан

Дээлийнхээ дотоод хормойг огшоож имэрлээ....

Цагтаа сайхан явсны гэгээн ул мөр

Цаана нь үлдсэн бүхэн намайг тэмтэрлээ....

Ухаарах сөгөөгүй явсныг чинь гэмийн дайтайд санаж

Урт жилүүдийн хойно хайрын хонзон авахгүй ээ

Усанд өвдгөө дүрсэн уулын бургас ширэлдсэн бэлд

Учраа олохгүй үнссэн уруулын мөр хацарт чинь байхгүй

Хөөрхий зүрхэнд минь одоо болтол чиний зай эзгүй ч

Хүйтэн одод, хоосон зүүдээр дүүргэчихсэн...би...

1997 он

* * *

Би үхэж намайг хүмүүс мартахын цагт

Сүүдрээрээ гэрэл цуулж

Булшин дээр минь ирээрэй

Сүнс минь чамайг танина

Мартсан бүхний сүүлд

Мартаагүй үлдсэн чамд

Хөмөрч унасан манан баярлана

Хөлд чинь торсон чулуу баярлана

Хагацалд сүүмийсэн өвс

Өвдөн байж баярлана

Хажууд сөхөрсөн уулс

Өндийн байж баярлана

Хайртай байж дээ, үнэн байж...гэж

Хамгийн сүүлчийн удаа яс минь цуглаж хашхирна

1993 он

* * *

Шилэнд нуугдсан омгийг

Шимж бус залгилж уусан эр

Гутал үдэж байгаа юм шиг

Гудамжны хоёр талыг мөргөчин алхана

Тэнчигнэн согтуу явна....

Тэнгэрийг түшиж.....газрыг гишгэж.....

Тэнтэр тунтар алхаж яваа нь

Тэр “архинд” хөлд орж байна

Хаа нэгтээ тэрбээр

Харуулдаж унаад босохгүй...

Доторхи архи нь нисэн одтол

Дор хаяад маргааш болтол унтана

Бие сэтгэлээ даахаа байж унасан хүмүүн дээгүүр

Битгий харай! Диваажинг зүүдэлж байж мэднэ

1994 он

* * *

Жингэр тойрсон нохдын отлоо

Шуурга шиг хуйларна

Жин цуваа нь дундаа хэмхэрч

Шуу цавинхаа арьсыг хуулалцана

Эгзэгтэй газраа таглан

Оцойж суусан “амттай” жингэрээ

Эр ноход шүлэнгэтэн тойрч

Омголон улаан чивээ долооно

Азарган ноход омгоо хазалдан

Уралцаж хэмхэлцэх сиймхий дунд

Адтай жижигхэн “Бээжин хав”

“Ураг” барилдчихсан сэлбэлзэн зогсоно

Зовлон хуваалцах шахдаг хоточ нохдын удам тасарч

Золбин давжаа эрлийз нохдоор хот хороо дүүрнэ

1994 он

* * *

Занаж зуусан шүдэн дунд

Хүмүүн багтдаггүй

Заарсан хорслын аагинд

Шүд нь шүдээ эмтэлдэг. . .

Өшилж, хяхсан сэтгэл дунд

Хүмүүн багтдаггүй

Өөртөө л зөвхөн мэсэлж

Эс нь эсээ иддэг. . .

Атаалж бодсон санаан дунд

Хүмүүн багтдаггүй

Асаж дүрэлзсэн жөтөөндөө

Өөрөө л өөрийгөө шатаадаг

Үнсээр нь харин

Үнэний цоорхойг шаварддаг

1994 он

* * *

Амаараа дүүрэн

Алтан шүдтэй хүн

Алаг заяаны жамаар

Амар болооч болжээ

Өрөөлд өгөхгүй гэхнээ

Өөртөө нааж явсан

Өчүүхэн санаа цэглэж

Өндөр ёсыг дагажээ

Айл хотлынхон нь нулимстай үдэж

Аралтай уулын бэл дэрлүүлэв

Ариун хойд насыг нь урин дуудаж

Авга лам нь хойтохыг нь уншив.

Ам руу нь хуруугаа хийж шүдтэй нь ноцолдон

Амандаа “шамбалын ерөөл” хангинуулав

1993 он

* * *

Орчлон доторхи аниргүйн “хаант” улс

Оршуулгын газар ажин түжин . . .

Үлдэгсэд нь үүрдгүй мөртлөө тохуурхсан мэт

“Үүрд дурсана” гэж бичсэн үгийг салхи шоолно

Агаа алдар мохож мухардсан энэ газар

Амьдын заяа цуг ирж төгсөнө

Амар болоочийг үдсэн амьдчууд

Амархан мартаг гэж яаран одно.

Үгүй болохын шалтаг ододоор даравч

Үүсэхүйн шалтаг өвсний голоор гадагшилна

Тарж тэнэсэн сүнснүүд цуглан инээлдэж

Та нар тэнэг гэж өтөөр нулимна.

Олон зууны нулимсанд бялуурсан атлаа

Оршуулгын газар дандаа цангаж байдаг.

1993 он

* * *

Будан талд буухуйн цагт

Бугын дуудлага эхэлнэ

Улаан өнгөтэй дуунд нь

Урагдсан манан хөлтэй нь ороолдоно

Мансуурсан согоонууд чимээлэн

Танатай бөгс нь хавчигнана

Марзны цагаан омруун дээр

Танхай эврүүд тачигнана

Эхэр татсан бугын дуунд

Эцэж турсан навч шувтарна

Эр эмийн улангассан явдалд

Эргэн тойрны өвс согтоно

Үхэх нь дөхсөн намар оройн ялаа

Үржих гэж давхарлаж ниснэ

1993 он

* * *

Сул асгарах нулимс чинь

Энгэртээ бүдэрдэг нь худлаа

Суугаад өрөвдөж байгаа

Миний л сэтгэлийг онодог

Дэргэд уйлсан нулимс чинь

Дэрийг чинь нэвтэлдэг нь худлаа

Зүйргүй хайртай надад нэвчиж

Зүүдийг минь хүртэл норгодог

Бөмбөрөөд байгаа нулимс чинь

Хацрыг чинь эсгэдэг нь худлаа

Бөргийж суугаа миний

Халуун голыг зурдаг

Үрчигнээд ирдэг нулимс чинь чамд шингэдэг нь худлаа

Үйлийн үргүй хайртай миний л зүрхэн дээр хатдаг.

1999 он

* * *

Уул хараад

Мөнх гэж атаархавч

Урсах салхинд элэгддэгийг нь санаад

Мөнх бусад харамсахаа болино

Чулуу хараад

Мөнх гэж атаархавч

Цав суудгийг нь хараад

Мөнх бусад харамсахаа болино

Ус хараад

Мөнх гэж атаархавч

Урссаар ширгэдгийг нь санаад

Мөнх бусад харамсахаа болино

Урт богино өндөр намын хорвоод

Угтаа мөнхийн юм нэгээхэн ч үгүйд “цадна”

1993 он

“Нэхэл” төөрөг

Босоо унаагүй ч

Бодсон газар хүргэсэн

Хол ойрын амьтан зайдалж

Хонины хушуу эргүүлсэн

Тэнгэрийн заадас шиг

Оломны цагаан олойртой

Тэрэгний хусан шоохой

Мундааг нь холгосон шархтай

Ганзага цацалж явсан

Салхитай адуу

Гарын үзүүрт бөмбөрсөн

“Сайн” унаа

Ялаа бужигнасан

Ясан дээр тохсон “шир” болж

Уяа бараадан дэгийн зогсох нь

Урьд морь явсны хөшөө мэт

Бороолсон бэрэвхийнээс нь ус шүүрэх нь

Биеэ газарт юүлэх мэт

Хэдхэн хялгастай сүүлээ

Шарваж даахгүй ч

Хэнэггүй нь аргагүй жамыг урьж

Толгой хааяа дохино

Салж хагацахын “ерөөлт” өдөр

Санаагаа бие нь эс дийлж

Сарвайтал унав

Салхин дээрээсээ холдуулж эзэн нь

Сархиагны хөлд “гээв”

Хэрээнүүд дээгүүр нь

Тойрог татан бужигнаж

Хэрзийсэн зовлогыг нь

Голохгүй тоншино

Өөрөөсөө бусдад нэмэр болоогүй

Өнгөнд боолттой амь байсан

Амьдралын мөчир дээр “бултайж” жаргасан

Аргатайн ачаар”бумбайж” өтөлсөн

Доошоо малтсан “хэрсүү” явсан

Дотогшоо иртэй “хутга” байсан

Мөчөө атаа бүхнээ

Мөрөөрөө гэгдэхийн араанд зуусан

Мөхөх төрөхийн их мөрний

Мөлийж элсэн чулуу байсан

Нутгийн нэгэн өвгөн

Жамын босго давж

Нулимс чирсэн хавийнхан нь

Уулын чулуу дэрлүүлэв

Арцтай таргил өндрийн

Тэхий дунд нь онголохыг

Амьддаа тэр захисныг

Тэр л ёсоор нь болгов

Цаг цагийн өнгө элж тодорч

Цайсан яс тарж төөрөх үед

Зорго дураараа эрмэг хүрэн тас

Зовсон морины толгойн ясыг зууж

Үүл “бэртээх” өндрийн овоон дээр унагаж

Үйл төөргийн горыг нэгэн тайлжээ

Цаг цагийн өнгө элж, тодорч

Цайсан яс тарж төөрөх үед

Зоож ядсан гэрийн ноход сүүл агсан

Зольсон өвгөний толгойн ясыг зууж

Урийн ус “бэртээх” жалганы мухарт хаяж

Учир төөргийн горыг нэгэн тайлжээ

1992 он

Хил дээр бичсэн шүлэг

Хүний нутагт явсан цулбуур эвхэж

Хилийнх нь боомтод ирлээ

Торгон хилийн эмзэг зурвасны цаана

Тортог суугаагүй эх орны минь сэжүүр

Амаржих гэж байгаа эхийн хормой шиг намаж

Алтан харганатай толгод нь өндөлзөнхөн байна

Хилийн эрхэм түшмэл

Хээмсэгхэн ширтэж хуудас тараана

Асуулт бүхэн нь хариулт нэхсэн түүн дээр

Аль улсын иргэн болох . . . гэж асуусан байна

“Монгол” гэж

Зургаан хана шиг үсгийг

Зурхайн хөх тэнгэрээс доош нь урсгаж бичлээ

Монголд хэдий хугацаагаар суух. . . гэж бас асууж байна

Үхтлээ суунаа

Үхсэн хойно сүнс минь хүртэл Монголын харъяат гэж бичлээ

Зарах юм байна уу гэсэн хүмүүс

Завсраар нь бас гүйлдэнэ

Мохоо хутга шиг нүд нь

Монголоо зарах уу гэж асуух шиг сэрдхийлгэнэ

Үгүй дээ

Үгүй

Хардаг нүд гэмээнэ

Цавчихыг нь мартаж өмгөөлсөн

Хальдаг амь гэмээнэ

Үхэхийг нь мартаж өмөөрсөн

Нутгаа өгснөөс үхсэн нь дээр гэж цус нь буцалсан

Нумын хөвч аагтай илдний үр садыг Монгол гэдэг юм

Нуугаад байхад цухалзаад байгаа санаагаа ав

Нутаг руу минь унагасан

Нүдээ ав

Өвөг дээдэс минь ясаа дор нь ивсэн

“Өндөр” эх оронд минь санаархваас

Заяа чинь дутна. . .

“Хүрээ” зураг

Тохой минжин малгай

Толгой дэрээ асааж

Одтой торгон хормойгоо

Хажтай гутлаар өшигчсөн авгай

Намар оройн шамраганаар

Намс намс сэмбэлзэнэ

Усны гудамж уруудан

Улалзанхан гунхана

Утаа чирсэн “чийчаан” тэрэг

Устай хонхор шалихад үсэчсэн шавар

Зайлуул авгайг будаж өнгөрнө

Долоож байсан хорвоо

Нулимж байна гэж

Дотроо харлалтал гомдож

Дээлнээсээ үргэнэ

Уухал торгон дээлийн

Ланзан хээ “шатааж”

Урт хар гэзгээрээ

Нүд шавхуурдсан бүсгүй

Хавар эртийн борооноор

Хотос хотос алхална

Усны гудамж өгсөн

Улалзанхан гунхана

Утаа чирсэн “чийчаан” тэрэг

Устай хонхор шалихад үсэчсэн шавар

Залуу бүсгүйг будаж өнгөрнө

Алмайрч унасан хорвоо

Миний сайханд

Атаархаж байна гэж

Дотроосоо омогдоно

1992 он

Харанхуй буюу сохор хүний яриа

Наран голлож

Халуун гаарсан

Намуухан хэрлэнгийн

Гал үдэд

Би шөнө болж төрсөн

Чих гар хоёртоо

Нүднийхээ ачааг хувааж

Чимээнд хөтлөгдөхийн зовлон

Өлгийнөөс намайг тоссон

Би жаргал дундах зовлон

Би гэрэл дундах харанхуй

Хүн хүний түрүүнд

Ижий минь л . . .

Халд өртөөхгүй бөөцийлж

Галд ойртуулахгүй хаацайлж

Аргалд явахдаа дандаа хөтөлж

Ааруул үнэртсэн энгэртээ нааж

Үсийг минь намиртал илж

Үнсэнэ

Өмөлзөхөөс өөрөөр уйлдаггүй

Өөрөөс минь нулимс гардаггүй болохоор

Болгоомжгүй багын зан хатгаж

Бороо дусаж байгаа юм уу гэж асуусан

Тиймээ миний хүү гэж ижий минь
Тэнэглэхийг минь нуусан
Бодлын “үүлтэй” ижий минь
“Бороошиж” байсан нь тэр юм билээ
Нуусаар байтал нь алдуурсан нулимс
Нүүр оносон нь тэр юм билээ
Үйлийн үртэй ижий минь
Үйрч байсан нь тэр юм билээ
Үнсэхэд нь асгарсан нулимс
Үртэс нь байсан юм билээ
Нас үеийн хүүхдүүдтэйгээ бужигнаж
Намуун хэрлэнгийн хөвөөнд өдөржин тоглоно
Наашаа яваарай гэж шуугилдсаар байгаад
Намайг тэд нар цүнхээлд унагаж инээлдэнэ
Эрэгрүү тэмцэж намайг зүтгэхэд
Ийшээ тийшээ гэж улам гүн рүү зүтгүүлнэ
Элгээ хөштөл тэдний инээлдэх нь гашуун ч
Инээднээс нь гэрэл гэгээ харах шиг болдог сон. . .
Хүмүүс минь ээ... зөв л дуугарч байгаарай
Хөөрхий би үгэнд чинь хөтлөгдөж яваа шүү. . .
Би жаргалд боолттой зовлон
Би гэрэлд боолттой харанхуй
Дуунд чинь аргамжаатай
Дутуу заяа

* * *

Ус нутгаа санаж, гүйн завдах морин
Уулын толгой ширтэн сүрэг захална
Үүр үүрийн хяраанаар сэрүүн сэвэлзэж
Үсээ ч гэж чадахгүй битүү бэтгэрнэ
Хаврын нялх ногоог тасдахгүй үнэрлэж
Хатсан амаа усаар цавлаж дэмий хөрвөөнө
Хөвч жийсэн сум мэт салхи сууж
Хөлөө шөлгөөж, далд зөөлхөн тургилна
Хавирган сар шиг болтлоо живхэрихгүй
Хажуу хөтлийн овоог таширлан сар шиг шингэнэ
Чөлөөтэй нь аргагүй задгайрах түүний ард
Чөдрийн гурван хөх шазганаж үлдэнэ

* * *

Анхны цагаан цас дэвсэн
Чоно адуу идэж байна
Амь амиа
Дэрлэж унах хорвоогийн
Амьдын богинохон зайнд
Бие биенээ идэж амь зууна
Зайлсан амь тойрон
Задгай цагаан тал
Эргэн тойрон мөр
Элбэж идсэн чийр

Цадсан чононууд

Цаашаа жаргал эрж одно

Алаг дээс шиг мөр

Араг яснаас холдоно

Идүүлсэн адууны

Араг ясанд тулж унтарсан

Мөрнөөс эхлэн

Идсэн чонын

Араг яс болох цэг хүртэл

Энэ мөр үргэлжилнэ

Мөхсөн сэхсэн бүхнийг

Мөр эрхи шиг хэлхэнэ

Энэ эрихээр

Энэрэнгүй бурхан маани уншина

Надад бага нас байгаагүй

Харихад аавын хэлэхийг хамт бодож

Ханатлаа ухаангүй тоглож яваагүй

Дэгдээхэй гэнэн зангаа тэр чигээр нь эдлээгүй

Дэндүү хашир “өвгөн санаат” явсан болохоор

Надад бага нас байгаагүй. . .

Өвчтэй ижийнхээ цонхигор дэрний дэргэд

Өдөржин шөнөжин өрөвдөхийн уяатай байж

Өдий төдий олон тоглоомноос татгалзаж

Өөрийгөө авч үлдэж чадсан болохоор

Надад бага нас байгаагүй

Хэрсүү хоёр хайрын уулын дунд

Хэлэх хөдлөхөө хүртэл битүү цэнэж

Зодуулах ах, шоглох дүүгүй орь ганц

Зоргоороо атлаа ижлээр дугаж өссөн болохоор

Надад бага нас байгаагүй

Миний голын тохой

(Ач хүү С.Хотулдаа)

Ус хажсан хавирга газар

Уул бохирсон өвдөг газар

Бургас цугласан суга газар

Бурхны зурсан гоё газар

Яаж баръя даа гэсэн

Багтаж ядсан бага насаа

Яг л энд сэмэлсэн

Бал эрсэн зөгийт булан

Загасаар хээлтсэн туулын

Мэл хархан хэлбэлзээн

Заяаны замдаа үдэлсэн

Миний голын тохой

Ус хажсан хавирга газар

Уул бохирсон өвдөг газар

Бургас цугласан суга газар

Бурхны зурсан гоё газар

1993.3.21

Лүн сум

Чинийхээ дэргэд өтөллөө би . . .

Амраг хань минь би

Анх л чамдаа хэлсэн үгэндээ багтаж өтөллөө

Амраг хань минь би

Алдаа оноо хоёрын үнэнд багтаж өтөллөө

Ижил хань минь би

Илүү дутуугүй аман хишгийн заяаг балгаж өтөллөө

Ижил хань минь би

Ирэх буцах алаг тавилангийн зайг гудайлгаж өтөллөө

Сайн хань минь.. би..

Саран наран хоёрын хэвгэрт багтаж өтөллөө

Сайн хань минь би

Санах мартагч хоёрын хоосонд багтаж өтөллөө

Жаахан багын хань минь... би...

Жамын модны сүүдэрт зэхээстэй өтөллөө

Жаахан багын хань минь ...би...

Жаргал зовлон хоёрт хэлхээстэй өтөллөө

1993.12.10

Харанхуй

Цэцэг өгсөн

Ууланд асаж

Одод уруудан

Талд сөгдөх заагт

Цэцгийн гэгээ

Оддын гэрэлд хуримлаж

Харанхуй болно

Цэцэгийг тод харагдуулах гэж

Үүр цайна

Харанхуйд ч

Гэгээтэйд ч

Хэрээ

Хар харагдана

Дуртгалын гэрч

“Хүүхэд насыг чинь, би мэднэ

Хүүхэн насыг чинь, хань чинь мэднэ...”

(тэмдэглэлийн дэвтрээс)

Салаа гэзэгтэй хөөрхөн зураг чинь

Сайртын горхины толионд байдаг

Би л таньдаг. . .

Санаанаас гардаггүй чанга цовоо дуу чинь

Сархиагт хайрханы хаднаас цуурайлдаг

Би л сонсдог

Алаг алаг чулууны бөөрөнд

Алганы чинь хээ байдаг

Миний л гарт тордог

Агьтын хоолойн ягаан ганга

Аальгүй салхинд ганхахаар үнэр чинь гардаг

Би л мэдэрдэг. . .

Айлын сайхан гэргий болсныг чинь

Аймаг, хошуугаараа мэддэг

Би л үнэмшдэггүй. . .

* * *

Үнэн үгийг чанга хэлэхээр

Худлаа сонсогдоно

Худлаа үгийг чанга хэлэхээр

Үнэн сонсогдоно

Үнэн үгийг шивнэж хэлэхээр

Үнэн сонсогдоно

Худлаа үгийг шивнэж хэлэхээр

Бүүр сонсогдохгүй

1979 он

* * *

Буу хараалж байхад

Хэрэм мөргөж байдаг

Буруулж чадахгүй болсон

Амиа гуйж байгаа юм бишээ

Сум тусах эгшин хүртэл

Самраа цөмөж байгаа юм

Амь тасрах агшнаа хүртэл

Амьдарч байгаа нь тэр ...

Богд уул

1998 он

* * *

Ододын дундахи хоосон зайд

Од буй гэж би итгэнэ

Орчих их зовлонгийн зайд

Жаргал буй гэж би итгэнэ

Гэнэн итгэл минь

Борооны дараа солонго татдагаас болсон байж мэднэ

Харанхуйн дараа гэрэл ирдгээс болсон байж мэднэ

Гэнэн итгэл минь

Их уйлсны дараа

Инээд ойрхон байдгаас болсон байж мэднэ

Гэнэн итгэл минь

Их инээсний дараа

Нулимс ойрхон байдгаас болсон байж мэднэ

1998 Он

* * *

Тэргэн дээр суусан шаазгай

Тэнгэрийн хов чалчина

Цаана чинь шаазгай шагшлаа гээд

Цай үйж хөл алдана ижий минь

Хүн ирэхээр л нэг их хашгирна

Хүүг минь ирэхийг хэлдэггүй мөртлөө ... гэж үглэнэ

Их зөнтэй ч гэлээ шаазгай

“Ижий совин” байхад би

Илүү шагшаад яах юм гэдэг биз гэж

Аав мэдэмхийрнэ

1998 он

* * *

Цатгалан хүний нүдэнд

Өлөн хүн “өргөс” шиг

Баян хүний нүдэнд

Ядуу хүн “өөдөс” шиг

Үхэж л байж, тавилан тэгшрэхийн цагт

Үгүй байгаагийн ялгаа арилж

Амттай амтгүйг нь мэдрэх

“Араатан” гэвэл “өт” л үлдэнэ

Бээжин

1998.01.10

Улхын цагаан дэрс

Улхын цагаан дэрс

Унан тусан ганхана

Учир нь үл олдох

Намрын аялгуу гиншинэ

Хааяа цагаан дэрс

Салхиа дагаад найгана

Хатан газар эхдээ

Сөгдөж мөргөн бөхөлзөнө

Эвийн цагаан дэрс

Ийшээ тийшээ үймнэ

Ижий ааваа бодохоор

Элгэн тушаа чимчигнэнэ

Улхын булан

1999.09.12

* * *

Дээврийн цоорхойг сар сүвлэсэн шөнөөр

Дэндүү тод зүүдэндээ ижийтэйгээ уулзав

Саранхөхөө минь хаана байна... гэж асууж байна

Шаналсан хацар дээгүүр нь нулимс гулгаж харагдана

Булгийн минь усанд

Бийрээ дүрж

Зорголын минь уулыг

Зурж сууг гэж

Өөдтэй байлгахын эрэлд хатаж

Өнжүүлийн ууландаа хүргээд өгчихсөн гэлээ... би

-Өө хөөрхий

Өөрөө чи уул байж чадаагүй юм уу гэлээ... ижий минь

Зорголын уул

1999 он

Этюд

Эрхэм бүсгүй чиний

Надад бичиж байсан

Инээд нулимсаар дүүрэн

Захидлуудыг урлаа ...

Зэрлэг үнэн хайрандаа хорсож

Зэлүүд тэнгэрт нисэхийм гэж бодлоо...

Үгүй байнаа...

Үхсэн шувууны өд шиг хийсэн газар уналаа...

Үнэн үг тэнд нэг ч байгаагүй байж...

Сүү савируулсан бодол

Хэлмэгдсэн номын мэргэдийн дурсгалд

Цэцэг бүхэн дэлбээндээ шүүдэртэй

Цэцэн буу болгон хүн байтай. . .

Номын улаан уулс нурахад дор нь байх

Номхон ногоон газар үйлийн лайтай

Улаан шуургатай

Улаан жилийн

Улсаа цэвэрлэх гэж

Ухаанаа буудсан

Улаан мунхаг өдөр

Оддын сүүлч тэнгэрт живж

Овоо хараан дээр үүр хаяарав

Олон хуврагууд үхэлд ханалж

Орхимжны нь сэжүүр зөөлхөн өмөлзөв

Үүрийн шувуудыг үргээн

Замаг тачигнана

Үхлийг хуврагууд

Залбирч тосно

Архад тунарсан

Ариун шамбалын

Алтан сүмийн дээвэрт

Жанцан хонх шаргиж байхад

Хавсарсан алга дундуур нь

Харваж орох сум үнэгүй ээ...

Хойд насны

Номын шадны юлд

Хар цагаан хоёрын

Хилийг цавчиж байхад

Хоосон чанарт дэвтсэн тэдэнд

Хорвоо хэмээх зүүд үнэгүй ээ...

Буудах гэж байгаа

Өрөөлд нүгэл хураахгүй гэгээн

Буруугүй атлаа

Өөрөөсөө шалтаг хайх ариун

Сэтгэл арилсан хуврагуудад

Үхэл үнэгүй ээ

Исгэрэх сум

Сүүлчийн амьсгал хоёрын ирэн дээр

Ижийдээ л үнсүүлсэнгүй дээ гэсэн

Сүү савирсан бодол цахина

Үүсгэлээ бодох тэрхэн эгшинд л

Үхлийн үнэ тэнгэрт хадна

1997.7.12

Илдийг цагаатгахуй

Ач хүү С.Хабулдаа

Эцэг өвгөдийн цавчилдаж явсан

Ирт илдийг би цагаатгана

Зөвтэй гэж цагаатгана

Зэвтэй нь хамт цагаатгана

Дэвсэж ирсэн сарны туяаг

Ширдэглэж давтсан

Дэгдээд ирсэн салхины хийморийг

Шүглүүлж давтсан

Шүдээ үйртэл зууж давтсан

Шүүдэр дунд

Шидэж хатаасан

Дээш өргөн

Долоон бурхнаар билүүдэж

Доош талбихдаа

Цагаан үүлээр арчсан

Үүл хуйхалсан гал дээр

Шатааж ширээсэн

Үлээсэн ганц хялгасыг

Тасдаж галзууруулсан

Их гүрэн

Илүү зориг юуг ч

Цавчиж байсан аранга

Цамнаж явсан хянга

Ягуухан эргэх хөх дэлхийд

Ялах ялагдахын ухааныг

Ясанд нь тултал зааж өгсөн

Ялгуусан Монгол илдийг цагаатгана

Эртэй морьдын өвчүүн дор

Ертөнцийн тал умарч

Ирэн дээр нь унасан

Нулимс хуваагдаж байсан илд

Хурц хурц гэлээ гэхэд

Хүүхдийн сэвлэгийг хөндөлгүй үлдээсэн

Хувь тавилан ижил хүмүүн заяаны

Хойч ирээдүйг цавчилгүй уучилсан

Миний монгол гүр илдийг

Мунхаг хүн сүлдэлж яваагүй

Айдсын хялуугүй

Аль ч зуунд буруугүй

Монгол илдийг цагаатгана

Морьтой түүхтэй нь цагаатгана

1997.1.12

Хар сүлд

Ач хүү Р.Есөнхулан, Р.Сэнгүм

Ач охин Р.Мөрөнгуадаа зориулав.

“...Миний цэрэг эрсийн толгой дээр

Хан тэнгэр

Хар сүлд

Хатан төмөр дуулганаас

Бусад юу ч үл асьюу...” гэж

Чингис Богд

Дэлт морьдын

Салхин дунд дуун алдвай...

Дэлгэр суудалт

Эмээл дээр үг алдвай...

Дэлхийд сонсож

Эр тангараг зангидав

Эзэн Богдын

Энэ үгэнд

Хүмүүн амьтан төрж зогсов

Хар сүлдний

“Хөл” тэд болов

Үндэс нь газар “шигдээстэй” байв

Эзэн Богдын

Энэ үгийг

Хөх уулс өндийн сонсов

Хар сүлдний “зэв” нь тэр болов

Үзүүр нь наранд “дүрээстэй” байв

Эзэн Богдын

Энэ үгийг

Хууртай салхи намирч тосов

Хар сүлдний “амьсгаа” нь тэр болов

Үнэр нь цэцгэнд “шүглээстэй” байв

Эзэн Богдын

Энэ үгийг

Хаан дээдсийн сүнс босож сонсов

Хар сүлдний “амь” нь тэд болов

Үнэн нь он цагт “дараастай” байв

“...Миний цэрэг эрсийн толгой дээр

Хан тэнгэр

Хар сүлд

Хатан төмөр дуулганаас

Бусад юу ч үл асюу...гэж

Чингис Богд

Дэлт морьдын

Салхин дунд дуун алдвай

Дэлгэр суудалт

Эмээл дээр үг алдвай

Дэлхийд сонсгож

Эр тангараг цацав

Эзэн Богдын

Энэ үгийг

Ихэмсэг дэлхийд

Илдээр хэлүүлэв

Дэлхийн тэн хагас нь

Хүзүүгээрээ ирлэж сонсов

Эзэн Богдын

Энэ үгийг

Ихэмсэг дэлхийд

Нум сумаар хэлүүлэв

Дэлхийн тэн хагас нь

Зүрхээ чичрүүлж сонсов

Дэлхийг умруулсан энэ үгийг

Хаан Чингис хэлж байхуйд

Дээр нь их Монголын

Хар сүлд дүрэлзэж байв

Тэргүүн дээр нь

Тэнгэр байв

Тэрний цаана

Нар сар байв

1993.3.11-нийг хүртэл

Багын шүлэг

Нутгийн хөөрхөн тэрнийгээ

Нуур шиг хонио хариулж явахад нь

Налайсан хоньдын дундуур нь хага яран

Навсайтал давхиж очлоо

Дээлэндээ салхи өвөртлөн

Дэгдээхэй шүүрэх гэж байгаа харцага шиг хүрлээ

Туурайн ирэнд оглорсон

Таанын цагаан цэцгүүд

Цэргийн наадмын ёслолын буудлага шиг

Цэнхэр тэнгэрт хуйлрав

Би мөн том байлаа....

Хөөрүү гэдэг нь хонь сандаагаад... гээд

Хүүхэмсүү нь аргагүй ширэв татаад

Үргэсэн хонио тогттол

Үг солихгүй айлгалаа

Бэлчээрт хонио тогттол

Бие биендээ хайрын үг хэлдэггүй

Амар хэнэггүй монгол хайр

Алсын хөх уулсын араншинтай

Урамгүйхэн сажлуулж гэртээ ирэхэд

Уул шиг аав минь дөрвөлж дээр суучихаад

Бэлчээр түйвээсэн овилгогүй... гэнгүүт нь

Би гэдэг... морьтой хөшөө...

Моньд минь... гээд чөдөр шүүрээд босоход нь

Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэх шиг болдог сон...

Эцэг төр минь

Хайр

(Ач хүү Б.Гүнмөрөндөө)

Гүйж яваа чинь

Агаар зүссэн илд

Гүнмөрөн минь би чамд

Ашидын их хайртай...

Хүн хэлээд өгчихсөн юм шиг

Үг хэлэх чинь нухацтай

Гүнмөрөн минь би чамдаа

Утгын их хайртай...

Буруу зөвөө эрт мэдэрч

“Том” хүний буурьтай

“Бурхан” минь би чамд

Далдын их хайртай...

Буурал амьдралын минь

Амтаг бал бурам

Буцаж ирсэн “аав” чамдаа

Дэндүү их хайртай

Хүүдээ бичсэн шүлэг

(Хасартаа)

Өдөлж гүйцээгүй үр минь

Өмөөрөх аав нь үгүй болохын цагт

Уулын шар өвсөн дунд

Уйлж нэг үзээрэй...

Хархан сормуусаа эгшихийн цагт

Хажуугийн уулсыг нэг хараарай

Хэтний ган шиг хатуу уулс

Хэнэггүй хуурай байх вий

Хайртай хүү чамайгаа би

Хад болгонд нь захисан юм

Өөрийгөө олоогүй үр минь

Өмгөлөөх хүн үгүй болохын цагт

Ухарч нэг урсаагүй усны дэргэд

Уйлж нэг үзээрэй...

Хацраа эгшихийн цагт

Харгилах усыг нэг хараарай

Чиний нулимс, миний дэргэд юу ч биш гэж

Чимээтэйхэн урсаж л байх вий...

Чинэрсэн хөх усанд

Чамайгаа би захисан юм

Сарны зэлгээхэн туяаг

Саарал дэлхий залгина

Өлөн цагаан гөлөг шиг саран

Өвдөг сөхрөн нуурын толиог долооно

Уйлсан нулимсаар минь

Амаа зайлсан хүүхэн шиг

Ус

Агуу их эрхэмсэг

Гэрэл гэгээг уухгүй хөвүүлнэ

Замгаа хүлхэж

Залгихгүй эрхлүүлнэ

Уулыг мэрж

Хазахгүй хорооно

Ус

Нүгэл хилэнцэт

Нүхтэй сувд шиг намайг

Эрлэгийн хүзүүнд зүүх сондор мэтэд

Эелдэгхэн сүвлэнэ

Сарны зэгэлхэн туяа

Саарал дэлхий рүү асарна

Усанд л сөгдөнө

1998 он

Хатан цэцэг

О.Эгшиглэндээ

Дэргэд нь хүмүүн мэлтрэн уйлахад

Дэлбээгээ хумидаг зөөлөн цэцэг

Дотроо мэгшин дагаж шаналах

Дорнын сүнстэй хатан цэцэг

Хажууд нь хүмүүн мишээн гэрэлтэхэд

Халиун дэлбээгээ дэлгэн баярладаг

Инээхийг хүртэл эсэндээ мэдрэх

Ижий сүнстэй хатан цэцэг

Бүтэн заяаны совингоор бурамласан

Бөргийж ургадаг эмзэгхэн цэцэг

Сэтгэл бараадан гуньж жаргах

Сэрүүн заяатай хатан цэцэг

Ханиа л дагаж жаргана

Ургаа хадан бөх ч гэлээ

Уулаа л налж жаргана

Заяа тавилан хатуу ч гэлээ

Замаа л элээж жаргана

Ургасан цэцэг их ч гэлээ

Усаа л бараадаж жаргана

Унах босох байх л гэлээ

Ухаанаа л түшиж жаргана

Урьхан хонгор дэлхий гэлээ

Нараа л хормойдож жаргана

Учрах хагацах байх л гэлээ

Ханиа л дагаж жаргана

Хөгжмийн зохиолч

Т.Ганболд аялгуу бичжээ

Учир нурших шүлэг

Улыг минь битгий шагай

Чамтай чамгүй

Чулуу миний бузар булайг бүртгэж байгаа

Ухаангүй хийсэн бүхний минь төлөө

Уулсын өмнөөс хожим яллах юм шүү намайг ...

Би эхээс эмзэг аймхайтайгаа төрсөн

Ямар сайндаа

Битгий айг даа гэхдээ

Бүрэнхийн түрүүчээр хамрыг минь хөөдөж байхав дээ

Араас минь битгий шинш

Чамтай чамгүй

Агаа таван тэнгэр

Алдаа оноог минь ширтэж байгаа

Олиггүй муу үйл хийсний минь төлөө

Оддын өмнөөс хожим гэсгээх юм шүү намайг...

Би эхээс гэнэнтэйгээ төрсөн

Ямар сайндаа

Зүйлийн зальтай амьтан

Зүүдий нь хүртэл хуурах вий гэхдээ

Миний дээр эсгий үнэг зүүхэв дээ...

Би эхээс төөрч мунгинахтайгаа цуг төрсөн

Ямар сайндаа сөөм хоёр бойтгонд минь

Хол ойртоо сонсогдох

Хонх торгоож өгөхөв дээ

Улыг минь битгий шагай

Чамтай чамгүй

Чулуу миний бузар булайг бүртгэж байгаа

Ухаангүй хийсэн бүхний минь төлөө намайг

Уулсын өмнөөс хожим яллах юм шүү

Араас минь битгий шинш

Чамтай чамгүй

Атаа таван тэнгэр

Алдаа оноог минь ширтэж байгаа

Олиггүй муу үйл хийсний минь төлөө

Оддын өмнөөс хожим гэсгээх юм шүү намайг...

Амирлангуй

Үнэн явсан уу гэж
Эрлэг надаас асууна
Үгүй дээ үгүй...
Эрлэг чамд ч үнэн байхгүй гэж
Би гэжинө
Эгдүүцсэн эрлэг намайг
Хагд өвс шиг зажилж
Эргэж ирэхгүй миний ард
Харууслын сүүдэр нулимсаар таргална
Бурхан миний хойноос
Тоож заргалдахгүй
Бусад нь байна даа гээд
Амирлангуй...
Итали. Венец.

1994 он.

Хоргодохын шүлэг

Ухаантай байхаас

Тэнэг нь илүү эрх чөлөөтэй

Үнэн байхаас

Худлаа нь илүү үнэтэй

Байгаа бүх юмс

Байраа сольчихсон мэтэд ...

Бадаг зүүд шиг

Бүдэг заяа тэмтрэхэд

Урт бодол агшиж

Уйдах юм шиг санагдавч

Өглөөг чөрхлөн авчрах үүрийн туяаг санаж

Өөдлөх уруудахын хорвоод би

Өөрийн эрхгүй хоргодно

Ариун тунгалгаас

Бузар булай нь илүү тод өнгөтэй

Амьд явахаас

Үхэх нь илүү амар амгалан

Буй байгаа юмс

Бууриа сэлгэчихсэн мэтэд ...

Мунхаг гашуун бодол

Муруй замаар шогшиход

Уужим санаа огшиж

Уйдах ч юм шиг бодогдовч

Уйлж хоносон тэнгэр өглөө цэлмэдгийг санаж

Уур инээдийн хорвоод

Улам би хоргодно

Өөдтэй гэдэг бүхэн

Уруугийн сүүдэрт хиртэж

Өс атаа мөсгүй сэтгэл

Үхэгсдийн элгэн дээр бүжиглэж

Толгой бөгс хоёрын

Тогтолцоо солигдсон мэтэд ...

Цухал сэтгэлийн будан

Цусанд булинггар унагахад

Ухаан санаа мунхарч

Уйдаx ч юм шиг элийрэвч

Сарны наагуур нүүсэн үүлс халхалж биш арчиж

өнгөрдгийг санаж

Сайнтай муутай хорвоод би үхэн хатан хоргодно

1998 он.

Аргаа барсан шүлэг

Өдөр өдрөөр архи хүртэж

Өөдөөс өөдөсхөнөөр эрлэг рүү намайг зөөх үр минь

Өрцөн цаанаас тасарч унасан цагаас чинь

Өө тавьсан юм, надад бий билүү үр минь

Архиар эссэн уураг тархи

Аавыгаа бодох мантай болдог юм байна

Бурууд алдсан ухаан гэдэг

Бурханд алгадуулаад ч засардаггүй юм байна

Үүл буусан толгой гэдэг

Үгэнд дийлддэг эд биш юм байна

Үхсэн хойно минь ч адлуулж үргэлжлэх

Үүрдийн их лай юм байна

Илүү дугуу зангүй нулимс ойрхонтой

Их л сайн хүү байсан даа чи...

Ямар хорлол, тархийг чинь цөмлөн унаж

Янаглан хорлож дотроос чинь хэмлэв?

Сайхан хоёр ач чи надад төрүүлсэн

Сар наран дор чи намайг жаргаасан

Жимс шиг хацрыг нь үнсэж

Жилийн жилд би саглайтал цэцэглэсэн ...

Жирийн заяа азаар тэгширч

Жаргал гээчийн бэлд нялхарсан

Ижий бид хоёрын чинь амьд яваа нь

Илүү юм биш биз дээ...

Элдэг дуусдаг насыг мөнхөд бодож

Эндүүрч яваа юм биш биз дээ...

Эцсийн амьсгал татахдаа би

Чамд зовж хахмааргүй байна

Эндэж алдсан нэгнийгээ хайрладаггүй хорвоод

Чамайг орхиход аймаар байна

Аргиж хатсан хоёр хайлаасны сүүдэр дор

Архи залгилж тоглож суугаа үр минь

Амьдын энэ хорвоо чинь

Алаг л гэнэ, хар нь дийлэнх юм шүү дээ...

Өдөр болгон архи хүртэж

Өөдөс өөдөсхөнөөр эрлэг рүү намайг зөөх үр минь

Ухаарлын их бяр өөрөөсөө гарга л даа чи

Ухааны тэр дарсыг чинь аав нь залгилж

Жавар инээдийн энэ хорвоод

Жаргалтай аав яваад авс жийе, үр минь

1998 он

Миний зай

(Өөрийн гэсэн болгондоо зориулав)

Дэлхийгээс булааж төрсөн

Дээлийн энтэй зайг минь

“Үхэл” хэмээх алаггүй үнэн булааж

Үгүйн салхи тэнд дураараа буйлна

Өөд болоход минь та нарт үлдсэн

Өм өмөөр онгойсон сэтгэлийн чинь зайг

Унаж чулуужихдаа үлдээсэн

Ухам ухмаар эзгүйрсэн харууслын оронг

Олон олон гэхэд

Одод нь олдсон

Хөх тэнгэр нөхөхгүй...

Олон олон гэхэд

Цэцэг нь өлдсөн

Бор газар нөхөхгүй...

Шоглуулсан сэтгэлийн хагацлыг

Шороо чулуу хоёр нөхөхгүй

Амьдад чинь

Миний өмнө алдсан алдаа

Аль байдгаараа

Ашаа эвдэж байсан бүхэн

Миний байхгүйн зайд

Миегнэн оршиж

Нууя гэлээ ч дийлдэхгүй

Нулимс тэнд зоргоороо урсана

Үхсэний минь дараах миний зайд

Үгүйлэхийн шаналан гиншин холхино

Тэгэхэд нь тэгэхгүй яав! гэсэн

Тэнэг гэмшлийн зайг ...

Тэр минь байхдаа гэсэн

Тэнэмэл дуртгалын лайг ...

Буруутай зөвгэй миний орон зайг

Бурхан хажуулаад ч нөхөхгүй

* * *

Илүү дутуу зангүй хань минь

Ижий сэтгэл нь нялхаараа...

Үргэлжлэх үл тасрах ач нараа тэвэрсээр

Үнгэж эрхлүүлж нялуурсаар...

Элэг энгэр нь сүүнд дэвтэж

Элбэг дээл нь араасаа онгоно

Сүүний үнэртэй хүүхдүүд

Элгэнээс нь нялхруулж

Сүүдэр зуусан жам

Араас нь мэрнэ

Элэгдэх хэмээх жамын босгыг

Эх хүн энгэр нь сүүтэй давна

Хатан Бөзөнхийн гол

Сувдан эрдэнээр хөөсөрч байх нь ээ

Хатан Бөзөнхийн гол минь

Сууж ядтал санагдах

Хаваржаа намаржаа хоёр минь

Баралзан баралзан харагдах нь ээ

Зорголын улаан болдог минь

Багтарч үхтэл бодогдох

Ижий аав хоёр минь

Барин тавин зүүдэнд нь ээ

Боржгин цэнхэр хөндий минь

Байхын аргагүй дурсагдах

Багын жаахан тэр минь

Хөгжмийн зохиолч Т.Ганболд аялгуу бичжээ

Хайрын хийморь

Үүлэн чөлөөний наран заяанд

Үйлийн үрээ эдлэн жаргасан

Нэгэн биений минь нөгөө тал

Нинжин сэтгэлийн минь цагаан сүүдэр

Хань минь дээ

Хань минь дээ

Миний л хань минь дээ

Цэцэг цасны эрээн чөлөөнд

Чиний минийгүй уусан ханилсан

Чихэртэй давстай амьдралын дарсыг

Хувааж залгилсан хосгүй амраг

Хань минь дээ

Хань минь дээ

Миний л хань минь дээ

Цэцэн тэнэгийн буурал орчлонд

Цэлмэг итгэлийн мөрөнг хажсан

Хойд насандаа ч бие биенээ эрэх

Хорвоо багадсан хайрын хийморь

Хань минь дээ

Хань минь дээ

Миний л хань минь дээ

Чамайг би дурсана

Чамайг би дурсана

Чанх дээр түгсэн

Чандмань гурван одтой дурсана

Чамайг би дурсана

Чагтага гогцоорсон тооноор

Хоймор унасан сартай дурсана

Чамайг би дурсана

Дөлөрсөн хөх өвс шүргэсэн

Дөрөөн чимээтэй дурсана

Чамайг би дурсана

Дөмөн сэвэлзэх талын

Дөрвөн намартай дурсана

Чамайг би дурсана

Арган дээр суугаад инээдэг

Аальгүй хар нүдтэй чинь дурсана

Чамайг би дурсана

Аль ч эрийг хайрлаж мэдэх

Алдаатай чинь дурсана

Хань

Нүгэл буяны

Хутганы ир шиг завсарт

Нүд нүдээ олж

Бие биендээ нэвчсэн

Нарны сарны

Ургах жаргах сүвэгчинд

Үг үгээ сүвлэж

Нэгэн насыг эмхэрдсэн

Газар тэнгэрийн

Амь хайрласан зайд

Хана, хацар нийлүүлж

Айл болсон

Асаж унтрахын

Өөдсийн чинээн эгшинд

Аргал хомоол түүж

Гал асаасан

Учрах хагацах жамын

Улаан голыг бөхөлж

Удам залгах үрс

Урд хормой дээр унасан

Эр зүрхний-од тэнгэр

Их санахын-ад тэнгэр

Илч гэрлийн-оч тэнгэр

Ижий галын-ач тэнгэр

хань минь...

1999.12.13

Ач хүү Хасарын Хасуйд

Элээний сүүдэрт өртөх төдийд даарах

Энгэр, өвдөг жиндэх насанд

Ач заяав.

Зүүнээс туньж манддаг нарны “өөдөс”

Зүрхэн дээр минь “чарлаж” мандав.

Өвөө нь хүүгээ

Өсгөнөө...

Цэвэрхэн үүлэн зүлгэх

Тэнгэрээр татуулж өсгөнө

Цэцэг нь багтаж ядсан

Талаа жийлгэж өсгөнө.

Халуун салхи зайчилж

Сүүдэртээ хөтөлж өсгөнө.

Хаан тулгалсан төрийн

Сүлдийг тойруулж өсгөнө.

Идэр жигүүр цуцаж

“Ингэн туйлаадас” үсэнд хаялах намар

Ач заяав.

Газар буудаггүй долоон бурхны хэлтэрхий

Гарын алганы хонхорхойд “инээж” түгэв

Өвөө нь хүүгээ

Өсгөнөө...

Халиун хонгор зулайг нь үнэрлэн

“Согтож” өсгөнө...

Хатуу хорвоотой удаан зууралдаж

“Тогтож” өсгөнө...

Эмээ “хатан” уултай нь

Элбэж өсгөнө...

Их Чингисийн монголыг

Үргэлжлүүлэх гэж өсгөнө.

Хүргэж өгөхийн шүлэг

(Ханьдаа)

Салаа гэээгтэй

Салхинаас бусдад үнсүүлээгүй

“Цэцэг” явахад чинь

Сарны гэрэлтэй ширэлдэн орооцолдож

Гэрэл цуулан гар гараасаа хөтлөлцөн

Гэрийн чинь гадаа хүргэж өгдөг л байлаа

Бөөр алаг тугал шиг сурагч хувцастай

Хөөр халгисан “Улаан хацарт” явахад чинь

Бөгцөг няслах шиг харвах оддыг “нулиман”

Хөөрхөн чамайгаа хүргэж өгдөг л байлаа

Эвлэж өгөхгүй зовоох үгээ дундаа дамжилж

Инээмээргүй юманд цамцаа язартал инээж

Санаархсан хөвгүүдийн нүдэн дундуур туучин

Сайхан чамайгаа хүргэж өгдөг л байлаа

Амьдрах заяаны зөнд хатан

Алхаа сүүдэр хоёроо нийлүүлэн

Бүрэг зангынхаа “хил” дээрээс

Бүтэн жил чамайг хүргэж буцсан

Нэг л өдөр би чамайг

Гэрийнхээ үүдэнд хүргэж ирсэн

Ижийдээ нэрий чинь хэлж

Ичиг хагарч амарсан

Бөрт цагаан гэрийн өрхний эрээн дээсэнд

Би чамайгаа хүргэж өгсөн

Болж бүтэх амьдралын галын захад

Бие сэтгэлээ чи надад хүргэж ирсэн

Ганц олдох амьдын заяа салгаж

Газар ижийд хэн нь хэнийгээ хүргэж өгөх нь

Үлдэх үр хүүхдүүд минь

Үзэж л байж таах оньсого

Зуны өдөр урт

Зуны өдөр урт

Зүүн уулын оройгоос

Баруун уулын орой хүртэл урт

Зуны өдөр урт

Халуурсан ногоо хөрж

Хажуу айлын сүүдэр миний гэр унтаргал урт

Шөнө дунд адуу тургилав

Шуугиант хотын зуслан сэжүүрт

Шөнө дунд адуу тургилав

Гэгээн зүүд тал руу хулжиж

Гэрт тогтомгүй сэтгэл гэгэлзэв

Тэрэгний хэдэн морьд

Тэмтчиж өнгөрсөн үүрээр

Тэнүүн бор хөдөөгөө санаж

Тэврэлдэж хоносон сормуус хагацаав

Тэрэгнийх ч бай хониных ч бай

Тэргэл саран дор адуу тургилж хоносон

Хотын дундаа малын жишээ тэд холдоогүй ээ

Хогны захад хайрга цавчиж хоносон...

1992-1993 он

Олох гээхийн шүлэг

Хүү Л.Ирмүүнзаяа-даа

Сүнс тэнэсэн эзгүй хоосноос

Сүүдэр гэрэл тэнцсэн

Дэлхийгээ олсон.

Гал тойрсон

Есөн гаригаас

Ганцхан амьтайг нь

Олж буусан

Хүлэг янцгааж

Хорхой бужигнасан төөргөөс

Хүмүүний төрлийг олж төрсөн

Түрэмгий салхи нь дураараа

Түүх дэвссэн монголоо

Онож унасан.

Эцгээсээ усаж

Эхэд бүрэлдэж

Биеийг олсон.

Элбэг энгэрийг нь

Эгшсэн амаараа тэмтчин

Сүү олсон.

Олсон, олсон

Олон юмс

Олсон

Өөртөө таарсан

Ухаан

Олсон...

Өрхөө татах хань

Олсон

Өвдөгөндөө мөргөх

Үр

Олсон

Өөр хүн Бичихгүй

Шүлэг

Олсон...

Олдсон бие

Гэтлэхийн шалтагт

Шингэнэ.

Олсон юм

Гээхийн шалтагт

Шилжинэ.

Толгой дээрээ

Нулимсаа өргөж ургадаг

Цэцэгсийг гээнэ.

Тортогоо нисгэж

Үнсээ дэвслэх

Галыг гээнэ

Торойгоод үлдэх

Хайртай бүхнээ

Гээнэ.

Тоост орчлонгийн

Зовлон жаргал

Хоёрыг гээнэ.

Өш хонзон, атаа хорсол

Өргөмжлөл магтаал

Бүгдийг гээнэ.

Өнжүүлийн уулс, хүйтэн булаг

Өглөөний нар

Үдшийн гялааныг гээнэ

Өөрийгөө

Би сүнстэйгээ

Монголдоо гээнэ.

Намрын салхи

Бодол сэвэлзсэн

Намрын бүрхэг өдөр

Ботгоны буйлах дуун

Нүдний “арз” нэрнэ

Бүдэрсэн нулимсанд

Согтсон энгэрийн

Бүтэн хоёр товч

Хар аяндаа мултарна

Болохын тухай

Бодохоос өрсөж

Болж өнгөрсний

Шарх илүү хөндүүр

Хэвтээ шар салхи

Өвсний уцаар хүргэж

Хэлгий цагаан манан

Уулын элгэнд цагираглана.

Цуламхан нам гүмийг

Цуулж нохой хуцна

Цугтаа яваа юм шиг

Цуурай дагаж боргоно

Өтгөн үүлс газарлаж

Үдээс хойш бороошино.

Салхи хэдий намдсан ч

Цээжин дотор сэрвэлзэнэ.

1990 он.

Хээр талын намар

Зэлгээн намрын цагаан үүлс

Хэсэг хэсгээр тасрахуй...

Зэвгэй дуртгалын илд

Ногоон нулимс унагана.

Зэрэглээ татарсан талаар

Хонгор салхин бөмбөрөхүй ...

Зээрэгний өтгөн сүүдэрт

Халтар царцаа шаргина.

Унаж уугисан намрын наран

Дүйрэнги халуунаар төөнөхүй ...

Унагаа сүүдэрлэсэн гүү

Зэлнээс холдохгүй зовооно.

Өнжүүлийн уулс

1.

Харвасан одод

Мөргөн хальгирч

Хөрөвсөн үүлс

Шүргэн сэмэрсэн

Хөглөрсөн хөх уулс

Хойд, урд өнжүүл.

2.

Талын хоймор

Зангиран зээглэж

Таанын шуурганд

Өвдөг дүрсэн

Хөглөрсөн хөх уулс

Хойд, урд өнжүүл

3.

Зэрэглээнд урагдан

Тэнгэрт лугшиж

Зүүдэнд ирж

Тунарч хаяалсан

Хөглөрсөн хөх уулс

Хойд, урд өнжүүл

4.

Бодол болон

Манангаар уйлж

Богшрогo жиргэхэд

Цэцгээр инээсэн

Хөглөрсөн хөх уулс

Хойд, урд өнжүүл

1993 он.

* * *

Хавартаа ирсэн шувууд

Нуураа орхиод нисчихсэн

Хамаг сайхан цэцгүүд

Ишээ орхиод хийсчихсэн

Нутаг сэлгэсэн буурины

Зовсон өвс ургачихсан

Нуурын хонгор амсар

Давсан омгол татчихсан байхад

Хувирч үзээгүй амраг минь

Хуучин л байдаг янзаараа...

Холын хөх уулс

Мананд шургаад гирэвшчихсэн

Хоёр жил ширтсэн хөтөл

Нүдэнд илүүлээд мөлийчихсэн

Хажуу саахалтын хүүхнүүд

Хадмын бурханд мөргөчихсэн ...

Хань нь болох намайг ирэхгүй гэсэн

Хов чихэнд нь дуулдчихсан байхад

Яхын аргагүй амраг минь

Яг л байдаг янзаараа ...

Нам гүм

Саран зэв шиг шинэдийн сар

Зулай дээр байдаг

Садарч буусан одтой цөөрөм

Хажууд байдаг

Анираа залгисан нам гүм

Эргэн тойрон байдаг

Ангир ядахдаа дуугарахгүй

Эл хульхан байдаг.

Өөрөө л жаахан хөдөлбөл

Өвс ёолох гээд байдаг

Үг л дуугарвал цуурайтаж

Манан цуурах гээд байдаг.

Шүдэнз зурвал үргэчихмээр

Ажин түжин байдаг.

Шүлгээ бичье гэхээр

Амьсгаа дуулдаад байдаг.

Ядахдаа...

Ядахдаа...

Ядахдаа...

* * *

Өлгийтэй үрээ нойрсуулах гэж ганхсаар

Өөрийнхөө аялсан бүүвэйнд дууран

Энгэрийн товчоо ч товчлох сөгөөгүй нойрссон

Энхрий чамайгаа харжээ...суухнаа ...

Хацар хацрын нь өнгө бие биендээ уусч

Хажууд нь байхад сүү үнэртэнэ.

Амьдралын модыг бөхийлгөж ургасан хоёр жимс

Адилхан гэдэг нь яанаа....

Өөрийн эрхгүй хайр хүрч, ханийнхаа

Өрөөсөн хацар дээр нь үнсээд сэрээчихвэй

Зүүдийг чинь уруулаараа цавчсан

Зүггүй хайрыг минь өршөө!

“Ирэхгүй” ээжээ зүүдэлж байхад чинь сэрээчихсэн бол

Их нүгэлтэй намайгаа уучил!

1993 он

Сэрүүн зүүд

1.Хаялга

Дөнгөж хөлд орж буй хүүхдэд гарт нь чулуу бариулж тэнцүүлж өгдөг. Миний гарт буурал ижийн минь бариулсан чулуу, урд Өнжүүлийн чулуу байсан... Өөрөө би чулуу танихын аргагүй нялх байсан ч намайг тэнгэр газрын дунд тэнцүүлсэн чулуу Өнжүүлийн гэдэгт эргэлздэггүй.

“...Алгандаа атгаж тэнцэг гэж

Алаг чулуу өгсөн хөл уул минь...”

/Монгол уул шүлгээс/

Хааяа би нутагтаа очиж, тэнэж яваад тэр чулуун дээрээ гишгичихээгүй л байгаасай гэж боддог... Гишгичихсэн байсан ч миний чулуу надад хилэгнэхгүй, харин ч намайг босоогоороо яваад минь баярлаж ч болох...

Миний сэтгэл л харин эмзэглэж ачыг дэвссэн “хэргийн” учир өөрөөсөө “ял асууж” зовох ...Зовлон жаргал эмзэглэлийг би өөрөөсөө нэрж гаргана бүлгээ...

Надаас, миний сэтгэлээс үүддэг болгон миний өмч.

“Миний халуун нулимс хүний энгэр дээр хөрдөггүй...

Миний л энгэрт шингэдэг”

/Өөрийн шүлгээс/

2.Цацлага

Хагацах, ирэх заяаны хэвлий

Халуун, харанхуйд би сэрүүн байсан .

Тэвнийн үзүүрт арвай тогтох орон зайд

Тийчилж хөлбөрч би сэрүүн байсан.

Заадас бүхнээ салгаж төрүүлсэн эхээсээ

“Задгай дэлхийд” гарахдаа сэрүүн байсан.

Хөхний сүүнд норсон

Дээлийн энгэр налаад

Хөг торгон

Бүүвэйн дуу сонсоод

Би

Бөх гэгч нь унтсан.

Тэрнээс хойш

Тэгэхэд сэрүүн байсан гэх цаггүй

Тэр чигээрээ

Тэнэг эрээн зүүд

Ариунаасаа бузар нь их

Амьдаасаа үхсэн нь олон зүүд

Үхэж байж сая сэрмүй, би...

Зүүсгэл

Би ийм нэртэй шүлгийг 1969 онд бичиж байж...

Энэ нэр хүмүүст олонтаа хэрэглэгдэж, надад хувь оногдохооргүй хуучирчээ...

Хөдөөний бүсгүй

1. Хаялга

Хөдөөх сайхан бүсгүйг би харсан... Наадамд унадаг морио малд явахдаа унадаггүй болохоор тэр гундуухан буурал морьтой явсан. “Буурал” он цагийг унасан тэр үзэсгэлэн, мэнд мэдээд л өнгөрсөн, миний асуусан айлыг ташуураараа зааж өгөөд л... Айлын зайтай сажлуулж явснаа тачигнатал хатируулсаар холдсон. Эргэж нэг ч хараагүй... Монголчууд өөд болоочоо нутаглуулчихаад эргэж хардаггүй ёс шиг л болсон. Морины нь төвөргөөн шүлгийн хэм болон бөмбөрдсөөр бүдгэрсэн... Бүдгэрсэн тэр зурхайнаас миний шүлгийн морьд эргэсэн. Өөрийгөө тэр миний сэтгэлд орхичихоод эргэж ганц хараагүй... Уруул нь омголтсоноос өөр эмгэггүй эрүүл бор хөдөөгийн тэр бүсгүйн, үгнээс нь “ааруул”, үснээс нь агь ганга үнэртэх шиг болсон.

2. Цацлага

Хөдөө талд уулзсан

Хөөрхөн бүсгүй

Хөмсгөн дээгүүрээ харайн алдсан

Хөөрүү ганган харцгүй байсан

Хөхөрч хөшиж гунхсан

Хиймэл дэгжин маяггүй байсан

Хөдөө талд уулзсан

Хөөрхөн бүсгүй

Идэр бор царай нь

Энгэсэг хэрэггүй хөөрхөн байсан.

Илүү зангүй ааль нь

Инээмсэглэхээс өөр гоёлгүй байсан

Юншийн хормой

Зүүдний ад

“...Эрслэнгийн мээм

Тавхайдаа байдаг...”

/Ардын домгоос/

1. Хаялга

Зөөлөн үгт хатуу сэтгэлт хүмүүн алиныг хэлж барна. Хатуу хэлт, зөөлөн сэтгэлт хүмүүн түүнээс цөөнгүй. Бага байхад айлын эгчис чихэр өгнө.

Өгөхдөө, олон хөөрхий хэлдэг эгчийн өгсөн чихэр цөөхөн, загнаж байж өгдөг эгчийн чихэр олон байдаг сан...Хал хайр хоёрыг орчлонгоос зэрэг эрэлтэй... Нэгийг нь илүү олбоос зовлон болдог.

2. Цацлага

Өрхөн завсраар салхи оргисон

Өрвөлзсөн бургаатай хүйтэн шөнө

Өрөвдөхнөө барагдахгүй ижийгээ бодож

Өөдөсхөн нойр үүрээр үзэж зүүдлэв.

Өлөгчин эрслэн намайг тавхай дороо дарлаа

Өндийх гэхэд газар доошоо хонхойно

Хавирганы бураа шажигнатал дарна

Хааяа нэг хүржигнэтэл хүрхэрнэ

Тэр дороос нь гарах гэж

Тэмцэж агдаж байтал

Сэрэх зүүдлэх хоёрын дундуур

Сэлэм мэт үүрийн туяа цавчив.

Тэнгэр өнчин намайг өршөөж

Тэнэмэл зүүднээс хагацааж амраав.

Зүүдний төвөргөөн хэгзэлсэн уранхайг

Зүйж хайж эвлүүлж ядахнаа

Өнчин намайг

Өрөвдөхдөө

Өрөөсөн мээмээ

Өх гэсийм билээ ...

Эрслэнгийн хөх

Тавхайдаа байдаг гэдэг

Эртний монгол домог

Эзгүй байжээ...зүүдэнд

Өрөвдөхийг өшлөх хэмээн бодох болсон

Өнөө өглөө би гэмшил залгиж сэрвэй...

Ганц ангир

1. Хаялга

Намрын сар гарахуй дор, нуурын хөх өнгө буурна. Буцах тогоруу цуглан, хятад шийний илд шиг далавчаараа ус цавчина. Намрын шувууд голдуу нуурын захаар дэрвэлзэнэ. Нуурын голд бараг очихгүй... Намрын нуурын ус голоосоо хүйтэрдэг ажаам... Хорвоогоос буцаж байгаа хүмүүн, зүрхнээсээ эхэлж хөрдөг гэдэг. Өнчин ангир нуурын голд ганганана. Хагацал гэдэг, халуун хүйтнийг анзаарах сэрлийг хүртэл булаана. Усны хамгийн гүн газар шувуу хөнгөн харагдана. Өөрийн “их” зовлон, өрөөлд “бага” санагдахыг элрээж, өөрийн “их” зовлон, өрөөлийн “их” зовлонгийн дэргэд бага хэмээн бодвоос зөвийн хувь буй.

2. Цацлага

Хосын тасархай

Ганц ангир ганганана

Холын дууг нь авчирах

Долгио дагаж гаслана

Ганганан

Ганганан

Ганганана.

Өрөөснөө эрэн ганганана.

Өдөн дотроо ганганана.

Цээл дундаа ганганана.

Цээжин дотроо ганганана.

Ноднин энд

Хоёулаа байлаа.

Энэ жил тэр

Хоёулаа байнаа ...

Ижил нь гэвэл

Сүүдэр нь байнаа...

Ганц ангир ганганана.

Ганганан

Ганганан

Ганганана...

Зэрэглээ

1. Хаяага

Хүн намайг санаж яваа бол надад тэр хүн бодогдоно. Би хүнийг санаж яваа бол тэр хүнд бодогдоно.

Бид хоёрын “үнэнг” зөн совин зөөж гүйнэ. Совинг гомдоохуй дор бид хоёрын дунд цавлаж, түүний гаваар “байгаа” хоосон , “байхгүй” хоосон хоёр алаглан урсмуй...

2. Цацлага

Хэлбэрийг эвдэх хөх зэрэглээ

Хуурай урсгал

Хэвтээ огтлол.

Бидний дунд зэрэглээ байна гэдэг

Бид хоёр хол байна

Битүүхэн гунигаас унасан

Нулимс ууршиж

Би чамайг гомдоосон

Үг хиншүүтэж

Бид хоёрын дундуур

Зэрэглээ урсана.

Бидэн хоёрын дундах

Цугласан сэтгэл зэрэглээтэж

Бидэн хоёр

Бие биенээ бодохын чинээтэй холдоно.

Хувь заяаны цулыг хэрчих гэж

Билүүтэй мэтгэлцэж галзуурсан

Хутга мэт хөх зэрэглээ

Бид хоёрыг салгаж урсана.

Хоёр талаас нь бидэн хоёр

Холын дуртгалаа урж шиднэ

Жам руу бидэн хоёр

Зэрэглээний хоёр талаар очно.

Зэрэглээ урсана.

1991.06.10

Тоглоом буюу үхлийн Рапсоди

(Дууль)

ОРШИЛ

Мөнхөрлийг үхэлд булаалгасан

Мөхөс заяат хүмүүн гэгч

Амьдрал хэмээх хатуу тоглоомыг

Амьдын зайд өрж тоглоно

ӨРӨЛТ

Нүүр нүдгүй

Нүцгэн үнэн

Үхэл-дэргэд

Үзэгдэхгүй хүлээнэ

ТОГЛООМ-ХҮН

Нүгэл буян хоёрт

Бүдчин тоглоно

Нүд нүдэндээ унаж

Дурлаж тоглоно

Тэнэг цэцэн хоёрт

Хуваагдаж тоглоно

Тэнгэр газар хоёрыг

Аргадаж тоглоно

Агаа хорсол дунд

Шатаж тоглоно

Айдас баяр хоёрт

Өртөж тоглоно

ӨРНӨЛ

Буруу зөв адил үхлийн өмнө

Бурхад хүртэл хүчгүй

ӨРӨЛТ

Төөрөг заяаны төгсгөл дэх

Түрэмгий-үнэн үхэл хөндөлсөнө

ХУВИРАХУЙ

Нулимс тэнд

Бороо шиг асарч

Яс тэнд

Цас шиг бударна

Мартахуйн манан

Тоосрон бударч

Магтаалын малгай

Эзэнгүй нисэлдэнэ

Алдсан оносон

Бүгд цагаатгагдаж

Аниргүйн хаан

Үгүйг гишиглэнэ

Алдуурсан сүнс

Хорвоогоор тэнэнэ

ӨРГӨЛ

Үхэл рүү

Үнэн лүү

Бид явж амьдарна

Он цаг

Орчих тутам

Ойртон ойртож амьдарна

Дэлхийдээ шингэх гэж

Дэндүү богинохон амьдарна

Алаггүй үхэл чамайг

Амиа өгч шагнана

Үхэл...

Үнэн...

Гэрэл сүүдэр хоёрын яриа

Сүүдэр

Орчлонд

Оршин буй бүхэн хоёул бүлгээ . . .

Бодь бие-чи

Хий бие-би

Гэрэл

Чиний оршихуй надаас шалтах. . .

Чамайг байлгах гэж.. би шатах. . .

Хөдөлгөөн

(Бүрэнхий-гэрэл сүүдрийн завсраар шагалзана. . .

Бүдгэрсэн дуу аниргүйд шургана. . .)

Сүүдэр

Хэлбэрийг дагаж-би бүрэлдэх

Хэлтгийг дагаж-ус урсах

Гэрэл

Чулуу-цэцгэн дэргэд

Чамайг би зурах

Чухамдаа сүүдэр чи

Миний хүчинд байх. . .

Хөдөлгөөн

(Ихэмсэглэл-номхоныг хэмлэнэ

Их холд нохой яс булаалдана)

Сүүдэр

Хүмүүнийг чи гэгээн аргамжаанаасаа алдаж

Хүйтэн жамд булаалгах бүлгээ

Би дагасаар

Битүү харанхуйн цулд нийлж залиран одмуу

Газар дээр асгаран үлдэж

Гарцаагүйн жамыг чи залилмуй

Гэрэл

Үгүй дээ

Үхэгсдээс уллаж чи үлдмүү . . .

Ирэх нэгнийг хүлээж

Эхийн умайг отмуу . . .

Сүүдэр

Мөнх бусын өмнө би

Унаж үлдэх дор. . .

Мөхөл бүхний

Уйт хар дэр

Гэрэл

Алагласан ертөнцийн дугуй хээний

Алга, ар шиг хоёр тал

Илч хүйтэн хоёрын чанараар

Элдвийг өгүүлэн үнэнийг юунд хэмлэлцэнэ

Хөдөлгөөн

(Салхи зөөлнөөр сэвэлзэхэд

Хөнгөн бүхэн сэвэлзэн

Санаандаа үл захирагдан

Хэн хэн лүгээ цуглана)

Сүүдэр

Халуун өөрөөсөө-хүйтнийг нэрж

Цагаан өөрөөсөө-харыг нэрж

Нэгэн биенд оршиж

Нэрээ л салгаж тогтмуу

Гэрлийг магтан дуулагч тодруулан хашгирагч

Гэнэн дуу мину-жамын цуурай

Гэрэл

Үгүй дээ чи миний

Өнгийг хэгзлэгч туурай

Сүүдэр

Сүнснээс бусдыг би дагамуу . . .

Сүүдэр гэрэл шиг мөнх ажаам

Гэрэл

Амьдыг дундаа бөмбөрүүлэх бидэн хоёр

Алаглан орших юун харш

Нүдний алаг бид хоёрыг дуурайж

Нүгэл буян хоёр бид хоёрыг дуурайж. . .

Хэлмэр

(Хүмүүс сэтгэлийнхээ хэрээр автугай хэмээн

Гэрэл сүүдэр алаглана

Хүмүүс мөхөсийн зорготоо дийлдэн

Сүүдэр цуглуулах бүлгээ

даарна даа)

Үхсэн амьд хоёрын яриа

Би-

Баяр нуугдан гуниг нүүрлэсэн өдөр

Баруун хойшоо та хэвтээгээрээ явсан

Инээд дүрвэсэн тэр газар

Их олон хүн уйлсан (дутаагүй)

Үлдэгсэд нь хэрхэн харуусдгийг

Үзэх гэсэн хүмүүс очсон (илүүдээгүй)

Хэлэхийг сонсохгүй болсон хойно чинь сайхан үгсийг

Хэлхээ нь тасарсан сувд мэт асгасан

Жилийн дараа гэргийтэй чинь суух хүн

Жигтэйхэн гунигтай эхнэрийг чинь түшиж байсан

Живж байгаа онгоцны эцсийн шураг тэврэх далайчин шиг

Жингүйдлийн дундаас тулах цэг олсон мэт налалдаж байсан

Орчил

(Хатсан намагт мэлхий дэвхцэж, дуугаараа өөрийгөө норгоно

Хайлган шувууд уснаас загас шүүрч, буцааж алдана)

Үхсэн хүн-

Аяа чи “халуун” хүмүүн. . .эвдэрчээ. . .

Амьдын ховыг үхсэнд нь зөөх бүлгээ. . .

Би-

Ингэхээс буцахгүй болсон хүмүүн

Их болсны гайгаар . . .би үүгээр өвдөв.

Цэцэг нь хөл ороон ургаж

Цэцэн тэнэг ялгалгүй холилдон орчих аж

Амьдын “лайт хүмүүн” учир

Ангид би хаана оршино

Сэтгэлийн хор дундуур туучсан юмаа

Сэв суугаа байлгүй. . .

Амьдын хар нүгэл дундуур явсан юмаа

Ад шүглээ байлгүй

Үхсэн хүн-

Чиний зөв агаад буруу. . .

Чимээгүй . . . намдуухан ярь

Мөрөөрөө явсан яс доргиж

Мөч мөчөөрөө салах нь

Ярихаасаа өмнө боддог нь ухаантайд

Ярьчихаад боддог нь тэнэгт “очдог”

Би-

Жамыг гаталсан учир та уужуу бүлгээ. . .

Зусрын хорвоод иймийг эс үзсэн гэж үү дээ. . .

Үхсэн хүн-

Эхийн тунамал шиг цэнхэр орчлонд

Их удсан . . . би зуурхан байсан . . .

Живж байгаагүй

Хөвж байгаагүй

Уусч байсан . . .

Би өрөм байгаагүй

Хусам байгаагүй

Сүү байсан. . .

Цагаан өнгөөр алт цус хоёроос бусдыг сүлдэг хорвоод

Цагийг идэж-насыг уусан . . .

Үүнд энэлэлтэй. . .

Орчил

(. . .Зовсон цагт

Ус эргэн дундаа гаслана

. . .Халууцсан цагт

Ус эргэн дотроо буцална)

Би-

Үхсэнээсээ амьд нь олон гэвч

Амьдаасаа үхсэн нь олон. . .

Үгүйн мананд бүдгэрснээ санах нь цөөн

Үхсэн хүн-

Мартаагүй байх

Магадгүй би хааяа хэрэг болдог байх. . .

Амьдаас нь харамласан магтаалаа

Над руу асгаж

Үхсэнээс нэхэхгүй гэмийг

Надтай мартаж гэж. . .

Орчил

(Нулимсын гашуун бороонд

Уул нэвт норжээ. . .

Нугын ногоон нам гүмд

Ус, өвс хоёр хэрэлдэнэ)

Би-

Өдийд та амьд асан бол

Өөрийнхөө үзсэнээс илүү юм үзэхгүй. . .

Хүн хүнээ идэж байна

Шүдээрээ, тархиараа бие биенээ зажилж

Шүлсээрээ үнэн рүү нулимж байна

Ам ходоодондоо бус

Авс, газар хоёр руу залгиж байна

Арга заль буйлж

Арьсан дотроо хүн “ясгүй” болох нь. . .

Орчлонгийн булайгаас дайжсан

Үнэн хүн чанар хоёрын сургийг танаас сураглах ичиг. . .

Үхсэн хүн-

Чи битгий бүүвэй аял

Талимаарсан тэр аялгууг сонсвол

Там диваажингийн алинаас ч би зулран дахин төрнө

Чи уйл

Чамайг уйлах тусам чинь би

Цочихгүй бөх нойрсоно

Цагаа олсон үхэлд би улам дасна

Орчил

(. . .Нулимсын гашуун бороонд

Уул нэвт норжээ. . .

Нугын ногоон нам гүмд

Ус, өвс хоёр хэрэлдэнэ

Мөнх бусын булайгаас

Мөнхийн юмыг аврах гэж шоргоолжнууд гүйлдэнэ)

Хэлтгий Нанзад

Дууль
Нарны ааг амтагдан
Гангийн халуун хөлбөрч
Цэцэгний иш өлдөн
Дэлбээ нь газар шургачсан
Тэр зун
Хөхүүл ингэний дэлэн айж
Зовсон сүү гарна.
Хээлтэй гүү бүхнээс
Босоо унага төрнө.
Эрэл сурлын хүн болгон
Айдас ганзаглаж ирнэ.
Ээрэм цагаан талд
Дайны зар нүүгэлтэнэ.
Хэзээний цовоо Хэрлэн
Уулын сүүдрийг булгин
Хээнцэр цагаан сарыг
Мандал дээрээ үнгэнэ.
Хэм яруу долгио нь
Хамгаалах хүүтэйдээ бардам
Хэлж ердөө барагдахгүй
Газрын туульс бурна
Хэлтгий Нанзад

Хэрлэнгийн хүн

Хээгүй төрсөн

Хөдөөний хүн.

Хөвөөн дээр нь зусахад

Дэрэн доогуур нь урсаж

Хэрлэн тоонотдоо өвөлжихөд

Босгон доогуур нь урсаж

Хэрлэн Нанзад хоёр

Бие биен дотуураа жаран жил урссан ч

Намуун Хэрлэн Нанзадад

Нас өгсөн болохоос хүү өгөөгүй.

-Эрх Хэрлэн чи минь намбайгаад

Эрмэг мөрөн юмуу даа

Зүүдэнд ч болов хүү үнсүүлж өгөөч гэж гуйсан

Зөрүүд Нанзадын гуйлгыг

Хэрлэн тоогоогүй

Хэлтгий заяаны өмнө горьдлого цайж...

Хоног хоногийн хуурайнд насаа үрж явж...

Малын хошуу эргүүлж

Хөлтэй буянаа тууж явахдаа

Мяралзах Хэрлэнгээ аргадаж

Урсгалыг нь даган гэлдэрнэ

Үдэш өглөө ялгалгүй

Хэрлэнгийн гүүрний дэргэд тамхиа нэрж

Үлэг гүрвэлийн зоо шиг

Гүүрний тэнхээг тагнайдаа шагшина.

Омголтсон уруул бүхэн

Тэдний цайнд цангаа тайлж

Оройтсон бүхэн тэдний гадаа тохмоо сэврээнэ...

Долоон сарын дундуур

Халуун гээчийн өдөр

Дорно руу цувсан

Цэргийн цуваа гүүр гатлав.

“- Цаг бишидлээ

Цайгаа үйгээрэй!

Цангаж яваа вий!

Цэргийн хүүхдүүд” гэж

Эмгэндээ захичихаад

Эр цэргийн цувааг Нанзад тосов

Гэгээн өдрөөр

Гэрлээ асаачихсан машины цуваа

Тоосон дундаа

Торолзох төдий

Архирах машины дуу

Тэнгэр язрам сүртэй

Айсан одод тэр шөнө

Цөөн түгсэн санагдана.

Цувааны их зам дээр Нанзад зогсон

“- Цугаараа буугаад гар!

Цай уу!

Манайх тэр” гэж заан

Манарсан тоосон дунд хашгирна.

Аман дотор нь элс шажигнаж

Мөрөн дээр нь тоос дарна.

Харсан нь гараа даллана.

“- Хай зайлуул, их яаруу! яваа улс” гэж амандаа үглэнэ.

Торойн бүртийх Нанзадад

Тоос бүгдээрээ шингэх шиг газар амсхийв.

“- Эргэж ирэхдээ буугаарай

Эсэн мэнд яваарай!” гэж үглэсээр гэрээдээ эргэв.

Дайчин цувааны дуулианд хөөрсөн хонины хээр нь

Далавчтай юм шиг товолзтол алхална.

”-Амсаад явсанд тооцоорой

Амар мэнд яваарай!” гэж

Думаа эмгэн

Дээж өргөнө.

-Аавын сайхан эрчүүлийн цангаа тайлах

Аз дутлаа! Чиний

чанасан цай! гэж Нанзадыг хэлэхэд

Бүх л юманд өөрөө л буруутай юм шиг

Бөртөгнөсөн эмгэн нь ханцуйдаа уйлна.

“Дэндүү хэлэв үү дээ! Хөөрхий минь

Дөчин жил бие биенээ

налсан юмсан” гэж эмгэнээ өрөвдөнө.

-Надад заяагаагүй энэ олон хөвгүүдийн

Хэд нь эргэж ирэхгүй бол гэхээс

Эрийн харам нулимс

Дэрэн дээр нь унах нь

Гэрийн дээвэр балбах

Намрын ботгон мөндөр шиг

Энэ гашуун бодлыг нь таасан юм шиг

Эмгэн нь урт гэгч нь санаа алдах нь дуулдана.

Нар хур тэнцсэн

Найман сарын сүүлчээр

Дайчин цэргийн цуваа

Дорнодоос баруун тийш хөвөрлөө.

”-Тээр! гараад ирлээ, цэргийн цуваа

Хэлээгүй юу?

Тэнгэр газар амарлаа

Хөгшин минь.

Өглөө амгайлчлахад, хонины хээр минь

Өлзий зөгнөн эвшээж байсан юм

-Ядраа тайлам цайгаа зутагнаарай!

Явдалдаа алжаагаа биз, цэргийн хүүхдүүд

Яаралгүй яваа байлгүй

Ялалт авчирсан ачтанууд. . .” гэж

Эмгэндээ “захичихаад”

Эрвэлзтэл хатируулан цэргийн цувааг Нанзад тосов.

“-Буцахдаа бууна! –гэж та нарыгаа хүлээгээд

Буурь ч сэлгээгүй!

Буугаад гар!

Буурлын минь цайг амс!” гэж

Бужигнасан тоосон дунд Нанзад хашгирна.

Аз жаргалын үрийг цацаж байх шиг

Цэрэг бүхэн гараараа даллаж өнгөрөв.

Амар амаглангийн цэнхэр дуулал

Хэрлэнгийн хөндийд багтаж ядан хоцров.

-Агаатныг дарсан энэ олон сайхан эрчүүд

Аав, морь хоёртоо яаралгүйч яахав дээ!-гэсээр

Мөрөн дээрээ унасан, их замын тоосыг ч

Хайрлахын эрхэнд гүвж чадалгүй зогсож

Мөнгөн зоотой Хэрлэнтэйгээ хоёулаа

Харцнаасаа алдууртал цувааны хойноос ширтэв.

Домбон ёотон

Дууль

Намайг өсгөсөн

буурал ээж, Тогоочийн дурсгалд

1.Хууч хөөрөх олноо өргөгдсөний наймдугаар он

Миний эмээ залуудаа :

Нүд зүсний нь сайханд

“Нүүл хавхаастайн” харчуул

Морьтойгоо

Гоёлтойгоо унаж байсан ч

Нэгэнд нь ч инээд дэвсээгүй үзэсгэлэн явж. . .

Миний эмээ-заяандаа

Нүгэлт хар гөрөөчний

Амраг нь болон дэлгэрч

Ханилгаатайн

Хайртайн идийг үзүүлсэн

Нэгэн цагийн шагшаан байж. . .

Хавийн сайхан хүүхнүүд

Торго эсгэж суудаг байхад

Ханиа аваас ирэхий нь хүлээн

Ганзага юунд нь залбирсан

Хангай хишгээ хайрлавал

Арьсы нь шалбалах гэж зэхэн

Хатан хутганы ирийг

Хялгас тасартал билүүдсэн гэргий байж. . .

Авааль үнэнч гэргийн

Заяа нэгэн хөрвөж

Араараа модтой ууландаа

Өвөө минь залуугаараа жаргаж

Насны тунгалаг бага үдэд

Эмээ минь хөл хүндтэй үлдэж

Найм дахь отгон хүүгээ

Нулимсан дээрээ унагажээ.

Хүсэл бүтлийн түшиг

Хань нь унасан гэрийн

Хүйт орогносон зайг

Хатамжийн сэтгэлээр нөхсөн ч

Цагийн хонгор хэлхээн дунд

Хутганы ир нь мохож

Цадах, өмсөхийн хомсхонд

Хүүхдүүдийн шүд нь ир оржээ.

Хөл нь сөхөрсөн цахиур буу

Утаа исэнд мэрүүлж

Хөдөлгөөнгүй бүхнийг элэг барьдаг

Аалзны шүлс хэржээ. . .

Санаа сэтгэл хазайхад

Сар нь жил шиг урт хорвоо

Сайн сайхан явахад

Саадагны хөвч шиг богино хорвоо

Үрчлээт хатуу алгандаа эднийг

Есөн шагай шиг бөмбөрүүлсэн ч

Үрс нь мэнд торниж

Дөрөөн сур тэнийлгэжээ.

Мартагдсан бууны хүхээ цахьж

Чивчирсэн гунигийн эрч суллажээ.

Үдийн тарчиг сүүдэрт

Хормойд нь багтахгүй найман үрээ

Үйл заяаны золионд

Чулуу дэрлүүлэлгүй бүтэн өсгөхдөө:

-Зовлон заяаж дээ гэж

Бүсгүй богино бодолдоо

Бүдэрч явсан өдөр олон чиг

Бүрхээд цэлмэдэг тэнгэрийн

Бүхний наран зайлаагүй!

Сэхүүн сэтгэл шунал хоёр нь

Багтаж ядсан баян Ширэг

-Сэрхний минь сэмжээр

Гэрээ бүрэхгүй юу? гэж дайрахад нь

Найман бүргэд бууж нисэх болохоор

Бядтай хөлий нь аяыг даахгүй

Навсайчих байлгүй дээ!

Навтсаараа л больё доо гэж

Үр түшигтэй сэтгэлийнхээ

Хошлонг нэгэн чангалж

Үгнээс хүртэл амьдралаа өмөөрч

Үгүйдээ гуталгүй өөдрөг байж

Намрын хүйтэн хяруун дунд

Хөмөн гуталгүй өлчиржүүлж,

Нарны гал халуунд

Алга сүүдэргүй галшуулж,

Үгүй дугуугийн зовлонг

Алхам бүхэнд нь шингээж,

Үнэнээрээ явахын сайхныг

Нас бүхэнд нь даруулж,

Ардаа үүрч, элгэндээ тэвэрч өсгөсөн

Амьд халуун найман тахил.

Аминдаа зөв, найман танхил үр нь

Жаргалын найман морь шиг

Тарваж эрхэлж өсөөгүй ч

Жалгын намхан сухай шиг

Хамуулд даруулж гудайлгүй

Жавар нар хоёрт боргошин

Хүн чулуу шиг хатуужжээ.

Арван зургаан алган дээр

Сүүдэр унаж гэмээнэ

Амьтны царай харахааргүй

Зовлонгийн тохом сэвэрч,

Ардын жаргал дэлгэрсэн

Хорин нэгэн онтой

Ачит буурал эмээ минь

Тавь хэлтийлгэж золгожээ.

2. Дууль өрнөх, нэгэн мянга есөн зуун дөчин дөрвөн он

Дайны хөл

Дэргэд биш ч сэтгэлд

Дандаа сүүдэр шиг даган

Хүн бүхний хажууд

Тэр холын

Тэгсэн мөртөө

Хамгийн ойрын дайн

Тэнгэр газарт

Шүглээгүй газаргүй хатуу цаг

Идээштэл орхих цайгүй болохоор

Тогоо усан хаяа татаж,

Элхэндгийн* навч эргэлдэн

Гавьтай ааггүй богшино.

Туж тамхи гувшдаг

Аавын мод толгой өлөн.

Туулайн хоргол түүсэн өдөр

Утаатайхан бохьшино.

Гурил будааны уут

Нугалаагаараа сэмрэм эвхээстэй

Гуниг зовлонгийн манан

Зүрхний оройд татаастай.

Эмээ минь өглөө бүхэн

Өлзийгүй зүүдээ адална.

Эцэг минь гал ширтэн

Ахыг бодоод суучихна.

Өглөө болгон би эмээдээ

Нар дотор нь мандсан

Шанага сүү хүргэж өгнө.

Өө миний хүү ирлээ! гэж

Өвөр дээрээ суулган сэвлэг илж үнсэнэ

Үдэш болгон би эмээдээ

Түрүүчийн од хөвсөн шанага сүү барьж

Өөтэй газар бүдэрч, цалгиасаар хүргэж өгнө.

Үр минь айсангүй юу! гээд эмээ

Хөлийнхөө авдрыг ухаж

Давхар давхар боодолтой

Домбон ёотон гаргаж

Дотоод хормойгоо дэвсэн

Хичээнгүй нь аргагүй сэлтэлж

Долоодын цагаан цахиур шиг

Хэлтэрхий нэгийг өгнө.

Сүү эмээдээ хүргээд

Ингэж шагнуулдаг ажлаа

Сумын даргын албаар ч

Яавч би солихгүй байсан.

Эмээд минь

Энд тэндхийн хүмүүс чихэр будаа өгнө.

Эрэлчин суралчин

Эмээгийн д бууна.

Энд тэндхийн сонинг

Эмээ минь л эхэлж сонсоно.

Гэлээ ч гэсэн

Ная гарсан эмээтэй минь

Наймаа хэлцэх хүний яриаг би сонссон.

Намуухан тэр үдэш

Чихээ туурганд шигдтэл нааж зогссон.

Гэр чагнадаг хүн муухай гэсэн

Гэрийнхнийхээ хуулийг тэгэхэд нэг зөрчсөн.

-Таван цэнгийн алтан ээмгээ заръя!

Тал шуудай гурилаар өгье! гэж

Танихгүй авгайн ярих сонсогдсон.

-Эмээ нь алт зүүж

Чихний омгоо дарж явж үзсэнгүй.

Идэр явахад,

Айлын минь юмтай хөгшин өнгөрөхдөө

Ам нь ангалзаж

Амь нь тэмцэх мөртөө

Алтан бөгж ээмэг хоёроо заагаад

Ам руугаа хий! гэж зангаад байж билээ.

Сүү гэхийн оронд

Алтаа заахыг бодоход

Сүрхий л донтой эд билээ! гэх нь дуулдсан.

3. Дууль жаргах 1945 оны намар

Хожуу намрын орой

Азарган бороо асгарч

Холдсон тэнгэрийн дуу отголон

Зулай дээр цуглан тачигнаж

Хойд уулын оройгоос

Харвасан зэл шиг алдуурсан цахилгаан

Урд хөндийн

Унтсан унага шиг толгодыг шавхуурдсан орой.

Аавынхаа одончуу цувны юүдэн доор

Алдхан бие минь шанагатай сүүтэйгээ багтаж

Амгалан буурал эмээгийнх рүүгээ

Хөлийн хурд сориход

Аймтгай тунирхуу сүүн дотор

Борооны ус шомболзоно.

Аянга цахилгаан цахихад,

Барьж яваа сүүний

Ар нь хага ярагдан

Шанага хуваагдах шиг санагдана.

Орсон их борооны ширүүнд

Нялх хөл бээрч

Орохдоо би босгонд нь тээглэн,

Шанагатай сүүгээ асгачихав.

Чийг зуусан аргалтай шээзгий доогуур нь

Чиг зүг алдран, сүү мэлтийтэл урсав.

-Олз орох нь миний хүү шиг!

Яхав, яхав асгараг!

Овоо доо! Миний хүү

Бороотойд ч эмээгээ мартаггүй

Дундрааж болдоггүй

Цагаан сүүний нэхэл хатуу гээд

Духан дээр минь

Ядам хуруугаараа асгарсан сүүнээс түрхэв.

Май миний хүү! гээд

Домбон ёотонгоо бүгдийг нь өгч

Мартахын аргагүй сайхан инээдээр

Нэмж бас шагнав.

Сүүгээ авчраад

хэлтэрхийгээр нь шагнуулдагсан

Сүүгээ асгачихаад

бүтэн ёотонгоор шагнуулсандаа

Гайхах баярлахын хур

Гадаах бороотой давхцан асгарав.

-Дайн дууссан! гэж эмээ хэлээд

Даахий минь үнэрлэн тэврэв.

Эмээгийнхээ дэлгэр өвөр дээр хярж

Эмтэлж идсэн ёотонгийн амт

Хамгийн том ахын минь

Халхын голоос явуулсан ялалтын амт байсан.

1982. Заан тэрэлж

Зургийн шувуу

Дууль

. . .Давжаа шувууны зүрхийг

Дайрч сөрлөсөн тохиол

Далинаас нь унасан өдөөр

Сүлжиж бичсэн дууль. . .

Зохиогч

Хуучин сүмийн дээвэр доор

Шувуу шувуундаа жиргэнэ.

Хошуу хошуугаа нийлүүлэн

Шувуу шувуундаа дуулна.

Гонхны дай модон дээрх

Зурмал шувуунд өт зөөж

“голоод идээгүйд“ нь гомдож

Үхтлээ харамсах шувуухай .

Бусдын жиргээнээр үсчин

Будгийн шувуундаа жиргэнэ.

Хүйтэн хошуунд нь хошуугаа наан

Бүтэн өдөр уйтай хагшина.

Алгын чинээхэн далий нь

Аяар аяархан тоншиж

Агаарын мөнгөн цээлд живэн

Амраглан тоглоё! гэж жиргэнэ.

Хөдлөхгүй мөнх ”аашинд” нь гомдон

Хөөрөх өдөө зулгаан уйлна.

Хөх тэнгэрийн одод дэрлэн

Хөлийн тушаа нь үүрээр нойрсоно.

Будгий нь бүлээсгэх харуу нойронд нь

Буйлсан жаргал, тэнгэрийн зүүд

Өглөө дахиад л амтат нойрноосоо

Өнчин сэрж бөөр нь жиндэнэ

Эргэн тойрны сайханд

Элин халин уусна.

Эцэс төгсгөлгүй хайрандаа

Эргээд дорхноо бууна.

Уйтай зургийн шувуу

Элгэн дунд нь хярж

Уйдахын аргагүй хайр

Зүрхэн дунд нь үерлэнэ.

Солонгын долоон өнгөний

Үзүүр зууж нисэж ирнэ.

Сортой мөнгөн төглийн

Үнэрийг дагуулан нисэж ирнэ.

Өндөрт мандах нарны

Илч түүж нисэж ирнэ.

Өвсөнд буусан шүүдрийн

Дусал балгаж нисэж ирнэ.

Сүм тойрон хэдэнтээ эргэж

Сүрэл дэрсний хугархай түүнэ.

Хавь ойроор хэрэн тэнэж

Хялгас шавар цуглуулж хөлсөнө.

Үр мөнхийн хорвоог мялаах

Үүр засан хөл алдана.

Тэртээ үүлсийг сүлбэн нисэж

Тэнгэр газрыг хөвөрдөн халина.

Хөдлөхгүй өндөглөхгүй зурагнаас

Удмын үр горьдон зүтгэнэ.

Хүсэл хайраар бүтсэн үүр нь

Улирах цагт мөнх хоосон.

Тэвэр тэвэр гунигтаа бүдэрч

Дэвэн дэвэх жигүүр сурьдаана.

Тэнгэр дүүрэн шувуудын дунд

Тэрэн шиг сайхан нь үгүйг гайхна.

Харах бүрийдээ хайр нь хүрч

Хагших бүхэндээ дуугаа барна.

Сарны цагаан туяа сөхөрч

Санааны зөөлөн үзүүр нь хөхөрнө.

Далиа сийрч сэмэртэл илж

Илчээ харьж барагдтал тэвэрнэ.

Хошууны ирээ мохтол үгсэж

Хуурай болтлоо мэгшиж хагсана.

Зузаан хөвч шар навчаар халуурч

Зуурдын хагацлаар ой нүцгэрэх намар

Явгалсан мананы хөлд чийгтэж

“Янаг” зургийн хагас нь салхинд хийсвээ.

Тал биенд нь залгаас болон

Тавилан хагасыг бүтэн болгож

Өндөр тэнгэрийг жигүүртэйгээ цуг мартаж

Өвөлжин тэр хагацлаа дэрлэв.

Хаврын шуурга, догшин хавсарганд

Хайрын шувууны үлдсэн бие нь хийсэв.

Хоосон зайг дүүрэн болгон

Хохио дуудан хаваржин дэрвэв.

Нар өрөмдөн хүрээгүй өндөртөө гарч

Навчин далиа хумин газрын хатууг шилэв.

Намар оройн ингэн туйлдаас шиг

Намисан өд тэнгэрээр нэг будрав.

Үүлгүй тэнгэрт шувууд жиргэж

Үхэлд дөжирсөн хорвоо хэнэггүй. . .

Орой, өглөө, шөнө, өдөр

Он жилүүд огтхон ч завгүй! . . .

1982. Тунгалаг билэгтийн сүм

Орон зай

(Дууль)
Байдал
Орчлонгийн хөх тойргийн
Гуниг баярын цэг
Голын сайр ширдэглэсэн
Гурван цоохор өндөг...
Дотор нь тэнгэрийн зүүд унтана.
Дундуур нь нарны гэрэл урсана
Орчлонгийн
Орон зайнаас
Гурван бөөрөнхий зай
Гурван битүү заяа булааж
Амь хальстай лугшина
Аз эзтэйгээ унтана
Хөх ногооны зэрэглээ
Хэлбэрий нь эвдэнэ
Харуу эх нь сарвалзаж
Хатуу газрын тарни уншина
Тэднийг
Хөөрөх тэнгэр
Хөөх харцага хүлээнэ
Тэднийг
Хөх сүндэл

Цагаан үүл хүлээнэ

Хажууханд нь

Эрхий ороох нялх зэгстэй

Сохор нуур

Эргийн саарал чулуугаа

Самардаж тоолно

Жин үдийн үүлс

Нууранд үйж

Жингүйдэн хөөцөлдөж

Хөлбөрөн норно

Тойрог өнцөг хутгалдсан

Тоостын их орон зайд

Үүсэл мөхөл

Үгүй буйтайгаа

Авцалдан

Алалдан

Арсалдан

Аргадан

Оршиж эс оршино

Нуур дотроо давстай

Өндөг дотроо шувуутай

Нуур болгон давстай байхгүй

Өндөг болгон шувуу болохгүй

Харин...

Нулимс болгон давстай нь

Хачин...

ХӨДӨЛГӨӨН

Цагаан тоосондоо бүрэлзсэн

Цангасан адуу нуурын зүг айсуй

Айсуй хөлд нь

Чулуу үсчиж

Адууны сүүлэнд

Тэнгэр ширэлдэнэ

Усны үнэр

Адууг чангааж

Уулсын хошлон

Чимээнд чивчирнэ

Дэлээ илдлэн дэргэх

Догшин аадар шиг морьд

Хөлтэй түймэр

Тогослон шатаж

Галтай чулуу

Тортоглон буцлах шиг...

Аралтай нуур руу

Адуу сумлан

Огторгуйн алчуур сүүлт од мэт

Оорцог толгодоор будран айсуй...

Хэсэг дэрсний ёроолоос

Хэвлээр газрыг илэгч

Эрээн зүстэй сур

Элэг шалдан могой

Чимээнд бас доргиж

Чигээ буруулан мурилзав

Авиа шуурахад гай мэдэрч

Амиа нуух зай тэмтчив

Азын шооны гурван нүд шиг

Алган чинээн үүр тохиов

Амин хоохойн сэрэл сүүхээлж

Агшнаа тэр үүрийг гурав ороов

Уурагандаа халуурсан

Унага ч гишгэдэггүй шувууны үүрийг

Амь тэмцсэн могойд

Амирлангуй бурхан

Ад зэтгэрийн

Аль нэг нь

Ам булаалдан зааж өгч...

Урийн ус мэт адуу

Уул уулын дундуур

Багтаж ядах мөртлөө

Урссан сүү мэт адуу

Умгар үүрийн дэргэдүүр

Бусган займж өнгөрчээ

Өндөг могой хоёр дээр

Өлөн тоос бууж

Өртлөөс гэтэлсэн могой

Чивчирсэн биеэ суллав

Тоос цэцгэнд бууж

Толгод дуниаран чимээ дарав

Нууранд буусан үүлсийг үргээн

Адуу усанд орж

Нугас ч хөдөлгөөгүй тунгалагыг нь шилэн

Ариун усны өрмийг шимэв

Омруунаас нь унасан ганц дусалд

Од ойчих шиг цагираг дэлхэнэ

Мундаан дээр нь

Лүндаа мандсан морьдыг харахад

Хуурай газарт ааг нь багтахаа байгаад

Нойтон усанд хөлөглөсөн

Хувилай сэцэн хааны онгоцны сэлүүр

Номхон далайг цавчих шиг санагдана.

ЯВДАЛ

Энэлэн амирласан могой

Мэсэн толгойгоо цогнойлговол

Эрүүн доор нь хоол

Эргэн тойрон нь нам гүм

Тээр болох нэг ч аниргүй

Тэртээ дээр ганц шувуу
Газраас аргамжаатай дэрвэж
Гаслан ганганан сарвалзана
Цулбуурын чинээн амиа
Морин туурайнаас булаасан
Чухмын нэгэн ач гэж
Мэдэх сэрхүйгүй могой
Ач болсон өндөгний нэгэнд
Амаа эвлүүлж эхлэв.
Хомхойн сэтгэлд ухаан тавьж
Хоёр өндгийг залгиж
Хөхтэй байгаагүй хүйтэн могой
Бөхтэй юм шиг болсон могой
Идшээ дааж ядан
Их бутанд шургав
Өнчин өндөг
Үүрэндээ хазайн торойж
Өрөөсөн зайнд нь
Тэнгэрийн өөдөс унав.

1995.05.28

Хайрын сүнс

Дууль

“Тал дээр тавьдаг яс байна

Тамд очдог сүнс байна

Тавилантай насандаа бүтдэггүй юм бол

Тамын чинь үүдэнд заргатай болно

Элсэнд тавьдаг яс байна

Эрлэгт очдог сүнс байна

Энэхэн насандаа бүтдэггүй юм бол

Эрлэгийн чинь үүдэнд заргатай болно...”

/Монгол ардын дуунаас/

ОДОХУЙ

Үйлийн үр огтлолцох

Зөрөг дээр хормой шүргэсэн

Үг хэлэх шиг нүдтэй нь

Харц мөргүүлээд авсан хархүү

Тэр сайхан бүсгүйд дурлаж

Тэсгэл хатуу хайрын

“Лай”-д унажээ.

Хосын сайхан жаргалын хаяа дэрлэж

Хохийн хэцүү заяаны

“Зай”-д үйжээ...

Их хайр эрхэмсэгийн учир

Ид хавын тэнгэрт мандаж

Царайчилсан хайр хүчгүйн учир

Цагийн хөлд хэлтрэн үлдэж

Зүрхэн дотор нь бүсгүй оршиж

Зүүдэн дотор нь буйлан тонгочиж

Эс бүхний нь дотроос нь шатааж

Эрлэгийн босгон дээр зүлдлэн авчрав

Хожимдсон хайрын дэндүү гаслан

Хохирсон тавилангийн хатуу хяслан

Амьд насных нь гэнэн дурсгал

Ахиад заяахгүй гэгээн үзэсгэлэн.

Аль аль нь зам салгах

Алтан жамын уулзварт ирэв

Амдаж ядсан хархүү

Азаар бас нэгэнтээ

Араалдаж нүүсэн үүлэн сүүдэрт

Аравдын сарны гэгээн завсар

Алаг нүдий нь ширтэн байж

Арай ядан хэдэн үг сольжээ...

-Чамин хорвоог орхисныхоо дараа

Чамд би хүү болон төрж

Харамласан уруулаар чинь

Гуйлгаж үнсүүлж

Халуун цагаан сүүгээр чинь

Цээжээ дэвтээж өснөө гэжээ

Галзуу хүнтэй ч уулзчихав уу? гэсэн шиг

Гайхсан бүсгүй үгий нь чихнээсээ гулгиж

-Хачин юм гэж

Гайхаш бөмбөрүүлж ядан

Харих зуураа бодмоглож

Гадаа үүдэндээ гээжээ...

Үнэн хайрын буулганд

Үйлээ эдэлсэн хархүү

Бэлийн замыг элтэл

Биеэ барж тэмтэрсээр

Сэтгэлээсээ эхлэн үхэж

Сэмрэн сэмэрсээр унав

Бүтээгүй хайрын орчлонгийн

Өндөр босгыг гадагш давж

Бүлээн чулуу дэрлэн

Өөд болон талийжээ.

ЭРЛЭГИЙН БАЙЦААЛТ

Эрлэг асууруун:

Өргөөл гэж хэлээгүй байхад

Өөрөө морилж ирсэн чи...

Хархүү хариулруун:

-Үнэн юм шоовдор хорвоод

Үлдье гэхнээ тогтох газаргүй

Үйлийн үргүй сайхан түүнд

Үхсэн хойноо ч би хайртай

Эрлэг асууруун:

-Энэ хайр гэдэг чинь юу юм бэ?

Эрлэг надаас хүчтэй гэж үү

Хархүү хариулруун:

-Эрлэг та харахааргүй

Эс бүхэнд минь шингэсэн эз юм

Эргээд миний сүнснээс ч зайлахгүй

Энхрий гашуун ад юм...

Эрлэг асууруун:

-Ухаан юм уу?

Уул юм уу?

Ус юм уу?

Цус юм уу?

Хархүү хариулруун:

-Эхэндээ солирсон ухаан юм

Эр эм хоёр уул юм

Эргэндээ багтаагүй ус юм

Эвлэж бүрэлддэг цус юм

Эрлэг асууруун:

-Тамд тогтохооргүй санагдах уу?

Тасдаад чамайг хаясан ч үлдэх үү?

Хархүү хариулруун:

-Там диваажин хоёрын алинд ч...

Тарж цайсан ясанд минь ч ...

Үйрсэн бие минь буцан цуглаж

Үгүйлэх юм минь ганцхан тэр...

Эрлэг хэлрүүн:

-Өршөөл надад байдаггүй ч

Өрөвдөж байна...

Би чамайг

Эрлэг намайг өршөөлөө гэж

Энд тэнд ярив

Хэн ч үнэмшихгүй

Тэгвэл чи буц л даа

Тэнгэрийн дор газрын дээр хүн болж төр...

ЭРГЭХҮЙ

Тамтаг болсон биенээс нь

Сүүдэр салж

Тасын эрэлхүү сэгсрээнээс

“сүнс” зайлж

Амьддаа хэлсэн үгнийхээ

Арилсан улбааг элдэж

Айл болгоны хатавчаар шурган

Азгүй эрлийн замд хатав

Бүсгүй бүхний хормой доогуур шургавч

Бүрэлдэх заяа улам дайжиж

Амьддаа үзсэнээс илүү зовлонг

Алдуурсан сүнс ахиу эдэлж

Айл хүний бараа дагаж

Албин сүнс оршилгүй тэнэв

Амраг түүнээ олохгүй зовов

Арав хорин жилийн нүүрийг үзэв

Сүүдэрт бэргэсэн тоорой гандах намар

Сүнсэнд нэгэнтээ аз тохиож

Амьдаа хайртай явсан бүсгүйтэйгээ

Айлын хаяанд тааралдаж

Зөв энгэр доогуур нь шургатал

Зөн совингийн илд харшиж

Цэвэршсэн умайн амсар дээрээс

Цэцэггүй зөгий шиг үргэн холдов

Холоос түүнийгээ харахнаа

Хосгүй үзэсгэлэн нь гундан буурч

Хоёр шанаанаасаа шууран бууралтаж

Хорвоо нэгэнтээ өгснөө хураачихсан

Үсээ хусуулах нь үлдсэн хөгшин

Үр олохоосоо

Үхэл олох нь ойр болсон байв

Ядсан сүнс

Чадсан хорвоод гомдож

“...Амьдаас илүү санагдах тамд чинь

Амар сайхандаа жаргая...

Эргэж би хүн хэзээ ч болохгүй ..." гэж

Эрлэгийн өмнө сөгдөн гуйж

Хосын өлмийг зөөллөн нурах

Хоёрхон атга элс болов оо.

1993 оны зургадугаар сараас

1994 оны нэгдүгээр сар

Буутын ус

Дууль

Хээтэй шаргал манхан

Хээлэн дундаа

Туурайн мөр устай

Хэвгий дагаж урсаагүй

Хэлтийж ер халиагүй

Туулайн нүдэн шандтай

Тэр чигээрээ

Улаан цурам говьд

Нов ногоон амсартай

Нар байдгаараа

Шунхалж буусан цавд

Цэв хүйтэн ундаргатай

Булаг булгаас

Төөрсөн шанд

Говийн “нүд”

Буурал домгоос

Төрсөн “шад”

Буутын ус

...

...

Цахиур бууны

Гол төмөр

Шандын тархинд хатгаастай

Цангаа тайлсан хүн

Баярлахдаа уясан

Цагаан сэрс* гандаастай

Танхи хулангийн

Омруун доор нь

Цагираг дэлхээнэ

Тагшин чинээн

Торгон толио нь

Холын гаригийг булгина

Үдшийн оддын

Яарихын түрүүч

Нэгэн домог эхэлнэ

Үүрийн оддын

Явахын сүүлч

Нэгэн нулимс унагаана

Эрэхэд олдомгүй

Нуугдсан ус

Нэргүй элэрт

Нэрэхэд гарамгүй

Тунгалаг ус

Жимгүй баларт

Сүрэг хулан

Сүүдрээ тангаран

Шимдэг байж

Бүрэгхэн шандны

Хурган долгио

Үймдэг байж. . .

Цахиур бууныхаа

Оноонд

Амаа тосоддог гөрөөчин

Бууныхаа ард

Биеэ залган

Отож

Булгийн хөлийг

Үеэ чулуужтал

Сахижээ

Чулуу ч хөндөлгүй цуглах

Хулангийн сонор

Сүрэг

Цуурай зангирах

Төдийхөнд

Бууны овооноос дайжна

Нарлаг шаргал говьд

Тоосон хөрхөг

Татаж

Нүгэл баярын

Нүдэнд

Элс цацан хулжина

Харууссан шүд

Доод уруулдаа

Шигдэнэ

Хулангийн тоос

Ханзарсан зэргэлээнд

Шингэнэ

Сүүдэр цохисон

Хулангийн сүрэг

Сардаа эргэхгүй хатуу

Сүлдээ зүхсэн

Гөрөөчний зуулга

Хоногтоо хүрэхгүй татуу

Амь үргээх зэхэл

Тархин дунд нь

Нэгшинэ

Эм шандын нэхэл

Элсэнд хумигдан

Эгшинэ

Нүгэлт гөрөөчний

Нүд галиган

Бударч хүлээнэ

Нүдэн шандын

Ус гансран

“Буйлж” хүлээнэ

Шандан дээр

Нар голлож

Ирмэлцсэн өдөр

Буун дээр

Нүд бөмбөрч

Ирлэгдсэн үдэд

Сүрэг хулан

Сүүдрээ гишгэчин

Ирлээ

Ширэлдсэн нарны урсгалыг

Сүүлээрээ самнан

Ирлээ.

Олойрт манхны

Хээг цөмчин өмчин

Ирлээ

Овоо хараан дээр нь

Тоглон тонгочин

Ирлээ.

Усаа санасан хулан

Насаа мартаж

Ирлээ

Эзээ дэврээсэн гөрөөчин

Эсээ шатаан

Тослоо.

Омруу шанд хоёр

Гундаа тайлан

Учраагүй байхад

Овоо хулан хоёр

Гуниг дуудан

Давхацлаа

Аранжин улаан говь

Уулга алдан

Хөрвөв.

Аяган чинээ шанд

Усаа цацан

Цалгив.

Таж магнаг манхны

Элс нуран

Нөмөглөв.

“Тас” хийсэн чимээ

Тэнгэрт үржин

Нүргэлэв.

Цуурайнаас өрсөн

Хулангийн

Улаан тоос

Цуурсан тэнгэрийг

Гагнан гагнан

Оргив.

Тоосон дунд шургачсан

Хээлтэй хулан

Сөхчиж босно.

Толио бэргэсэн

Хээтэй шандад

Цус дусна.

Хайр нь дотроо амины

Амьд явахын

Аагт

Хал нь гаднаа амьдралын

Халуун хүйтний

Заагт

Гал нь үргэсэн

Нүдэнд нь

Тэнгэр зог тусав.

Эцсийн амьсгалаа

Салхитай элбэн

Эхэр татав.

Эхээсээ тасарсан

Нойтон унага

Эхний амьсгалаа татав.

Амьдрал халаагаа

Ажиг хэнэггүй

Авч өгөлцөв.

Ангир шар уураг

Цустай холилдон

Алаглан урсав.

Үхэж төрүүлсэн эхээсээ

Цочиж унасан

Нялх амьтан

Үйл заяаны ирээр

Хүйгээ тасалж

Хөллөв.

Үймсэн шандын

Цэнхэр цээлд

Дуугаа унагаж

Үхэл амьдралын

Цус сүүн дээр

Тэнцэв.

Гайхсан нүдээр

Ирэх одохын

Хорвоог тэмтэрч

Ганц нэгхэн гишгэлсээр

Гөрөөчнийг бараадан

Чүүчигнэв.

Энгэр нулимстай гөрөөчин

Элий ухаантай

Гуйвж

Эрхт хөх тэнгэрийн

Өлмий доор

Сөгдөж . . .

Нүд нь хөдөлсөн амьтан руу

Нүхтэй төмөр

Шагайхгүй! . . .

Нүгэлт насаа дуустал

Үртэй амьтныг

Хагацаахгүй! . . гэж

Ирт ган хутгаар

Эрхийгээ эсгэж

Андгайллаа. . .

Ис утаанд баригдсан

Цахиур буугаа

Элсний гүнд гудрав.

Үхсэн амьд хоёр

Үл тасрах

Амьсгал салгасан.

Буу гөрөөчин хоёр

Үл учрах

Зам сзлгасан.

Булаг булгаас

Төөрсөн “шанд”

Говийн “нүд”

Буурал домгоос

Төрсөн “шад”

Буутын “ус”

“Үр” могой

Домог дууль

“Устай чулуу тааралдвал үмхэж битгий

тоглож байгаарай! Могойны өндөг байдаг юм

гэнэ лээ . . . “

Дивангарт нэг хүнээс . . .

(Эмээгийн захиас)

Эрт урьдын цагт гээд

Үлгэр эхэлдэггүй байсан үеийн

Амар сайхандаа жаргав гээд

Үлгэр дуусдаггүй байсан цагийн

Элин домог

Энэ шороотой дууль

Алсын хатавчинд ургаж

Айзам шүлгэнд минь яргав . .

(Зохиогч)

Домгийн цагаан азарга

Над руу айсуй . . .

Дороос нь манарсан тоос ану

Үүл ажуу . .

Дээрээ эзэнгүй эмээлийн

Гөлөм нь хийсэж айсуй . .

Дэрвэж буйн шалтаг ану

Салхи ажуу . .

Буруу талын дөрөө нь

Хадтай харшин ханхийхүй

Бие жихүүцэм домог шивнэсэн ину

Энэ ажуу . . .

* * *

Овоохойн дотор орилох дуун

Овоохой тойрон орчих олон

Цаашаа наашаа холхих хөлөнд

Цас ёолно

Цалалзах жаврын үзүүрт

Хад улина

Омгийн зайран цамнан бууж

Одтой тэнгэрийг зүхэж дуудна

Олон шигшрэг шаргин дуулж

Онго шүтээнийг жиргэн даллана

Хоёр амь салж ядсан эгшинд

Хорвоогийн хормой чичирч

Билүүнд ирлэсэн хутга шиг нүд

Хорогдохын “амь” царайчилж

Бэргэсэн тэнэмэл “бурхад”

Хатавчны завсраар шагалзана

Гадаа “цагаан ороолон” маналзаж

Гал руу нулимчин шуурга шарвалзана

Туг галын төөнө бараадан

Тулгар эх төрөх гэж

Гурван шөнийн од дамжин

Гурван өдрийн үүл дамжин

Гуниг зовлонгийн үйл дамжин

Гурван хөтлийн онь дамжин өвдөв

Төрдөггүй үр заяасанд

Төрлийн сэтгэл үймж

Амьд үлдэх эсэхийн азын төлөг төөрөв

Хөдлөх тоолонд нь

Хөх толбо гардаг байсийм. . .

Хөөрхий минь. . . гэсэн

Хөгшдийн уулга гал тойрно

Хөх нь уурагласан ч хэвлий нь тэлээгүй дээ!

Хачин юм . . . гэсэн

Хүмүүсийн гайхах оромж тойрно

Омгийн зайран цамнан бууж

Оочин хадыг үйртэл бөөлж

Тэнгэрийн заадсыг мурийтал дуудаж

Тэнхэлээ баран муужран унав

Зэгэл үдэш шөнөтэй залгах

Зөнөсөн нохой хий боргох

Зэвүүн совин дээстэй ороолдох цагаар

Зээрийн хонгор арьсан дээр эх төрөв

Амсхийсэн сэтгэлийн амьсгаа

Айдсын сүүдэрт хахаж

Хүссэн баярын тайлал

Хүрэн эрээнээр эргэн

Хүлээсэн бүхний нүд

Духан дээрээ үсрэн гарч

Хөөрхий зовсон эх

Дөнгөж төрөөд ухаан алдав

Халуун хэвлээс нь тасарч унасан

Хар эрээн могой арьсан дээр цагираглаж

Сул асгарах халуун цусны тунараанд

Сүвэгч нь сохор тэвнэ шиг толгойгоо дүрнэ

Сүү нэхэх шиг хэлээ гозолзуулан

Сүүтийсэн болгоныг бараалан мурилзана

Үзээгүй ёрын сүрд дарагдсан

Үр минь ирнэ гэж хүлээж ядсан эцэг ину:

-Тэнгэр үр хайрлана гэсэн чину

Лус надад могой хайрлалаа . . .

Идэр янгир уулнаас нь хагацаан намнаж

Илчийг нь бодож зэхсэн өлгийгөө яанам . . .

Эр хүн төрнө гэж битүүхэн дотроо билэгшээж

Илд давгаж гурван голын усанд хатааснаа яанам?

Амь зуулгын “улаан” хүнсээ татрааж

Амьд амьтан руу нум эвшээлэлгүй хүлээснээ яанам

Хүйтэн чулуу дэрлэн, биеэ орхихын цагт

Хүү минь торойж үлдэнэ гэж итгэсэн минь яахав? гэж

Ховор гардаг эр нулимсаа

Энгэртээ хөлдтөл урсгаж

Хорвоогийн цаашаа харсан өсгийд

Эвхрэн эвхрэн сөгдөв. . .

Хорвоод төрсөн “эрээн үрийнхээ”

Хортой хоргүйг мэдэхгүй . . .

Холдуулж тууя! гэхнээн

Хоргодоод хөдөлж өгөхгүй . . .

-Эх нь нэгэнтээ ухаан орохдоо

-Энэ л миний лай юм даа . . . хэмээн

Төрөхдөө эгшсэн сүүмэн биенээсээ

Төгрөг төгрөг нулимс нэрж

-Цээж дарах хөхөө хөнгөлж

Цэгээн сүүг нь амсуулья даа!

Ирвэгнэн ирвэгнэн хэвлийд хөдлөхөд ину

Идэр хөх мину

Чимчигнэн чимчигнэн

Чинэсэн лээ . . .

Үр мину үр мину гэж

Дотогшоо амьсгалан

Өдий болтол нь

Тээсэн лээ . . .

Цогтой галын

Илч бараадаж

Цоройн цаанаасаа

Унагасан лээ гэж

Тохмон дээр саасан уураг

Толгойнх нь тушаа ойртуулбал

Цэв хүйтэн үр нь хэдэнтээ сорж

Зэв мэт толгойгоо өргөн цогнолзов

* * *

Омгийн зайран цамнан бууж

Ойртсон бузрыг түлхэн бөөлж

Отгийн булингарыг тунгаан дуудаж

Онго сүлдээ тамлан даллав

Гай дайрав

Лай дөглөв

Эхийн тунамалд бөрт унаж

Элэнц хуланцын сүнс хилэгнэв

Үйлтэй хоёрыг эргэж ч харалгүй

Үнсэн дээр нь торойтол хаяж

Гарзны амыг лайтнаар таглаж

Галын тэнгэрийг авран тасдаж

Нар бүлэгнэн мандахаас өмнө

Гал дүлэгнэн асахаас урд

Гүн нойрын манан дундуур

Хөдөлтүгэй! . . . хэмээн айлдав . . .

Айлдлын утгыг анзаарав гэлтэй

Алаг эрээн үр нь эхийнхээ хөлийг орооно

Чимээ шуугиан гарах тоолон

Чивчирч улам чангарна

Өрөвдөхийн сэтгэлээ давхар ачаалж

Заншлын дээсээр чивчиртэл татаж

Өвөр хуваасан хань нь хүртэл дүлийрч

Зайранг даган орхиж одов

Зүүдэнд ч багтахгүй хагацлын илд

Зүрхэн дээр нь мэслэн бууж

Зүхлийн урсгал шиг

Зүг тахисан мөрөө чирч

Уур савссан

Буудал ханхайлж

Уулсын хөтлөөр

Нүүдэл давав

Утаа уугьсан

Ганц оромж

Уулын суганд

Өнчин торойн

Эргэж нэг харах

Энэрэл хургасан нулимстай нүдгүй

Их нүүдэл “гайнаас”

Исгэрэх сум шиг дайжив

Малын жимээс бусад нь

Дун цагаан цас

Малгайлан орох дуртай гэдэг нь

Өдөр болгон бургаа

Амьдрал хэмээх “алаг нүдний”

Хөмсөгний гадаа хаягдсан

Амьд явах насны

Хөсөгний сүүлд гээгдсэн тэднийг

Харанхуй тойрно

Хараал тойрно

Гаслангийн аранга тойрно

Ганцаардлын айдас тойрно

* * *

Унтаа араатан шиг нам гүм

Архирах цагтаа

Залгих юм шиг занал . . .

Уулсын дундах ажин түжин

Айдсын хорлол

Хазах юм шиг түгшүүр

Нар сар хөөцөлдөж

Гэрэл харанхуй химлэлцэнэ

Үр-могой

Хоногийн хэцийг

Гулгаж цагираглаж давна

Эх-хүн

Хоногийн хэцүүг

Мөлхөж босож давна

Төө илүүхэн үр гаргасан ч

Төрсөн л бол эхийн бие нялх

Өлгий, бүүвэй хоёр хэрэггүй

Өлзий бус “үр нь” танхи

Цагираглаж хэвтээ “үр” могойгоо эх нь харж

-Цоройн цаанаас унасан

Цоохор эрээн үр минь

Цогонд орчих вий! гэж эмээнэ

Унтаж байгаа юм шиг

Удаан гэгч нь цагираглахад нь

Амандаа бүүвэй гиншиж

Айдсыг нь үргээн ганхана

Ангир уургаа сааж

Аман тушаа нь ойртуулна

Үйлийн үрийн харанхуй зайд

Үгсэж бас үзнэ

Үр могой нь харин

Үсчиж хэнэггүй шавхчина

Хаа нэгэнтээ сураг алдрахад нь

Хань бодсон сэтгэл нь эзгүйрч

Ар өврөө самнан үгүйлж

Адсага хөмөө сөхчин эрнэ

Хоног тоолон могой томорч

“Хорхой” тойлон эх доройтов

Эрүү толгой хоёр шиг

Газар тэнгэрийн дунд

Эх үр хэмээгдэх

Хоёр “хэцүү амьтныг”

Хоолойг нь давах “хоол” мартжээ

Холдон холдсон “нүүдэл” мартжээ

Холбилзон асах “гал” мартжээ

Хомроглон эргэх “чоно” хүртэл мартжээ

Ээлгүй тавилангийн хатууд

Эх улам туйлдаж

Хүйтний алга дэрлэн

Хэвтэрт орон атирчээ

Хөхний сүү нь ширгэж

Хөлөөсөө эхлэн хөрчээ

Түлэх модондоо хөл хүрэхгүйд

“Галын бурхан” туйлдана

Балгах усандаа гар хүрэхгүйд

“Насны бурхан” харангадна

Бурхад цөөрсөн газар

Чөтгөр бүжиглэг гэж

Буйлсан цасан шуурга

Чих залхтал хөгжимдөнө

Амьдралын сэжүүрээс зүүгдсэн

Ганц хар цэг

Алдууран алдан дэрвэж

Мөхлийн инээд хүргэнэ

-Биеэ барагдтал

Би энийг тэжээлээ. . .

Харь үр гэлгүй

Халуун сүүгээ цутгалаа

Өглөө . . . өглөө . . . гэхэд

Өнгө нь цагаан болсонгүй . . .

Амьдрал чиний дунд

Ийм цөл байдаг аа . . .

Азгүй азгүй гэхэд

Ийм заяа байдаг аа . . .

Нуугаад уйлахад барагддаггүй

Нулимс байдаг сан. . . алга . . . гэж

Гавлаа цууртал эх гаславч

Ганцын заяа үржсэнгүй

Ижилтэй байхын тэнгэр хаяж

Ижий байхын “заяа” гээжээ

Алаг эрээн үр нь

Амьсгаа хөлдөм хүйтнээс дайжиж

Аманд нь шургаж бүлээцэх гэнэ

Аваад хаячихад хилэгнэнэ

Ширгэсэн хөхөө дэмий тэмтрэхэд

Ширүүн занд нь урь бууна

-Гарсан юм даа надаас гэж

Харсаар байж тураалтай биш гэж

Гараа эсгэж цусаа өгнө . . .

Сүнсийг нь хүртэл үргээсэн үр нь

Сүү цус хоёрыг ялгахгүй сорно

Өлсөх тусмаа нүд нь хурцдаж

Өөдөөс нь цоргитол ширтэнэ

Хөдлөх тоолонг нь хариулан дагаж

Хөвчөө тийрэх сум шиг гозолзоно

-Миний зовлонг мэдмүү энэ гэлтэй

Мэндийн зөрөө шиг бодол цахиж баярлана

* * *

Нар мандаж нялуурсан

Насны совин алдуурсан өглөө

Үлгэр домгийн өсгөлөн могой

Үмх ч хоолгүй өлсгөлөн могой

Эрлэгийн элчтэй дэр хувааж хоносон

Эхийнхээ хөлд нойрссон “үр”

Эвхсэн биеэ хилэнтэй задалж

Унтаад сэрсэн нойрмог орчинг бэргэтэл

Улайссан зэс шиг нүдээр сүлбэж

Эцсийн хоолондоо ам хүрч

Эхийгээ хөлөөс нь залгиж эхлэв

Хальж байгаа амь эргэх шиг

Халуу дүүгэн эхийн хөл бүлээцэв

Бүрэг барагхан ухаан орсон эх

-Би үртэй хүн юм аа! гэж бодов

Биеэ эвхрээн улангасан залгилах могой

Бэлхүүсий нь хүртэл эхийгээ залгив

Хэсэгхэн эгшин харвасан хойно

Хэвлий нь бүлээн оргиход

-Өсгөөд өгчихсөн байхад

Өтлөхөд хөл хучдаг нь үнэн юм аа!

Хувь тавилан хэрчиж заяасан

Хар эрээн үр минь! гэж амандаа шившихэд нь

Өөрт нь хоргодсон эцсийн шүүс

Өрөөсөн хөхнөөс нь цийлэн сүү

Төмөр мэт толгой дээр нь дуссанаа

Төдхөнөө тэгээд ээдэв . . .

Төгсөхийн их амарлин залгав

Халуун залуу явсны нь дурсгал

Харын хар гэзэг, могойн завжнаас унжиж байв

* * *

Домгийн цагаан азарга

Над руу айсуй . . .

Дороос нь манарсан тоос ану

Үүл ажуу . . .

Дээрээ эзэнгүй эмээлийн

Гөлөм нь хийсэж айсуй . . .

Дэрвэж буйн шалтаг ану

Салхи ажуу. . .

Буруу талын дөрөө нь

Хадтай харшин ханхийхүй

Бие жихүүцсэн домог шивнэсэн ину

Энэ ажуу . . .

17-р жарны шаргачин могой жилийн өвлийн тэргүүн сарын хорин цагаагчин могой өдөр
дуусгавай . . .

Өлөгчин чоно

Дууль

Авын бүрээ тасхийв

Агь шивээ намсхийв

Морьдын нуруу хотосхийв

Моност нуга балтасхийв

Уулын модод сэрсхийв

Усны толио манасхийв

Сумны гичир өрвөсхийв

Нумны хөвч шазасхийв

Адын догшин уухиалд

Агаар газар цавлаж

Асга чулуу шаргиж

Амар жимрээ алдав.

Шуугианы “майд” бахардсан

Шувуудаа тэнгэр зайлав

Шунгах морьдын хөлд

Шороо хөөрцөглөн мандав

Цуулж хуйлрах дайлаанд

Цухлын манан татав

Цуурай гаарсан анирт

Өвсний хагсуурга сульдав

Жартгай нүд хөлбөрөн гялалзаж

Жавартай харц бут тэмтэрнэ

Жаргахдаа золих амь эрж

Жалга судгийг нэвг нэгжинэ.

Үргээлгэний эрчүүлийн солгой дуунд

Үүлний нүүдэл улам хурдасна

Үер мэт анчдын уруй

Үйлийн үрийн нугачааг нэгжнэ

Эцэг тэнгэр золио шидэж

Эзийн бөрт мөр дээр унагаж

Улан дороос нь чоно босож

Улангаслын дээсийг хөвөж гарав.

Гөрөөчдийн агссан зэмсэг нь өлөн

Гөлмөөр далилсан морьд нь “жигүүртэн”

Өртлөөсийн ирэн дээр хальтчих

Өчүүхэн амь, сумны золиос

Алд алдаар сунах чоно

Амандаа зэгэл бэлтрэгээ зууж

Халуун хоёр амиа булаах гэж

Харьтаа ханзартал зуларна.

Ангаалдан элдэх олон морьтны

Ангийн хорхой үймэн язганаж

Эмээл дээрх утсан амиа

Эрлэгтэй цуг мартан улайрна

Хашгирах дуун өмнө хойно нь гарч

Хажуугаар нь өдөт сум шамрагална

Хандах зүг-бүрий барай

Хагацахын гашуунд-элий балай

Алгын чинээн бэлтрэгээ сэгсчин

Арагшаа хялам хялам зулбана

Арьсаа шувтаргал шахам харайна

Агтын туурай сүүлий нь сэмчинэ

Нумран харайхтай нь давхцан

Нумын хөвч нь дэлж агшина

Сунан сунан харайхын хэрээр

Сумны нэхэл исгэрч ойртоно.

Эгнэж сэрийсэн хөх нь савлаж

Элбэг хохилзсон бөөрөө балбана

Ивлээд удаагүй сүү юм болохоор

Элгэн дээгүүр нь хөөсрөн үсчинэ.

Уулын хүрэн бүүрэг дээр

Нар бүдрэн сөгдөх үед

Уулгын өчил, өлөгчин чоно

Гурван гурван жалга гэтэлж

Их аврал бүрэнхийн үзүүрт

Илүүр хушуугаа дөнгөж дүрэн

Исгэрэн тусах хурц зэвэнд

“Эх” биеэ дэвсэн унав . . .

Бүхий л хүмүүс мориноосоо буун харайж

Бүчин ирж эрхийгээ цусаар норгоно

Бэлтрэг үлгэсэн хөх нь сэрийж

Бие нь үхэж өгөхгүй татвалзана.

Тасарч өгөхгүй үртийн улаан гол

Тартагтаа тулж эхэр татав.

Там диваажин хоёрын босго тэгнэн

Тэрийсэн биенээс нь амь зайлав

Хөлсөндөө мөлчийсөн хангал морьд

Хөлөө амраан самчин гишгэлж

Цул хөх мах нь чичирч

Цусны үнэрт хамар нь сарталзана.

Ойрын ууланд инээд цуурайлж

Олзтой авын баяр сагана.

Аян дайны завсрын зугаанд

Азтай ганзаганы сур сарвалзана.

Бусдаас арай ажигчаа гайхуулах гэсэн

Буруу сэрэл сүүхээ залгиж

-Хараач хөөе хамхуул зуучихаж

Харайлт дундаа бэлтрэгээ нуучихаж гэж

Адтай нэгэн эр санасандаа хүрч

Амьтны нүдийг сэрдхийлгэж гялайна.

Үртэй амьтан тэгэлгүй дээ гэсэн

Үг тэнд эзэнгүй байв.

Эргэн эрж тэмтэрье хэмээн

Эршүүдээ гайхуулан нэг нь хашгирав.

Уул уулын хагтай хад тасхийж

Унагасан үгэнд нь цэцэг “дальдирав”

Их авын цустай хоймор

Эзэн дээдэс саадгаа огшоож

-Ингээд л орхичих яахнав, хэрэггүй. . .

Ирэх жилийн авд юу харвахнав гээд

Зуур баярын инээмсэглэл гүйлгэж

Зураас шиг зовхиндоон нүдээ нуув.

Өдрийн төгсгөлд хатгасан цэг

Үдшийн гялаан уулгалан түгэв.

Өндрийн од өвчүүлсэн чононы

Өрөөсөн нүдэнд ёлтойн буув.

Сэг дээрээс үргэсэн шувууд шиг

Сэвхийтэл эрчүүл мориндоо мордов.

Ав хураах бүрээ тасхийв

Айсан тал гүдэсхийв

Битүүхэн доргих морьдын төвөргөөнөөс

Бэргэж айсан саран мандав.

Анир анираа гишиглэн

Ажин түжин нөмрөв.

Агаар урж хэрээ бужигнахуй

Азарган чоно гудчин ирэв.

Өлөгчин чонын бөгсийг шиншин

Өвчүү цавинаасаа эхлэн биеэ хэмхэв.

Өгзөг дээрээ оцойн сууж

Өшөөр зангиран гэнгэнэн улив.

1997 он.

Морин сувд

Домог дууль

“...Идүүрээ долоож байгаа

Хөх ноход шиг давалгаа

Эргээ шалих тоолондоо

Үл мэдэгхэн юунд гасална...”

/тэмдэглэлийн дэвтрээс/

“...Ляо улсын хааны үеийн гуравдугаар сар, ан авын “улаан сар” байв...”

/Горлосын монгол зохиолчийн ярианаас/

Аргүй цагаан хоргой

Тэнгэрт хуйлж

Анир авсан хунгийн сүрэг

Сэжүүрээсээ үргэхэд

Илдэн жигүүрийн цавчаа

Ингэн туйлаадас шиг бударч

Ижий болсон нуураа

Хурайланхан зангирна...

Алмай амгалангийн тайв эргэхүй

Агаарт цацарсан хунгууд багцран

Элгэн өрөвлөгөө усаар цавдаж

Эрмэг давалгаа эмтлэн бууна

Ийшээ тийшээ далиа засан хөвж

Их усыг битүү цагаанаар цалмана

Хултай цэгээ шиг нуур хөлд дарагдаж

Хунгийн эрчилсэн дуу тэнгэрт хадна

Шуугин шуугин ганганалдах

Шувуудын хөх диваажин

Шугуй явгалсан талын

Сувд цагаан нуур

Амьтай-амьгүй заяа барилдаж

Атираа долгисоор хаяа балбаж

Тэнгэртэй холилдон зах алдарч

Тэнэгхэн алмайгаар тух мэлтрээнэ.

Ир залгаж, иш нь байдаг хутга мэт

Их амгаланг залгаж, түгшүүр байдаг хорвоо

Дэлхийн хацар дээр бөмбөрч тогтсон нулимс

Дэлхээ цагаан нуурыг дайрдаг бүхэн л дайрна

Торойгоод ирдэг үйлийн үр

Тойрч гардаггүй усан нүд

Тоглохын хорхойтой одод

Үйж, мяралздаг нуурын дэргэд

Хавар хаврын гурван сард

Хангал морьдын туурай тачигнаж

Эргийн нялх цэцэгний нь дэлбээг сэмлэж

Элбэг цөлх усны нь , булингарыг сандаана

Хавар хаврын гурван сард

Халтар нумын хөвч тийчилж

Хурц сум шуургалан исгэрч

Хунгийн өд цаслан орно.

Уулгалсан их ав хоморгын дараа

Улай үзсэн нуур энэлэн

Агаалах үүрийн шунхан хяраанд

Атга нөж шиг чинэрнэ.

Үхлийн ирнээс амиа булааж

Үргэсэн хунгууд шугуйд газарлан

Өрөвч сэтгэлгүй хорвоог харж чадахгүй дальдарч

Өдөн дундаа нүдээ нууна.

Дайван хөх тэнгэрийн дор

Дайрт бор газрын дээр

Дайраад ирдэг энэлэн зовлонг

Дахихгүй юм шиг гэнэлэн санаж

Ангаалдан харвах морьтны сүүдрийг

Аль хэдийнэ, чимээтэй нь элрээж

Амь тавьсан ижил сүргийнхээ

Ангалзаж байсан хошууг мартаж

Уухай дуухай хөл намдсаны дараа

Усаа гэсээр шувууд цэмцэлзэн бууна.

Урьдын адил хөвөн дэлгэрч

Удаахь хаврын ёрыг долгионд алдана.

Чимээ бүжиглэх, нуурын арыг хөндөн

Чилгэр хүзүүгээ гогцооруулан усанд булхаж

Хясал хүслээр бүтсэн, амьдын хуулиа дагаж

Хясаа задлан сувдтай нь залгина

Илүү дутуу юмгүй сайхан хунгууд

Идэштэйгээ цуг, эрдэнэ залгиснаа мэдэхгүй

Энэ л гашуун , бурхны зохицлын аагинд

Эцэстээ тэд өртөж, амиа алдахаа мэдэхгүй.

Дараачийн үхлийн адыг залгиж

Далавчаа засан намбархана. . .

Сувдагхан залгих, сувдтай хясааны тоогоор

Сумны үзүүрт төдий чинээ ойртоно

Хясаа мөлжиж, амтархсаныхаа золионд

Насаа бөөлжиж, амьдын тойргоос халихад нь

Цусаа асгаж, өдөө хийсгэсэн нуурыг нь тойрон

Мэсээ зэхсэн хүний шунал тэнэсээр үлдэнэ.

* * *

Аргамаг морьдынхоо нурууг амрааж

Авынд дараа баяр хоормоглоно

Ляо-улсын догшин эзэн гялайж

Лайт орчлонгийн зайд сууж налайна.

Зовхин дээгүүрээ, харайн алдах

Зольсон эзний мэсэн харц

Морин сувдтай хутгалдан уутанд унаж

Мухрыг нь төнхөн гөлөлзөн жаргана

Сүүдрээ хүртэл, хялалзан танддаг

Сүрлэг эзэн итгэж ер үзээгүй

Өмнөө зулсан хунгийн үхдлийг

Өрлөж байгаа цэрэг бүхнийг хариулна

Ганцаараа бас энэ зовлонд хатахгүй

Гал ассан нүдтэй эргүүл тойруул сүлжинэ.

Санаа хувирсан хэн нэгэн-нүдэн дээр...

Саяны хун шиг болгох гар-илдэн дээр...

Азгүй нэгэн эр баригдсан юм даг уу...

Амыг нь хүртэл боодог болж ...

Халуун улай дуусаж, тулам дүүрэхийн цагт

Хамар чихий нь нэгжиж сэрддэг байж...

Эзний хилэнг шатаасан хомхой боолын

Эрүүн доогуур нь илд “морилно”””

Зааж бүрэлдсэн өвчүүг нь хадаж

Залгисан сувдыг нь заавал авч сална

Сормуустай юм болохоор аньдаг, эзний нүдийг

Солбих эгшинд нь гэмийн адтай хамжиж

Эрхий сувд залгисан, цэрэг эр амь хожвол

Эргэж харьтлаа, өмдөө яасан ч шувтлахгүй

Эргэж мэнд харьж гэмээнэ,

Эхнэртээ ч тэрнийгээ үзүүлэхгүй

“Хэрэг” болохгүй сувд амилан тэвэрч

Хөлийн чимээнээс цочин тарчилна...

Алхам бүрд нь сэлэмний салхи сонсогдож

Айдсын торонд уйтай жаргана

Амьсгаа болгоноос айн мэгдэж

Аваагүйгээсээ долоон дор зовно

Хаан эзэн гаднаа амгалан, дотроо буцалж

Хаврыг хүлээн, авын донд хатна

Цустай гар дээр бөмбөрөх морин сувдны зүүдтэй

Цуг унтаж. илжиг орилоход сэрвэлзэнэ

Улиран одсон он жилүүдийн туурайнд

Уймран цайрах нуур хунгүй үлдэж

Усны ёроолд сувдтай хясаагүй болж

Ухаангүй үйлийн босгоогүй хөшөө, домогт хоцорч...

Наашаа цаашаа татах цагаан нуурын долгио

Надад цустай авын гайг ховлоно.

Намрын шарласан модод, эргий нь даган тонголзож.

Нургих хунгүй болсон, нуурын заяаг тавлана.

Тэнгэрийн өнгөнд хаяа уусгаж

Тэлчилж байгаа цагаан нуурын давалгаа

Ганцхан үг хэлэх гэсэн шиг дэллэн ирснээ

Гуниг хагацалдаа багтран зэллэн буцна...

Хавар хаврын гурван сард

Халуунтай хүүхэд шиг нуур цочиж

Айсан давлагаа нь эргээ балбан мэлмэлзэж

Алсын шарх нь сэдрэн янгинана.

Өмнөд Горлос-Мүгдэн хот.

Цэргийн хар

Дууль

“Маршал Чойбалсангийн мэргэн буудагч

Матадын дивизийн ахлах түрүүч...”

Манаргаж явлаа ах чинь гээд л хөөрдөг эрийг

Манай нутгийнхэн цэргийн хар гэх. . .

Халагдаад ирэхдээ хэнээ тусчихсан юм

Хайран амьтан гэх нь хоёр гурав...

Цэргийн хар хэнхэг амьтан гэж

Цэрвэх хүн хорь гуч. . .

Өрөөсөн гар дээрээ таван хошуу шивсэн

Өвөл зунгүй шинель чирсэн өвгөн

Өргөн нэвтрүүлэгээр “цэнхэр дурдан алчуур”-ыг дуулахад

Өвдгөө нортол уйлж суух ...

Байлдааны бэлэн байдалд байх хэрэгтэй яаж мэдэхэв гэж

Айлуудаар ярьж явсан улс төрийн хэрэг

Байнга зүүж явдаг дугуй цэнхэр тэмдэгнийхээ үсгийг

“Аавгүй устга 1939” гэсэн үг гэж орчуулж

Ам цуурсан хэргээр

Жил зургаан сарын тэнсэн авч

Жимсээ гүвсэн мод шиг горойж явсан эр...

Залуу насны минь хийморь шүншиг

Жанжин туг шигээ босоо байж үхнэ гэж

Жаалуудаар “тойрон хүрээлүүлж”

Жавьжаа хөөсөртөл ярьж л суудаг хөгшин

Халх голын дайны амьд сум

Хал үзсэн хуучин цэрэг

Хорхойд хоргүй хар өвгөн

Хоньтын нуруугаар нутаглах

Хамгийн их шунадаг юм нь

Халагдсан цэргээс дүрэмт хувцас гуйх

Халгаатай юм нь юу вэ гэвэл

Хажуудах хүнээ яриулахгүй дарамт болох

Таана хэнзэлсэн нэгэн сайхан намар

Тээр тэндээс ирсэн л гэдэг

Хар гүйхээрээ л явдаг хүн

Сажилж ирсэн гэдэг

Хаяанд ирчихээд мориноосоо буухгүй болохоор нь

Харсан чинь

Цулбуураа чирсэн бэлбэсэн хүрэн морин дээрээ

Цуутай боржгин эмээл дээрээ амьсгал хураан хөшиж

Цухал тухлын орчлонг орхисон байсан гэх

Тэр болгонтой огт адилгүй явж

Тэнгэрийн заадаснаас алдуурч унасан

Залуу насны хийморь шүншиг

Жанжин туг шигээ босоо үхнэ гэсэн үгэндээ хүрсэн

Үргэлж л эх орон дуудах вий гэж

Шөнөжин сэрвэлзэж хонодог

Үхсэн хойноо ч цэрэг байсан

Эгэл тэр өвгөнийг “цэргийн хар” гэх

Төөрсөн од шиг булшны нь шархыг

Сарны гэрэл долоож байдаг

Туурсан зуны алаг цэцэгс

Салхинд гунхан илж байдаг

Цэргийн харын булшийг хүмүүс мартсаан

Тэнд гэж

Олохгүй ээ.

“Цэргийн хар” гэж хүн байсныг

Бүүр мартсаан . . .

Тийм хүн

Олдохгүй . . .

Цагаан согоо

Домог дууль

Хэрэйдэн шар талд

Хээлтэй буга, сүргээсээ улдаж

Цэцэг дөнгөж яраглах, хавар

Чилдэн хөрсөн дээр зорголоо унагажээ

Урамын дуу, хээл татсан

Улаан намрын идийг үзжээ...

Галтай нар хур хулжааж

Гантай зуны ёр салхилж

Эргэн тойрон, уруул хатгах сөлгүй

Илэг шиг, улцан газар цулгүй

Цагаан согоо

Өдөржийн газар дэргэж явж

Өл хоол хальт мөлт сөрмөж

Элбэг хөхөндөө сүү нэрж

Эргээд үрдээ бараг л нисэж ирдэг байж

Ганц цагаан согоо ирснээс болж

Ган зуд, гай болох нь... гэж

Нутгийн сүсэг битүү өшиж

Нудрага дотроо үгсэх болов...

Устай, модтой “диваажинг” зорьж

Унхиалж одсон, сүрэг нь үгүй...

Аривжих, хорохын сэрэл бүрхэг

Адгуусны зөндөө төөрөн оджээ...

Газраас хооллож, тэнгэрт жаргадаг

Гарзын үүдний “хар” хаалгач шувууд...

Салиа нь арилаагүй зорголын дээгүүр

Сараачин эргэлдэж, зоогийн “тор” татна

Аниагүй нүд шиг мэлтийсэн талд

Амин үрээ нуух, бух чулуу ч үгүй...

Эрүү нь хөдлөхгүй бол ивэлдэггүй хөх

Эргээд ирэхэд үр нь байх байхгүйн цөх

Хур бууж аянга цахисан нэгэн шөнө

Хувилгаан тэнгэр цагаан согоонд

Хувилгахын шидтэй тарни шивнэж

Хувь заяанд нь аврал буулгав...

-Ижийгээ хол явахын цагт хөдлөхгүй

Хөх чулуу бол ... хурай ... хурай...!?

-Эргэж ирээд сүүгээ дусаахад

Эвий үр минь

Зоргол бол... хурай... хурай!... гэж шивнэхэд

Зоргол нь чулуу болон үлдэж

Зовохоо хугасалсан эх согооны

Эргэн эргэн зовж явдаг

Энэлэн нь жаахан сэвэрчээ...

Сэтгэл сэвэлзэхгүй бүтэн идээшилж

Сэрийсэн дэлэнгээ дааж яддаг болж

-Хөдлөхгүй

Хөх чулуу болж...

-Хөхний сүүгээ дусаахад

Зоргол болж...

Эрхиний бөөр шиг он цаг

Ижий үр хоёр дээгүүр өнхөрсөөр...

Цагаан согоо

Үрдээ эгсэн, улаан үдэш

Цагаан сүүгээ хичнээн асгалаа ч

Үр нь эргээд зоргол болсонгүй

Улайдсан зэс шиг наран

Учрыг нь эс мэдэв

Урдаар түгдэг үдшийн гялаан

Яасныг эс мэдэв...?

Цэцгэндээ бялуурсан тал

Яагаадыг эс мэдэв...?

Цагаан согоо багтарч

Яахаа эс мэдэв...?

Тэр минь яачихав даа гэж

Тэнгэрээс асуун сөгдөв...

Тэнгэр хэлрүүн:

Тэртээ урдаас нисэж ирсэн

Хар шувуудын багц сүүдэр

Хайртай үрийг чинь дайрч өнгөрсөн

Өөдсийн чинээхэн зоргол чинь

Өнө мөнхөд уул болсон... гэвэй

Тарчилж зовсон цагаан согоо

Тарж үйрсээр

Таанын цагаан цэцэг болов...

Зун намрын бүлээхэн

Зургаан сард дэлгэрдэг

Зорголынхоо хөлийг хучдаг

Зулхай цагаан цэцэг болов

Зорголын уул

Зовсон эх үрийн домгийн уул

Зорголын уул

Бодитой бодигүйд учирдаг ерөөлийн уул

Зорголын уул

Үүл цуглуулсан тэнгэрийн уул

Зорголын уул...

Үхсэн амьдтайгаа цуг газрын уул

2001 оны өвөл цаг

Сорвитой бурхан

Дууль

“...Чулууг нь ховхлоход бутарсан олон хар хорхойнууд,
энэ дуулийг ярьж байсныг нь би тасдчихсан юм билээ.

Тэд сонссон дуулиа мартагч гэж арван тийшээ садарсан.

Хорхойнуудын мөрнөөс энэ дуулийг би түүсэн юм...”

(зохиогч)

Дээлэндээ өвөртлөсөн салхиа

Бөгтөр уяаны дэргэд асгаж

Дэнжигнэн алхах Дэндэв

Биенээс нь ус гэрэлтэм согтуу.

Холын анирт хөлсөж боргосон нохой

Хотны цаанаас эзнээ оройтож таньсандаа гэмшиж

Хонины хашааны сүүдэрт шургаж

Хонхорцогтсон сүүлээр биеэ хучиж, нуугдав

Хоёр тийшээ савчихад нь хэм алдсан

Морин туурайн будлиу соёг чимээнээр

Хорол хүүхэн харуу нойроос сормуус ханзалж

Хуучин дан дээлийнхээ цэцгийг бужигнуулан эгэлдрэглэв

Хумсны хонь шиг жаахан сар

Унин толгойноос мултран алдаж

Хул шаргал үүрийн туяа

Ханын ширээр нохойны хэл шиг цухуйж байв.

Хаалганы нугас шархирах төдийхөнд

Ханхийсэн архины үнэр хүнээсээ түрүүлж орж ирэв

Шөнөжин уйлсан нулимс нь баартаглаж царцсан лаа

Шүдэнзний гал амсуугаа балбалзсан гэрэл цацав

Орж ирүүтээ...

Олон сонсох тусмаа жин нь хүндрээд байдаг

Оёг болсон үгээ урсгаж эхлэв

- Сав нь хуурайшсан миний муу эхнэр

Салтаандаа гараа хавчуулаад л унтаад байна уу

Энэ л үгийг сонсоод

Гаргана гэж зэхсэн юм шиг

Элбэг халуун нулимс

Хоролын хацрыг нь зүсэв

- Ганцхан надаас болдоггүй юм... гэж

Ганхийе! гэхнээ нүдүүлхээс айна

Чих хэл хоёртойгоо тас мартаж

Чимээгүйхэн шүлсэнд норж сууна

- Хүүхдийн зулай үнэрлүүлж өгдөггүй

Хар сувай-жингэр минь...

Энэ л үгийг сонсоод

Эгшээнэ гэж зэхсэн юм шиг

Элбэг халуун нулимс нь

Эргэж биенд нь шурган

Хавирган цаагуур нь бөмбөрч

Халуун голыг нь зурна

Бүрэнхий хойморт

Зулын гэрэлд туналзах

Бүжин лхам бурхны

Зөөлөн мэлмийг царайчлана

Нум мэт хоёр уруул нь

Сумаа нууж өмөлзөнө

Нуурын захад ангир ганганахад

Гурвуулаадаа гэж атаархана

Чийр болтол сонссон улиг

Чихний хажуугаар салхилна

Ээ чааваас даа гэсэн шиг

Ээмэг нь хааяа санжигнана

Буйлсан тэнэг нь хөдөлж

Бурж тайтгардаг Дэндэв

Буруугийн шалтгаа сольж

Бурхандаа агсарч гарав

- Будагтай зураг юм уу чи

Бурхан юмуу

Үдээр болсон цээжийг минь

Үрээр норгооч гэж гуйлаа

Алганы судсаа орооцолдтол

Өвдөг сөхөрөн залбирлаа

Адуундаа явахдаа хүртэл

Эмээл дээрээ залбирлаа

Аварсан чинь хаана байна

Бүрэнхий хойморт

Зулын цаана тунарах

Бүжин лхам бурхны

Зөөлөн мэлмий тормойно

Өвөр дээрээ тэвэрсэн

Өлгийтэй хүүхдээ

Хөөрхий минь цочих вий гэж

Хөдөлгөж байх шиг харагдав

- Айл болгонд үр заяагаад

Алагчилж намайг зовоосон чамайг

Алнаа гэж хэт хутгаа сугалан

Үйлийг хатгагч донт сархадын гайгаар

Үрийн тэнгэр бурхандаа

Мэс тушааж алдаслав

- Даанч дээ чи... гэж Хорол

Дарладагаараа намайг ингэхгүйдээ гэж чарлав

Юм бүхнийг ширтэгч бурхны мэлмий

Юу ч болоогүй юм шиг дүрлийж байв

Оргисон агсамныхаа горыг амсан Дэндэв...

Овилго сууж горойж явах болов...

Нүгэлийн туйл үйлдсэндээ хахаж

Нүд болгоноос халирч зовох болов.

Тэнгэр бурханаа хүртэл чичсэн тэнэг толгой

Өөрийгөө хувхайртал зүхэж

Өрөө өмөртөл гэмшиж явав

Хонгор намрын шивээ давалгаалах цагаар

Хорол хүүхэн хөл хүндтэй болов

Таж магнаг хөлтэй, хатгамал бурхнаа

Туж өвөр дээрээ, залан аргадаж

Тасарсан утас болгоныг нь сэргээж суухдаа

Татсан учигныхаа тоолон, нулимс унагаж мэтгэв

Олон хоног эндсэн тэнэглэлийг хүртэл нигүүлсэж чаддаг бурхан минь

Дэндэвийг минь өршөөж хайрла гэж амандаа үглэж шаглав

Бурхны шарх эдгэсэн сайн өдөр.

Бурууг нь өршөөсөн хүүтэй болов

Бурхан айсандаа биш өршөөсөндөө өгсөн тэр хүү

Борвин дээрээ цагаан сорвитой төрөв.

Гэгээ хормойлон Дэндэвийг орж ирэхэд

Гэр дүүрэн сүүний үнэр ханхийв

Хэм тэгшхэн морин туурайн чимээнээр

Хоролын хацар дээр инээд зүсрэв.

2003.07.24-28.

Эрхэмсэг дууль

“энэ дуулийг хүрээ хуучаас олов би”

(зохиогч)

Сархад омголон тул, толгойд асаж гавал дотор “тургилмуй”

Салхитай сэлэм тул, толгой эрж, гарын тэнэгийг бараадмуй...

Дээдсийг долоох налиг билбүүр хүмүн

Хормой дороос өгсөж, толгойд мацмуу...

Дэлхийн дээр орших атал

Сарны гэрэл өлмийд унамуу...

(өөрийн шүлгээс)

Магнаг хормой намалзуулан

Машид хүндэтгэл хөглөрүүлэн

Монгол ноёд, ёсыг болгоож

Мананд элийрсэн Бээжинд жасаалав

Угтсан ноёдын хөл хөнгөн

Усанд мөчрөө дүрсэн уд мэт

Урд хойно нь гарсан ёс ганган.

Уулын салхинд хийссэн өд мэт

Өглөөн шүүдэртэй зэрэгцэн будаалж

Үдшийн гялаантай давхцан дайлах

Өмнө газрын эелдэг түнш

Өлмийд нь хүн дэвсэх дөхнө

Буух суухад нь таяглан налж

Булхай харцаа хуяглан инээнэ

Булан тохойд гараа дэвсгэрлэн

Будагтай үгээр чихий нь шунхдана

Эвхсэн жолоогоо бүүргэнд чивчилж

Эх нутагтаа ноёдыг буцахын өмнө

Элбэг найрыг үүдэн дэлгэрүүлж

Ихэд хүндэтгэлийн “илбэ”-ийг үзүүлэв

Бүх хятадууд намхан болж

Бүсэлхийнээс дээш өндийхгүй жоролзоно

Бүрэнхий тэнгэрийн өсгий гижигдсэн

Бүдэгхэн аялгуу хөгжимд гиншинэ

Торгоны хээ шиг гуа эмс

Тойвтой нь аргагүй ойрхон гишиглэнэ

Тогоруун цамнаат бүжиг бүжин

Тогостой дэвүүрээр нүдээ нууж айлгүйтнэ

Ямар гээчий нь мэдэхийн аргагүй

Мөчирт болгоны жимс зураглан өрж

Яст мэлхийн дуулга хөвүүлсэн

Цэгээн шөл “тураглан” таваглав

Муу санаа мэт газар дор иссэн

Мунхагыг үүдэгч галзуу дарс

Гангар жүнз халиан сөгнөж

Гары нь амраахгүй шавдан барина

Монгол ноёд хоймор хаяалж

Морьтой ухааны ир хянгалж

Мөндрийн төвөргөөтэй үг ханзалж

Малгай засан жудаг хатуулна

Улаа бутарч, дуу гаарч

Уусан сархад шидийг талбиж

Бэлтэй эрээн найр хавтгайрч

Битүү сартай шөнөд золгов

Мөлүү хэлтэй өвгөн түшмэл

-Хааны болгоосон эрхэм үгийг

Халхын ноёдод уламжилъя! хэмээв

Алдар сүр, хэргэмийн өмнө

Атгахан болдог хятад зан

Анир даран аядах атал

Архины дуулиан адган шоволзоно.

Учиргүй шуугиан захаасаа хумигдаж

Улсын эзний зард ханъя гэлээ ч

Цуутай дарсанд хараа солбисон нүдээ

Цуглуулах гэж ядсан толгойнууд донжигноно

Омог төгөлдөр монгол ноёдын

Сүрийг улам бадаргуулсан

Оройн дээд отго жинсний

“Сүлд” чулуу өргөхөөр тогтчихв оо

Эрхэмсэг ноёд та бүгдээр

Эзэн хааны эрдэнэсийн санд морилж

Толгой дээрээ асаах чулуу шилэхдээ

Товлоно уу? Хэмээн эзэн хаан болгоов...

Үүдэн зүг алгаа дэлгэн

Үгээ дуусгаад гурвантаа бөхөлзөв.

Үймсэн гайхсан шагшаан дунд

Үгүй мөн азаа! гэсэн үг товолзоно

-Суудал хөнгөдөх вий хэмээн

Сур мэт болгоомж чивчирээн

Суутай дээдсийн ухааныг богшоож

Сулхан нь аргагүй тонгойсхийв

Өгсөн юмны гашуун хариу

Өдөр сардаа заавал эргэж

Өгөхгүй болгоныг шалж мэднэ

Өрөнд нь амь ч нэхэж мэднэ

Адуу тонгочсон, эртний тал

Алтаар жирэмсэлсэн газар шороо

Ар монголоо өгчих!...

Авья! ч гэж хэлж мэднэ

Солгой гараар чимхэж өгч

Баруун гараар ухаж авдаг нь

Сүн, Хан, Мин улсын үед ч

Байж л байсан сайвар сүүдэр

Далд санааны гүн цүнхээлд

Далавчаа хумин мөргөж унах

Эгээрэл үгүй тэнэг ноёд гэж

Эндүүрээгүй байгаа эзэн хаантан гэж

Дэрийж боссон илдтэй ааг

Дээлтэй гал монгол ноёд

Тал үүл хоёрыг хэлхэн бодож

Там диваажин хоёрыг залган болгоов

Шатрын нүүдэл шиг бодол өрсөлдөж

Шаазан жингэнэсэн зоог өндөрлөв

Шалж уулгасан дарс татарч

Шуугиан “босч” найр гадаалав

Хормой ороосон салхи шиг

Хорь гучин хятад бөмбөрч

“Хүнд” зочдоо хөвөөлөн хашиж

Хаан сангийн хаалга бараалав

Хатавчинд нь алтан арслан “архирсан”

Халтар дааман нүргэлэн онгойж

Итгэл хүлээсэн хятад монгол ноёдыг

Идэж байх шиг залгин барайв

Хаагуур нь орж гардгийн битүү оньсого

Хаалга хаалган завсар илдтэй хүн

Анихаа мартсан нүдтэй байгаа нь

Австай “босоо” шарил шиг харагдана

Эвшээж байгаа шүдгүй ам шиг

Эцсийн бололтой тоногт хаалга

Эрдэнэсийн сангийн торгон хальс

Эгшиг шаргисан олон хонхтой

Үүднээс нь эхлээд хөглөрсөн эрдэнэс

Үеийг элээсэн өлөн тоостой

Хормойн салхинд үргэн пургиж

Хоолой хорсгож хамар гижигдэнэ

Энд тэнд ассан дэнлүүний гэрэлд

Эрдэнэсийн өнгө улам галзуурч

Эрэлхүү хурц “гэрлийн” дуугаар

Элдэв өнгөөр хашгичин оодорно

Чухаг эрдэнэ хэмээн өөрийгөө магтаж

Чулууны хэлээр орлилдох нь

Чухамдаа ганцхан би... гэж

Чулуу чулуугаа муулах мэт

Сайрхуу хятад сая гэдийж

Санаа алдан, уулга нисгэн

-Эрдэнэс... эрдэнэсийн дээд...

Энэ юу ч биш зах зух нь...

Ясны хөөрөл нь түймэрлэн асаж

Ядуу хүн харвал нүд нь сохорно

Авах л чулуугаа заа! Атгаар нь өгнө

Аа хариу бол яахаа!?

Хясал хүсэлд биеэ зүйж

Хятад хүн амиа дүйж цуглуулсан эрдэнэс

Хаяа нийлж суух хойно

Хай бололгүй яахав, хамаагүй ав! гэвэй

Харсан болгондоо нүд унагаж

Халцагатай! гэтлээ шуналд шатахыг

Хазгайд тооцдог монгол ноёд

Хайнгадуухан харж хямсайн зогсоно

Өгхөд яарч байгаа мэтэд хятад хүн

Өнгөн дээрээ харагдахыг хичээвч

Авахад яарсан дотор санаа

Араас булгалзан сүүдэртэй нь хэрэлдэнэ

Гэгээн монгол ноёдын нэг нь гэнэт

-Гэрлээ бөхөөчих! харья! бид

Харанхуйд гэрэлтэх эрдэнийн чулуу

Халхын ноёдын толгой дээр асах учиртай гэхүй

Харанхуйг далимлах бий... гэсэн шүү

Хар буусан хятад үгэнд хахаж

-Хашир байх гэнэн байхаас

Хуруу дээр гэж хятад хүн ярьдаг

Хамаг гэрлээ, унтрааж дуусахад

Хагссан хаалганы завсраар харвасан

Хутганы ир шиг гэрлээс өөр

Харагдах зураа үгүй болов

Харагдах гялайх юмгүй түнэрт

Хаана нь буй, хог, эрдэнэс хоёр...

Балар харанхуй дунд үг хөдөлгөөн түгдэрч

Балмагдсан амьсгаа хааяа бүдэгхэн сонсогдоно

-Санаан зоргоор байлгасанд

Сайд ноёдод гялайлаа... гэрлээ асаа!

Сэрэлзэн асах гэрэлтэй зэрэгцэн

Сэжгийг нь үргээх гэсэн мэтэд

Мохоох ухааны хавыг үзүүлж

Монгол ноёд урт ханцуйгаа унагав

-Эрхмүүд минь бид чадлын хэрээр

Эрдэнэсийн чулуунуудыг тааллаа

Харанхуйд гэрэлтэх эрдэнийн чулуу

Хааны санд байгааг бидний мэтэд

Нүгэл байгаа даа! гэлээ ч олж харсангүй

Нүдний минь буруу боллоо

Хатан цагаан сарны гэрэл долоосон

Харгил хөх усан илж угаасан

Халуун наран цонож, хат суулгасан нутгийнхаа чулууг

Халхын ноёд толгой дээрээ асаахаас... гэж

Халуун инээд нүүр лүү нь цацан

Халбагар ханцуй огшоон мэхийв

Хургаж нэгэнтээ эргэж ч харалгүй

Хойно хойноосоо намиран алхацгаав

-Монгол хүнийг хуурна гэдэг

“Модон хутгаар үс авах шиг хэцүү” гэж

Хаан сангийн эрдэнэсийн зузаан хаалга

Хяхран үглэх шиг удаан хаагдав

-Сүүгээр битүүрсэн зулай дээрээ

Хүний нутгийн чулуу асаавал

Сүлд хийморь гудайна гэж

Монгол ноёд урт амьсгаа авав.

1994.

Гашуун таталбар

/”Жинчин” эссе/

Шөнөжин ягьдаг нохой

Бөглүү цагаан үүл толгод ажин түжин. Чимээ авиа нь бүгд цасанд дарагдсаных. Хааяа бараалах өвөлжөөний хөлөөс хотны нохой пүн пүн хийтэл хуцах дуулдана.

Ирж яваа алив нэгнийг мэдсэний төлөө, эзнээ сонор соргог байгтун хэмээн мэдээлсэн хоёр талын ашигтай мэдрэмж бүхий хуцалт болно. Зарим айлын хотонд “хээрийн боохойд” ч юм уу, саранд ч юм уу шөнөжин завсаргүй ягьж хонох нохой байна. Эзнээ дөжиртөл эцэст нь залхтал хуцна. Сонор сэрэмжийг саармаг жуулан хавь ойроо элийртэл хуцна. Хуцан хуцсаар эзнийхээ тэнэг итгэлийг булааж алмайруулж чадсаны эцэст гарзны үүдийг нээж өгнө. Чонын үйл ажиллагаа нохсын завсар чөлөөгүй хуцалтын “симфони” найрлын дэвсгэр дээр ёслол төгөлдөр болж өнгөрнө.

Нохой хуцаад л байхад аваад одсон чоно буруутай болж нохой хариуцлагатай байсанд тооцогдон өдөржин нар даган унтаж эзэндээ “өрөвдүүлнэ”. Цөөн хуцдаг, цагаа олж хуцдаг нохой хөл хүзүү шархтай, шархаа долоож хэвтэнэ. Их хуцдаг нохой, бие султайг нь далимдуулан бага хуцдаг нохойны хоолыг булааж аагирхана. Танай энэ муу нохой худлаа ягиад...гэж хааяа нэг хүн хэлэх нь тааралдана. Тэр үгэнд эзэн тавгүйцэж хотын хүний авчирч өгсөн шил юмаа, нохойг нь муулсан хүнээс нууж хүртэнэ. Шөнөжин ягих нохойгоо үнэнч шударгын дээдэд тооцож, нэгдэлд ажиллаж байхдаа шагнуулсан хөдөлмөрийн хүндэт медалиа хүзүүвчинд нь зүүж өгнө. Худлаа хуцдаг нь бус дандаа хуцдагтаа үнэлэгдсэн нохойн толгой ягнагар сүүл саадаглаастай.

Шөнөжин худлаа ягьдаг “таалалт” нохой нэгэн өдөр хүн тавьдаг хондноос үхсэн хүний толгой зууж ирж, хотоо түйвээжээ. Айл хотлынхон сэжиглэн нүдэж балбаж хөөж туусны эцэст “ягиур нохой” холоо очиж хэвтэн хөтөл хэжин, цав цагаан цасан дээр хар цэг мэт торойсоор харагддаг болов.

Тэгж явахдаа шөнөжин ягихаа больсон нь алдар хүнд түүнд хэрэггүй болсны гэрч мэт байсаар нэгэнтээ бараа туруугүй алга болов. Хожим эзэн нь халамцуу дурсахдаа -Сайн нохой байсан юм. Намайг л хоёр толгойтой болгох гэсэн байх, ухаантай амьтан болохоороо ...гэхэд гэрийн эзэгтэй сэжиглэн залбирч ...Хош гэм. Үхсэн амьд хоёр толгой нэг мөрөн дээр багтдаггүй юм. Дуугүй наад архиа гудар гэж зандрав.

Тамын хавтгай зураг

Монголын нэрт бурханч Бизъяагийн аймгийн Шарав гэвш диваажинд очжээ. Насаараа бурхан зурсан буянтан очилгүй ч яахав.

Бурханы томилолтоор тамд очиж нэгэн их хавтгай зургийг бүтээж диваажиндаа буцжээ. Тэр зурагт өнөөгийн нүсэр их хотын агаар мандал мэт их утаан дунд үйлдвэрийн яндан шиг гозгор гозгор юу нь харагдахгүй гал утаан дунд тамыг дүрсэлжээ.

Тэнд Ансельм /Кентерберийн хамба/ ном бариастай хөлдчихсөн, “Бурхан байсаар байхад бузар хаанаас ирэв, Бурхан байхад, ариун нь бас хаана байна” гэж үглэнэ. Эпиктет цаана нь дэмий л ярвайж зогсоно. Грасиан Бальтасарын гурвалжин малгай дээр гал асан дүрэлзэнэ. Тэр тамд ч ассаар л аж. Вовенарг аархуу зантай хэвээрээ Локк-г муу хэлж зогсоно. Өвгөн Марксын утаатай хар сахал бавгнан, элэрч одсон өвөг Фордуудын гутлыг “Капитал”-аар тосолж сууна.

Гитлер гиюүрэн хашгичиж, Геббельсийг дуудаж явна. Рейхийн “төмөр рыцарууд” тамын үүдээр хөлхөлдөнө. Тэд нүгэлтнээс бас тамыг харамлана бололтой. Сайн танихаас Ленин буйдхан харанхуй буланд толгойдоо үс ургуулах тос түрхэж сууна.

Нэлээд орны цагаатгалын комиссынхон тамын үүд рүү орж чадахгүй овооролдон уурлан багтарч ядахдаа тамыг иж бүрнээр нь цагаатгав хэмээн бичиг үйлдэж буцацгааж харагдав.

Өлзийтэй ёо... ёо...

Хүн тээврийн унаа хөл тавих зайгүй. Нас өтөлсний учир хөл дээрээ зогсох битгий хэл, хонгон дээрээ суухад ядардаг болчихож...

Залуучууд голдуу суусан суудлын хажууд очиж “ёо ёо” хичнээн хэлэвч нэмэр болсонгүй, хэн ч надад суудал тавьж өгч гийгүүлсэнгүй. Миний түнш нэг өвгөн өлзийтэй “ёо ёо”-г зааж өгсөн юм. Энэ нээлт надад нэг их тус болсонгүйд харамсах сэтгэл төрөв. Эд нар надаас олон жил энэ суудалд сууна даа. Бид чинь удахгүй л “жам” руу одоцгооно хэмээн гомдох шиг санагдаад явчихав. Эгнээ болгоны хажууд ёолсоор бараг л буух хаалган дээр ирэв. Нэг мэдэхнээ би жолоочийн хажууд ирчихсэн ёолж байв. Чи чинь өтөлж чадахгүй, жолоочийн суудал хүртэл булаалдах нь гэж өөрөөсөө ичив.

Давилуун сэтгэлээ мэдрэх тэнхээтэй байгаагаа мэдэrmэгцээ өөртөө бас баярлав. Хүн тээврийн унаанаас намайг буухад багананд наасан сонгуулийн үеийн сурталчилгааны нэгэн хүний зурагтай хуудсыг овилгогүй хаврын салхи урж, салхинд дэрвэсэн цаас-таныг аварна, таныг аварна гэж түй...түй... гэх шиг тачигнаж байв.

Мэдэгдэхгүй аялгуу

Манай хажуу талын дэлгүүрийн үүдэнд “гармони” хөгжим барьсан хараагүй хүн сууна. Үргэлж хөгжимдөн дуулна. Өмнө нь амыг нь дэлгэсэн цүнх харах тоолон юм хайрла гэж хэлж байх шиг санагдана. Өвлийн хүйтэн өдөр ч өдөржин дуулна. Оройхон тийшээ ямар аялгуу, ямар дуу болох нь ч мэдэгдэхгүй нэгэн зүйлийн гиншилт болж хувирна. Тэр хавиар явах хүмүүсийн нүд чих дасаж өрөвдөх битгий хэл харахаа байх бололтой. Түүнийг тэр даанч эс мэдрэн дуулсаар сууна.

Нүдээ халхалсан шил нь цантаж, бээрсэн хуруу нь ертөнцийн аз жаргалын ганцхан эгшгийг эрэх мэт тэмтчинэ. Тэр хулжсан аялгуу хаанаас амархан олдох аж даа.

Овоо хэдэн задгай төгрөг цүнхэнд нь орохын алдад тэнэмэл хүүхдүүд ганцхан шур гээд л шүүрээд алга болно. Алдчихсан хойноо л сая цунхнийхээ амыг тэмтчин хаана. Бүхий л өдрийн дуулж хөгжимдсөний нь үнэ тэр болно. Ядаж яваагаа, ядарч яваа нь хүртэл хайрлахгүй ямар гээчийн цаг үе вэ ч гэж бодогдоно. Энийг ч мартъя. Бүүр их сэтгэлийн тэнхээ гаргаж мартъя гэж бодъё. Нэлээд дэгжин хоёр залуу дэргэдүүр нь өнгөрөх гэснээ азнаан хоёр халааснаасаа баахан хог цаас, голоор нь хуваасан сурагч дэвтэр гаргаж ирснээ базан цүнх рүү нь сар хийтэл шидээд бахтай инээлдэн одоход өнөөх хөөрхий хараагүй хөгжимчин дуулж байсан дуугаа тасдан ... миний хүүхдүүд урт наслаарай! гэж хойноос нь чанга гэгч нь багтаж ядталаа баярлан хэлж билээ.

Аниргүй

Уул уулынхаа хормойг даран, дотогшоо амьсгална. Салхи уснаас гүйдлээ харамлан дуугаа хураажээ. Нуур чимээгүй ... анир анираа залгина.

Би аниргүйд автагдан чимээ, хөдөлгөөн хоёроо цагдуулна. Аниргүй намайг залгилсаар ...

Мичид гуу мөргөж, намрын шөнийн үүр эмээлийн урд бүүргэн дээр цайлаа. Гэгээ аниргүй гэтнэ, адууны зогсоол дунд эхийнхээ бөөрийг түшин зогсоо

унтсан нялх унага, нойрны халуундаа подхийн уналаа... Унуутаа цочин сэрсэн унаганы дор урд хөлөө бохирсон хээр азарганы дэл дэвсээтэй байлаа.

Цочсон гэгээ үүрийн улаан шуурга талд асгарав. Аниргүйн цэлдэн хөх нам гүм унаган туурайд өртөн ханзрав. Унага улаан талыг жийж дахин тэнцлээ.

1986.9.16

Хос эссе

1. Хумсын чинээхэн нар

Өвөөгийн цээж давхаргагүй гэрт хүн ярих шиг дүнгэнэнэ. Хумсын чинээхэн нар тоононы дааганаас мултарч ядна. Өвөө тэр холоос сульдсан зүрхнээсээ дуугарна.

-Хүү адуугаа олоо болуу? адуу тургилахыг сонсох юмсан... гээд хэлсэн хэдэн үгэндээ хахах мэт дуугүй болов.

Ашгүй уяан дээр дөрөө дуугарч адуу гүнгэнэн үүрсэв. Өвөө бүтээсэн өрх шиг хүнд зовхио дааж ядан нээж

-Хүү ирэв үү? Адуугаа олоо болуу? гэх нь түрийчийнхээс тод дуулдав. Гарч хараагүй байж би...

-Тийм байнаа. Ах ирж байна. Адуугаа олчихож...гэж санаандгүй цээжний бангаар хэлчихлээ...

Өвөө-Өө ашгүй дээ гээд гүнгий амьсгал татлаа... Сумын эмч орж ирүүтээ баруун хатавчинд цагаан нөмрөгөө өмсч гарлаа... Хумсын чинээхэн нар тоонон дааганаас нисэв.

2. Алчуур зангидсан хуур

Өвөө өөд болоод сар гаруй боллоо. Гэрийн хойморт залсан хуурны ногоон халзан морин толгойг эгчийн алчуураар боогоод бас л сар гаруй боллоо. Говьчуул хуурын нүдэнд гуниг унагахгүй гэж ингэж гашууддаг заншилтай. Долоон долоо дөчин ес хоног болно.

Нэг өглөө зүүн хамар дээгүүр улаан тугтай машин гарч ирлээ. Манай гадаа тоосоор тургин зогсуут хэдэн хүн бууж ирлээ... Цай цүү болсноо дараа нь том сийрсэн малгайтай, нүдний тас хар шилтэй ах надад, -За хүү дэгдчих, Урлагийн бригад ирлээ гээд айл саахалтынхнаа хөөгөөд ир гэлээ... Орж ирснээсээ хойш туж л нүүр нүдээ будсан гоё эгч нөгөө сийрсэн малгайтай ахад хандаж, -Найруулагчаа Би ямар дуугаа дуулах юм бэ? гэж зузаан уруулаа бөмбөлзүүлэн дуугарав. Нөгөө өндөр ах, -Өө ашгүй хууртай айл байна... гэснээ ухасхийн хоймор байсан хуурийг шүүрэн авах зуураа –Бас алчуур боочихсон нандин эд байхнээ... гээд алчуурыг нь хуу татахад, хуурын ногоон халзан морин толгойн том аягатай нүд нулимстэй харагдав.

1986.09.20

Үлгэр

Үлгэр гэж байгаагүй үед нэгэн хаан байжээ. Боол хамжлагуудынхаа дундаас цэцэн гэгдсэн тэнэгүүд, холыг хардаг гасангуудаа дуудан

-Би хэд наслах нь вэ? гэж асуудаг байж... Мэргэдүүд - Еэ дээ Удахгүй л болуу гэж хэлсний төлөө, бараг болох үнэний төлөө толгойгоо өгдөг заншил улиглажээ.

Хүний толгой өнхрөхийн тоолон хаан өлмийд нь өнхрөх толгойг харахын тулд амьд байдаг болж... Нэгэн мэргэн түшмэл, мэргэд шувтрахын даваан дээр иржээ. Хааныг,

-Би хэд наслах нь вэ? гэж асууж байхад гадаа нь хааны алуурчид сэлмээ ирлэж байсан биз.

-Ээ гэгээн хаантан минь. Та урт наслах нь, тэр ч атугай төрсөн хүүгээсээ ч урт наслах нь ... гэж хэлэхэд хааны магнайд баяр мандаж,

-Энийг битгий цаазла гэж хашгирчээ.

1987.11.19

Table of Contents

[Солонго билээ... би...](#)
[Монголын их хээр тал](#)
[Чамаараа би зөндөөн гоёсон](#)
[Эдлэн](#)
[Эх орон бид хоёр бие биендээ ирсэн](#)
[Өнжүүлийн хөх өвгөд](#)
[Ижийтэйгээ байхад...](#)
[Тэр өдөр](#)
[Чиний гар](#)
[Хагацахуй](#)
[Хан мөрөн](#)
[Сонет](#)
[“Нэхэл” төөрөг](#)
[Хил дээр бичсэн шүлэг](#)
[“Хүрээ” зураг](#)
[Харанхуй буюу сохор хүний яриа](#)
[Надад бага нас байгаагүй](#)
[Миний голын тохой](#)
[Чинийхээ дэргэд өтөллөө би . . .](#)
[Харанхуй](#)
[Дуртгалын гэрч](#)
[Улхын цагаан дэрс](#)
[Этюд](#)
[Сүү савируулсан бодол](#)
[Илдийг цагаатгахуй](#)
[Хар сүлд](#)
[Багын шүлэг](#)
[Хайр](#)
[Хүүдээ бичсэн шүлэг](#)
[Хатан цэцэг](#)
[Ханиа л дагаж жаргана](#)
[Учир нурших шүлэг](#)
[Амирлангуй](#)
[Хоргодохын шүлэг](#)
[Аргаа барсан шүлэг](#)
[Миний зай](#)
[Хатан Бөзөнхийн гол](#)
[Хайрын хийморь](#)
[Чамайг би дурсана](#)
[Хань](#)
19991213

[Хүргэж өгөхийн шүлэг](#)
[Зуны өдөр урт](#)
[Шөнө дунд адуу тургилав](#)
[Олох гээхийн шүлэг](#)
[Намрын салхи](#)
[Хээр талын намар](#)
[Өнжүүлийн уулс](#)
[Нам гүм](#)
[Сэрүүн зүүд](#)
[Зүүдний ад](#)
[Ганц ангир](#)
[Зэрэглээ](#)
[Тоглоом буюу үхлийн Рапсоди](#)
[Гэрэл сүүдэр хоёрын яриа](#)
[Үхсэн амьд хоёрын яриа](#)
[Хэлтгий Нанзад](#)
[Домбон ёотон](#)
[Зургийн шувуу](#)
[Орон зай](#)
[Хайрын сүнс](#)
[Буутын ус](#)
[“Үр” могой](#)
[Өлөгчин чоно](#)
[Морин сувд](#)
[Цэргийн хар](#)
[Цагаан согоо](#)
[Сорвитой бурхан](#)
[Эрхэмсэг дууль](#)
[Гацуун таталбар](#)
[Тамын хавтгай зураг](#)
[Өлзийтэй ёо... ёо...](#)
[Мэдэгдэхгүй аялгуу](#)
[Аниргүй](#)
[Хос эссе](#)
[Үлгэр](#)